

ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ПРАКТИК

ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ГЭХ ОЙЛГОЛТЫН
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

ИЛТ ХУДАЛ ГҮЖИРДЛЭГ
TWITTER MAL-INFORMATION
НИЙГМИЙН СҮЛЖЭЭ
ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ
ГҮТГЭЛЭГ

ИЛТ ХУДАЛ ГҮЖИРДЛЭГ
ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ

INSTAGRAM
НЭР ТӨР,
АЛДАР ХҮНД
MISINFORMATION
ХУУРАМЧ МЭДЭЭЛЭЛ
FACEBOOK ТАРААХ
ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ
DISINFORMATION

YOUTUBE
ХУУРАМЧ
МЭДЭЭЛЭЛ



НЭЭЛТГЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГААНЫ
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ

ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ПРАКТИК

ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ГЭХ ОЙЛГОЛТЫН
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

Улаанбаатар хот
2021

ННА 67.408
ДАА 345
Х-666



ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ПРАКТИК

ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ГЭХ ОЙЛГОЛТЫН
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн:

Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэгийн судлаач,
МУИС-ийн докторант, хуульч Д.Оросоо
Хууль зүйн ухааны доктор Ц.Цэлмэг
Судлаач С.Дэнсмаа, Г.Туул

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9812-0-4

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс нь НҮБ-ын гишүүн орны хувьд хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр тодорхой үүрэг амлалтыг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө авсан билээ. Энэ үүрэг амлалтаа биелүүлэхээр багагүй хүчин чармайлт тавьж байгаа ч тодорхой эрхийн зөрчлийг таслан зогсоох чиглэлээр НҮБ-ын хүний эрхийн механизмаас цөөнгүй зөвлөмж авсны нэг нь “гүтгэх”, “доромжлох” гэмт хэргийг Эрүүгийн хуулиас халах тухай билээ. Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2015 оны Эрүүгийн хуулиас тус гэмт хэргийг халж, Зөрчлийн тухай хуульд “гүтгэх” зөрчлийг тусгаж хоёр жил гаруй явсан ч мөн л хүний эрхийн үүднээс багагүй шүүмжлэлд өртөж, 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Зөрчлийн хуулиас тус заалтыг хасаж, Эрүүгийн хуульд “Худал мэдээлэл тараах” гэсэн гэмт хэргийг шинээр томъёолж оруулсан билээ.

Аливаа ардчилсан улсын хувьд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөө нь амин чухал асуудал тул Эрүүгийн хуулийн тус заалтын хэрэгжилтийг гүнзгийрүүлэн судалж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох нь зүйтэй гэж үзэж судалгааг Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг төрийн бус байгууллагаар хийлгэлээ. Судалгааны хүрээнд худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик, үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөөний зарчимд нийцэж буй эсэх, худал мэдээлэл тараах гэмт хэргийн “илт худал мэдээлэл” гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал, худал мэдээлэл тараах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, субъектив санаа зорилго, төсөөтэй эрх зүйн бусад зөрчлөөс ялган зүйлчлэх асуудал, ижил төстэй эрх зүйн тогтолцоотой зарим улсын эрх зүйн зохицуулалт, үндэсний болон олон улсын жишиг хэргүүдийг судалж, дүгнэлт хийсэн болно. Үүний зэрэгцээ судалгааны урьдчилсан дүнг энэ асуудлаар мэргэшсэн экспертийн хүрээнд хэлэлцүүлж, гол үр дүнг хураангуйлан хавсаргалаа.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд эдүгээ 30 орчим судалгаа олны хүртээл болоод байна. Мөн бид дээрх судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, бодлого шийдвэрт тусгуулах зорилгоор цуврал хэлэлцүүлэг эхлүүлээд байгаа бөгөөд хэлэлцүүлгийн видео бичлэгийг манай байгууллагын цахим хуудас, нийгмийн сүлжээнээс олж үзэх боломжтойг дуулгахад таатай байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал
П. Эрдэнэжаргал

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт	6
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГАЧЛАЛ	7
1.1. Судалгааны үндэслэл, шаардлага	7
1.2. Судалгааны ажлын зорилго, хамрах хүрээ	8
1.3. Арга зүй, судалгааны баг	9
БҮЛЭГ 2. ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ПРАКТИК	11
2.1. Худал мэдээлэл, түүний цар хүрээ	11
2.2. Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал	15
2.3. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн практик, шүүхийн шийдвэрийн шинжилгээ	39
2.3.1. Эрүүгийн хуулийн хэрэглээ ба худал мэдээлэл	39
2.3.2. Зөрчлийн тухай хуулийн хэрэглээ ба худал мэдээлэл	44
2.3.3. Иргэний хуулийн хэрэглээ ба худал мэдээлэл	48
2.4. Гадаадын зарим улсын зохицуулалт	49
2.5. Үг хэлэх эрхийн олон улсын жишиг, стандарт	53
ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ	58
НОМ ЗҮЙ	67
ХАВСРАЛТ	
Хавсралт 1. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дэлгэрэнгүй шинжилгээ	68
Хавсралт 2. “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал” сэдэвт экспертүүдийн уулзалтын тэмдэглэл	95

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их хурал
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭХАШШ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЭХЕА	Эрүүгийн хуулийн ерөнхий анги
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГАЧЛАЛ

1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 онд батлагдсанаас хойш Улсын Их Хурал (УИХ)-аар зарим нэмэлт, өөрчлөлт оруулан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс даган мөрдөх болж үүнээс хойш даруй дөрвөн жил өнгөрч байна.

Манай улсад 2020 онд 20 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, 228.4 тэрбум төгрөгийн хохирол учруулсан 13 мянга гаруй хэргийг шүүхээр шийдвэрлэсэн нь өмнөх оны шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн хохирлоос даруй тав дахин өссөн үзүүлэлт ажээ. Учирсан хохирлын нөхөн төлөлт 2020 онд 13 хувьтай байгаа нь өмнөх оны нөхөн төлөлтөөс 56 пунктээр буурсан үзүүлэлт юм¹.

График 1. 2020 онд бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг





График 2. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ (тэрбум төг.)



2017 оны 7 дугаар сарын 1-нээс гүтгэх болон худал мэдээлэл тараах үйлдлийг Монгол Улсад гэмт хэрэгт тооцохгүй болж Зөрчлийн тухай хуулиар шийтгэх болсон. Үүнээс хойш энэ төрлийн зөрчил 2017 онд 28, 2018 онд 486, 2019 онд 355 бүртгэгдсэнээс 2017 онд дөрвөн сэтгүүлч, 2018 онд 17 сэтгүүлч, нэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 2019 онд дөрвөн

¹ Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn

сэтгүүлч, нэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл тус бүр дээрх зөрчлийн улмаас торгуулах шийтгэл хүлээжээ.²

Худал мэдээлэл тараах, гүтгэх гэмт хэргийг онолын түвшинд судалсан магистр, докторын судалгааны ажил харьцангуй цөөн, ялангуяа 2015 оны Эрүүгийн хууль, 2017 оны Зөрчлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаас хойш энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн, шүүхийн практикийг судалсан томоохон судалгааны ажил байхгүй байгааг дурдах нь зүйтэй.

Тиймээс Эрүүгийн хуульд заасан Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик, уг хэргийн илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал, худал мэдээлэл болон үг хэлэх эрхийн хоорондын харилцан хамаарал, гадаадын зарим улс орон, олон улсын жишиг, туршлага, уг гэмт хэргийн статистик тоо баримтыг судалж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үндэслэл бүхий санал, зөвлөмж боловсруулахыг зорилоо.

1.2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик, худал мэдээлэл тараах гэмт хэргийн илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал, энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, субъектив санаа зорилго, төсөөтэй эрх зүйн бусад зөрчлөөс ялган зүйлчлэх асуудлыг авч үзлээ. Түүнчлэн дээрх асуудлууд болон үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөөний зарчим, хэрэг шийдвэрлэх ажиллагааны зөрчил, эрх зүйн асуудлыг шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар хуулийг нэг мөр хэрэглэх, Эрүүгийн хуулийн холбогдох заалт хийдэлтэй байгаа бол залруулах чиглэлээр санал, зөвлөмж дэвшүүлэхийг зорилоо.

Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, худал мэдээлэл, гүтгэлэгтэй холбоотой маргаан, эрх зүй, онолын асуудал болон үг хэлэх эрхийн хүрээнд гарсан гадаадын зарим улс орон, олон улсын жишиг, туршлагыг судлан дүгнэж санал, зөвлөмж боловсруулав.

² Глоб интернетейшнл төв, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан, 2020.

Судалгаанд ашигласан шүүхийн шийдвэрүүдийг <https://shuukh.mn> вэб хуудаснаас, мөн судалгаанд ач холбогдол бүхий хэргийн материал, шүүхийн шийдвэр, зөрчлийн хэргийн зарим материал, баримтыг хэргийн оролцогчдоос гаргуулан авч, тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, практикийг судлан дүн шинжилгээ хийн, онолын болон хууль хэрэглээний асуудлыг нэгтгэн судалж дүгнэлт хийлээ.

Судалгааны ажлын хүрээнд:

1. Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад дүн шинжилгээ хийж, хууль тогтоогчийн анх дэвшүүлсэн ойлголт, асуудлыг шинжлэн судлав.
2. Худал мэдээлэл, түүний цар хүрээ, төрөл, хэлбэр, агуулгын асуудлыг шинжлэн, гадаадын зарим улс орны Эрүүгийн хуулийн зохицуулалтыг харьцуулан судаллаа.
3. Илт худал мэдээлэл гэх хууль зүйн ойлголтын агуулга, худал мэдээлэл тараах үйлдлийн гэм буруугийн асуудлыг шинжлэн судлав.
4. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, Иргэний болон Зөрчлийн хуулиудын холбогдох зүйл, заалттай харьцуулан шинжиллээ.
5. Үг хэлэх эрх, худал мэдээллийн эрх зүйн асуудалтай холбоотой олон улсын жишиг, стандартыг судлах ажлын хүрээнд олон улсад жишиг болсон шүүхийн шийдвэрүүдийг харьцуулан судлав.

1.3. АРГА ЗҮЙ, СУДАЛГААНЫ БАГ

Судалж буй асуудлын онцлогоос хамаарч судалгаа нь ерөнхийдөө тоон болон чанарын судалгааны аргад тулгуурласан болно. Судалгааны ажлыг (i) судалгааны баримт сэлт, мэдээлэл, эх сурвалж цуглуулах; (ii) дүн шинжилгээ хийх гэсэн үндсэн хоёр үе шаттайгаар явууллаа. Энэхүү судалгаанд цогц байдлаар хандах болон чиг хандлагын шинжилгээний арга зүйг баримталсан бөгөөд судалгааны асуудалд нөлөөлж болох олон

хүчин зүйлийн харилцан үйлчлэлийг бүхэлд нь авч үзэхийг зорилоо. Гүтгэх, худал мэдээлэлтэй холбоотой харилцааг Эрүүгийн хуулиар өмнө нь хэрхэн зохицуулж байсан, өнөөдөр ямар байдлаар зохицуулах болсон, түүний үр дагавар, нөлөө, цаашдын чиг хандлага, өөрчлөлтийн талаар дүн шинжилгээ хийлээ.

Мэдээлэл цуглуулахдаа ярилцлага, хэлэлцүүлэг (чөлөөт ба албан хэлбэрээр, бүлгийн буюу хуульчдын хэлэлцүүлэг), ажиглалт, баримт бичиг цуглуулах аргыг ашиглав. Түүнчлэн баримт бичиг, тоон мэдээнд шинжилгээ хийх, кейс шинжилгээ, харьцуулан шинжлэх аргыг ашигласан.

Худал мэдээлэл тараах гэмт хэргийн шүүхийн шийдвэрлэлт, практикийг авч үзэхдээ аливаа иргэний бодож санасан зүйлээ чөлөөтэй хэлэх эрх, түүний зарчим болон бусдыг гүтгэх, доромжлох, худал мэдээлэл тараах үйлдлийг харьцуулан шинжлэх зэрэг асуудалд төвлөрч анализ хийлээ.

СУДАЛГААНЫ БАГ

Судалгааны ажлыг Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэгийн судлаач, МУИС-ийн докторант, хуульч Д.Оросоо, Хууль зүйн ухааны доктор Ц.Цэлмэг, судлаач С.Дэнсмаа, Г.Туул нар хамтран гүйцэтгэв.

БҮЛЭГ 2. ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ПРАКТИК

2.1. ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ ЦАР ХҮРЭЭ

Хуурамч мэдээлэл нь улс төрийг гажуудуулан, будилаан тарьж, ардчилсан институцид итгэх итгэлийг бууруулж, иргэний нийгэмд эргэлзүүлэн, мэдээллийн эмх замбараагүй байдалд хүргэж байна. Тухайлбал, 2018 онд Мьянмарын арми хоморголон устгах явдалд хүмүүсийг турхирахдаа Фейсбүүкийг ашигласан бол 2018 онд Эболагийн халдварын үеэр Эбола вирусийг Засгийн газрын лабораторид үйлдвэрлэсэн гэх худал мэдээллийн улмаас Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь Эбола вирусийн үнэлгээний төв рүү халдсан билээ. Мөн 5G цамхгууд COVID-19 үүсгэдэг вирус тараахад нөлөөлдөг гэх цахим зурвасын улмаас Их Британид 2020 оны дөрөв, тавдугаар сард харилцаа холбооны компаниудын хэдэн арван инженер халдлага, дарамт, хүчирхийлэл, доромжлолд өртөж, гар утасны 90 цамхгийг шатаажээ. Эдгээр нь худал мэдээллийн сурталчилгаа, түүний үр дагаврын талаар саяхан тохиолдсон гурван жишээ юм.³

Хуурамч мэдээлэл гэдэг бол хууран мэхлэхийн тулд хуурамчаар, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх, түгээх явдал билээ (Rychlak & Расера, 2013). Орчин үед олон нийтийн сүлжээ өргөн дэлгэрснээр ямар ч хүн мэдээлэл түгээх, хуваалцах, дамжуулах боломжтой болсон. Нэг талаас мэдээллийн асар их урсгал бий болж, хүссэн эх сурвалжаа сонгох, олон эх сурвалжаас мэдээлэл авах боломж нэмэгдсэн ч нөгөө талаас хүмүүсийг төөрөгдүүлсэн, сэтгэлийн хөдөлгөөн айдас түгшүүр төрүүлсэн, өдөөн турхирсан мэдээлэл түгж байна. Энэ нь гол төлөв иргэд бие биеэ үзэн ядах, айх, сэжиглэх зэрэг буруу үйлдэлд чиглүүлсэн мэдээлэл байдаг.⁴

³ <https://www.icnl.org/wp-content/uploads/2021.03-Disinformation-Policy-Prospectus-final.pdf>

⁴ МУИС, Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг, УБ., 2020, 731 дэх тал.

Зохион байгуулалттайгаар мэдээллийг гуйвуулж, тодорхой арга технологи ашиглан олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал, алдаатай мэдээлэл тараах, дамжуулах асуудал нь зөвхөн хувь хүний гаргах алдаа, үйлдэл биш бөгөөд үүнд улс орнууд, Засгийн газар, улс төрч, улс төрийн нам, эвсэл, гэмт хэрэгтэн, компани, залилан мэхлэгч, эдийн засаг, улс төрийн бүлэглэл, хэвлэл мэдээлэл, олон улсын үндэстэн дамнасан корпорац гээд нийгмийн бүхий л хүрээллийнхэн санаатай болон санамсаргүй байдлаар оролцож байдаг “нийтийн талбар” гэж дүгнэж болно. Энэ нь зөвхөн орчин үед гарч ирсэн асуудал биш, аль ч үед байсан нийгмийн сөрөг үзэгдэл юм.

ЗХУ-ын эхэн үед 1920-иод оны дундуур В.И.Сталин тагнуулын байгууллагын хүрээнд олон нийтийн санаа бодлыг өөрчлөх, төөрөгдүүлэхийн тулд хуурамч мэдээлэл түгээх аргыг ашиглаж байжээ. Мөн өнгөрсөн нийгмийн үед коммунист орнууд хөгжингүй капиталист орнууд, тэр дундаа АНУ-ын талаар хуурамч, ташаа мэдээллийг дотооддоо зориудаар түгээдэг байсан. Мөн 1986 онд Рейганы засаг захиргаа Ливийн удирдагч агсан Муаммар Гаддафигийн эсрэг хуурамч мэдээ гаргаж байв. Харин 1990-ээд оноос АНУ-ын улс төрд нэлээд хэрэглэгдэх болжээ. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс Европын Холбооноос гарах эсэх тухай ард түмний санал асуулгад хуурамч мэдээлэл маш хүчтэй нөлөө үзүүлснийг судлаачид цохон тэмдэглэдэг.⁵

Худал мэдээлэл цар тахал мэт хурдан тархаж, олон нийтийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд худал мэдээлэл тархсан тохиолдолд түүнийг залруулах, арилгах, няцаах болон худал мэдээллийн эсрэг бодит үнэн мэдээлэл түгээх нь нэн төвөгтэй. Худал мэдээлэл ардчилсан тогтолцоонд аюул занал учруулж, нийгмийг эмх замбараагүй байдалд өдөөн турхирах явдал цөөнгүй гарах боллоо. Өнөөдөр баталгаатай, үнэн зөв мэдээллийн хэмжээ, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ардчилсан улс орнууд гадаад болон дотоодын гарал үүсэлтэй худал мэдээлэлтэй тэмцэх, түүнээс хамгаалах асуудалд ихээхэн анхаарал хандуулах болсон.

⁵ МУИС, Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг, УБ., 2020, 730 дахь тал.

“Guardian”-ийн тоймч Натали Нугайред “Суртал ухуулгыг эрт дээр үеэс ашиглаж ирсэн боловч ийм шуурхай түгээх технологи өмнө нь байгаагүй юм” хэмээн дүгнэжээ.⁶

Философич, нейробиологич Сэм Харрис “Худал хэлэх нь замбараагүй байдалд хөтлөх дардан зам мөн. Худал хэлнэ гэдэг бол үнэнч харилцаа хүсэн хүлээж байгаа бусдыг зориудаар төөрөгдүүлэх үйлдэл юм. Хүмүүс ямар нэг зүйлийн талаар үнэнд нийцэхгүй итгэл үнэмшил бусдад төрүүлэхийн тулд л худал хэлдэг. Үнэнч зан бол бусадтай хуваалцаж буй бэлэг юм. Мөн энэ нь хүч чадлын, агуу эгэл жирийн байдлын эх үүсвэр юм. Худал нь бусад олон худлыг араасаа дагуулдаг. Үнэн баримтууд биднээс нэмэлт хүчин чармайлт огт шаарддаггүй. Худал хэлэх нь бараг бусадтай хамтрахаас татгалзах гэсэн үг. Худал хэлснээр бид бусдад хорвоог байгаагаар нь харахад саад болж байгаа юм”⁷ гэжээ.

Харин МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор М.Зулькафиль “Төрийн шууд мэдэлд байгаа цөөхөн хэвлэл бий. Бусад нь чөлөөт хэвлэл. Гэхдээ наанаа чөлөөт хэвлэл гэж ярьдаг боловч цаанаа бүгд улс төр, бизнесийн том бүлэглэлд харьяалалтай болсон байдаг. Үүнээс болоод мэдээллийн тэнцвэрт байдал алдагдаж байгаа юм. Үзэл бодлоо бичихэд тухайн сонин санхүүжүүлэгч эзнийхээ захиалга, заавраар бичиж байна. Сониноор л жишээ авсан болохоос биш Монголд үйл ажиллагаа явуулж буй телевиз, сайт бүгд адилхан. Ардаа санхүүжүүлэгчтэй. Нэг бизнесмен юм уу, улс төрчийн гарт олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл байх нь энгийн үзэгдэл болсон. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэн нэгний эрх мэдэлд очих нь цаад утгаараа эрх чөлөөг боомилж буй хэрэг. Эзэмшилгүй болох гэхээр зах зээл нь жижиг учраас дампуурах аюулд орно. Тэгэхээр дампуурахгүйн тулд хэн нэгний эзэмшилд очих, хаалтын гэрээ хийх гэх мэт арга хэлбэрийг сонгож байгаа нь нийгэмтэйгээ л холбоотой. Цахим хэвлэлийн эрх зүйн зохицуулалт маш чухал болсон. Цахим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүнийг гүтгэн доромжлох, нэр хүндэд халдах зэрэг нь энүүхэнд. Нэг хүний захиалгаар нөгөөхийг гүтгэж, түүнийгээ сайтаасаа авхуулах хүсэлт гаргахаар өмнөөс нь мөнгө нэхдэг. Нэг ёсондоо цахим сэтгүүлзүйг мөнгө олох хэрэгсэл гэж боддог

⁶ <https://www.icnl.org/wp-content/uploads/2021.03-Disinformation-Policy-Prospectus-final.pdf>

⁷ Сэм Харрис, Худал, УБ., 2017.

болчихсон юм шиг. Сайтууд ихэвчлэн бусдыг дарамтлах, шантаажлах замаар оршин тогтнож байна. Тэгэхээр үүнийг зохицуулсан хуультай болох хэрэгтэй. Гэвч болгоомжтой хандах нь зүйн хэрэг. Түүнээс биш хүнийг гүтгэн доромжилж, түүгээрээ шантаажлан мөнгө авч байгаа бол энэ сэтгүүл зүй биш, дээрэм, гэмт хэрэг юм. Хэвлэлийн эрх чөлөө нэрээр халхавч хийж хэн нэгнийг гүтгэн доромжилж, дээрэмдэж болохгүй шүү дээ. Ийм эрх чөлөө Монголд хэрэггүй. Уг нь сэтгүүлчид чинь оюуны талх үйлдвэрлэгчид”⁸ гэсэн байна.

Хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан “Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16-д иргэн бүр итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй гэж заасан. Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхүүд заримдаа мөргөлддөг. Нэг талаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалсан ч нөгөө талаараа хүний нэр төр, алдар хүндийг хамгаалсан хоёр заалт Үндсэн хуульд бий. Иймд үзэл бодлоо илэрхийлж байна гээд хүнийг гүтгэж болохгүй. Гүтгэлгийг хориглож байгаа боловч гүтгэсэн тохиолдлыг шийдэхдээ улс орон бүр ялгаатай. Худал мэдээлэл тараахыг гүтгэлэг гэдэг бөгөөд үүнийг гэмт хэрэгт тооцож, торгох, баривчлах, хорих ялаар шийтгэх зохицуулалт үйлчилж байгаа. Мэдээж гүтгэлгийг хорих, хүний алдар хүндийг хамгаалах ёстой ч заавал Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцох ёсгүй. Хэвлэлийн эрх чөлөө бол ардчиллын амин сүнс. Авлига, албан тушаал, ашиг сонирхлын зөрчил, эрх мэдлээ урвуулан ашигласан, бизнесийн хууль бус практик зэрэг иргэдийн эрх, нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх нь хэвлэл мэдээллийн үүрэг. Гүтгэлэг, доромжлолыг гэмт хэрэгт тооцсоноор олон нийтэд дээр дурдсан мэдээллийг хүргэх энэ урсгалыг зогсоох эрсдэл үүсдэг. Тиймээс нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэд мэдээлэлгүй үлдэх, аливаа ажиллагааны хууль ёсны эсвэл ёс зүйтэй эсэхийг мэдэх эрхгүй болж байгаа юм”⁹ гэж байр сууриа илэрхийлжээ.

⁸ М.Зулькафиль, Монголын хэвлэл мэдээллийн салбарт тулгарч буй гол асуудал бол эзэмшил, <https://ikon.mn/1a3s>, 2018.5.2.

⁹ <https://news.mn/r/764348/>

2.2. ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ГЭХ ОЙЛГОЛТЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг УИХ-аас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлтээр оруулсан. Худал мэдээлэл тараах гэмт хэрэг, уг гэмт хэргийн үндсэн ухагдахуун болох “илт худал мэдээлэл” гэх ойлголтыг шинжлэн судлах ажлын хүрээнд Засгийн газраас 2019 онд Эрүүгийн хуульд уг зүйлийг нэмэлтээр оруулахаар өргөн мэдүүлсэн хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, хэлэлцүүлгийн тэмдэглэл, хуулийн төсөлтэй танилцаж, хууль санаачлагч, хууль тогтоогчийн анхны хүсэл зориг, байр суурийг шинжлэн судаллаа.

Засгийн газраас хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Эрүүгийн багц хуулийн төслийг 2019 онд УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

Уг төслийн танилцуулга, үзэл баримтлалд “Монгол Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 34 дүгээр тогтоолын Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Зөрчлийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталсантай холбогдуулан хууль хоорондын давхардал, зөрчлийг арилгах үүднээс холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгажээ. Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1-д “Тогтвортой, хариуцлагатай улс төрийн соёлыг төлөвшүүлж, хүчтэй, чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх зарчмыг баримтална” гэж, 5.3-т “Хууль заавал хэрэгждэг, хүн бүрд эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн, хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална” гэж, 5.1.3-т “Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж буй бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ” гэж, 5.2.11-д “Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах...” гэж,

5.4.1-д “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлнэ” гэж тус тус дурджээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударгаар шүүлгэх хүний эрхийг хангах асуудлыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн тусгасан. Өнгөрсөн хугацаанд уг хуулийг хэрэгжүүлж ажиллах явцад холбогдох байгууллагууд болон иргэдээс гаргасан санал, хүсэлтээс үзэхэд тус хуульд заасан зарим асуудлыг тодруулах, нарийвчлах хэрэгцээ байна. Нөгөө талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг УИХ-аар батлах явцад эхний хэлэлцүүлгээр дэмжигдэж, хуулийн төсөлд тусгагдсан санал, эцсийн хэлэлцүүлгээр дэмжигдэхгүй батлагдсаны улмаас хуульд үүссэн хийдэл, давхардлыг арилгах, мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өөрчлөн тусгагдсан заалтад нийцүүлэх шаардлага байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн хууль өөрөө цаг үе, нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, аливаа зөрчил, давхардал, хийдэлгүй байх нийтлэг зарчимд тулгуурлан Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль тогтоомжийг нэг мөр ойлгох, хууль ёсны зарчимд илүү нийцүүлэх, практикт хэрэгжихүйц байх нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай; Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагаж гарах бусад хуулийн төслийг боловсруулж, дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар тусгажээ. Зарим төрлийн гэмт хэрэг тухайлбал, биеэ үнэлэхийг зохион байгуулах, бэлгийн дарамт учруулах, гүтгэх, мөрийтэй тоглоом зохион байгуулахыг шинээр гэмт хэрэгт тооцож, зарим гэмт хэргийн шинжийг ерөнхий ангид заасан нэр томъёотой нийцүүлсэн байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу дээр дурдсан хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах бөгөөд мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасны дагуу

хуульд шинээр зүйл, хэсэг, заалт оруулах, өөрчлөх, хүчингүй болсонд тооцох зэргээр нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна. Хуулийн төсөлд дээр дурдсан практик хэрэгцээ шаардлагад үндэслэн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

Эрүүгийн хуульд:

1. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг зөрчлийн хугацаа тоолох зохицуулалттай уялдуулах, улмаар зарим гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг боловсронгуй болгох;
2. Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалтыг хууль ёс, тэгш эрхийн зарчимд нийцүүлэх;
3. Зарим төрлийн гэмт хэрэг тухайлбал, биеэ үнэлэхийг зохион байгуулах, бэлгийн дарамт учруулах, гүтгэх, мөрийтэй тоглоом зохион байгуулах зэрэг гэмт хэргийг тусгах, зарим гэмт хэргийн шинжийг ерөнхий ангид заасан нэр томъёотой нийцүүлэх гэж тусгасан байна” гэжээ. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “Гүтгэх” гэмт хэргийг дор дурдсан байдлаар тодорхойлж өргөн мэдүүлсэн байна.

13.14 дүгээр зүйл. Гүтгэх

1. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн **нэр хүндэд халдаж илт худал мэдээллийг нийтийн сүлжээгээр тараасан** бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
2. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн **нэр хүндэд халдаж илт худал мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан** бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Тайлбар:

- Энэ гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллага хамаарахгүй.
- Үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийг гэмт хэрэгт хардсан, сэрдсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.

УИХ-ын нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгээр дээрх зүйл ажлын хэсгээс гаргасан саналаар дараах байдлаар өөрчлөн батлагджээ.

13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах

1. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн **нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан** бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Анх өргөн мэдүүлсэн төслийн “гүтгэх” гэснийг “худал мэдээлэл тараах” гэж өөрчлөн, “...хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдаж илт худал мэдээллийг нийтийн сүлжээгээр тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах” гэж ялгамжтай авч үзсэн байсныг нэгтгэн уг гэмт хэргийг “олон нийтэд тараасан бол” хэмээн объектив талын шинжээр нь тодорхойлж, субъектив талын шинжийг бүрхэгдүүлсэн (уг гэмт хэргийн объектив, субъектив шинжийг тэнцвэргүй тодорхойлсон), худал мэдээлэл нь “гутаасан, гутаах” агуулга, шинжтэй байх эсэхийг бүрэн тодорхойлоогүй, “халдсан” гэсэн хэт ерөнхий нэр томъёог хэрэглэсэн явдал нь хууль бүтээх ажиллагааны алдаа болж хууль хэрэглээ, шүүхийн практикт сөрөг үр дагавар үүсгэж буй гол шалтгаан болсон гэж үзэх үндэстэй юм. Хууль тогтоогч хууль зүйн техникийн шаардлагатай агуулгыг бүрэн бүрдүүлэх шаардлага, дүрмийг зөрчиж, эрх зүйн хийдэл гаргажээ. Хууль бүтээх ажиллагааны алдаа гэдгийг “В.М.Баранов нь хууль бүтээх ажиллагааны нийгэм ба хууль зүйн тааламжгүй үр дүнг үүсгэсэн алдааг хууль тогтоох байгууллагын шударга төөрөгдлийн улмаас хийсэн буруу үйлдэл гэж тодорхойлсон. А.Б.Лисюткин хууль тогтоох ажиллагааны алдааны тухай ойлголтыг арай өргөнөөр тайлбарласан. Тэрээр хууль тогтоох ажиллагааны алдаа гэдэг нь эрх зүйн хэм хэмжээ бүтээх субьектийн урьдчилан төлөвлөсөн болон урьдчилан төлөвлөөгүй үйлдлээр нөхцөлдсөн өндөр чанартай эрх зүйн акт батлах, үр нөлөөтэй ажилд саад тотгор болсон сөрөг үр дагавар юм”¹⁰ гэжээ.

Мөн уг зүйлийн тайлбар болох “Энэ гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллага хамаарахгүй. Үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийг гэмт хэрэгт хардсан, сэрдсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй” гэснийг хассан байна. Уг тайлбарыг хэлэлцүүлгийн явцад хассан явдал нь мөн хууль зүйн техникийг бүрэн бүрдүүлэх шаардлагыг алдагдуулан, хуулийн төсөлд анх тусгагдсан томъёолол нь хэлэлцүүлгийн явцад дэмжигдэхгүй хасагдаж батлагдсаны улмаас эрх зүйн хийдэл, давхардал үүсгэж, үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн байдлыг дордуулах үндэс болсон байна.

¹⁰ Т.В.Кашанина, Хууль зүйн техник, УБ., 2016, 137 дахь тал.

Худал мэдээлэлтэй холбоотой хууль зүйн нэр томьёо, ойлголтыг тодорхойлох явцад гарч буй нийтлэг алдаа, дутагдлыг АНУ-д төвтэй Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төвөөс (*International Center for Not for Profit law*) судлан анхааруулж, зөвлөмж гаргасан. Улс орнуудын цахим гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, эрүүгийн хуулиудад цахим үгийн төрлийг тухайлбал, хуурамч мэдээллийг эрүүгийн гэмт хэрэгт тооцсон нь түгээмэл байгаа боловч хэтэрхий өргөн хүрээнд, бүрхэг ойлгомжгүй нэр томьёо ашиглах тохиолдол байна. Энэ нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 19 дүгээр зүйлд үл нийцэх бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж байгааг хүлээн зөвшөөрөмгүй байгаа юм. Зохиомол мэдээллийн эсрэг хуулиуд хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд үр дүнтэй биш байгаа нь батлагдсан хэдий ч хууль зүйн шинэчлэл нь зайлшгүй шийдлийн нэг мөн билээ. Нөгөө талаас нийгмийн мэдээллийн сүлжээ болон интернэтийн бусад компани олон нийтийн тусын тулд үйл ажиллагаа явуулж байгаагүй бөгөөд одоо ч явуулахгүй нь тодорхой байх тул эрх зүйн зохицуулалт шаардлагатай. Шийдвэрлэх гол асуудал бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой олон улсын стандартад бүрэн нийцсэн хуулийн шийдлийг томьёолоход оршино. Хуурамч, алдаатай, буруу сэдэлтэй мэдээллийн тархалтыг хязгаарлахад төрийн зохицуулалт хэрэгтэй боловч төр үнэнийг дэнслэгч байх ёсгүй. Иргэд үнэн, худал мэдээллийн аль алинд нэвтрэх боломжтой бөгөөд харин тухайн мэдээллийн үнэн зөвийг үнэлэх бололцоо бүрдсэн байх нь чухал байна. Үүнийг хэрэгжүүлэхэд гаргаж буй зохицуулалт нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөө, хувийн нууцын талаарх олон улсын хэм хэмжээнд нийцсэн байвал зохино.¹¹

Дээрх байдлаас дүгнэхэд хууль тогтоогч Эрүүгийн хуульд байсан “гүтгэх” гэмт хэргийн ойлголтоос өргөн хүрээг хамрах “худал мэдээлэл тараах” гэсэн объектив талын шинжээр тодорхойлогдох, шинэ хэв шинж бүхий гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгажээ. Харин эрүүгийн хариуцлагын хувьд хорихоос өөр төрлийн ял шийтгэхээр тогтоосон нь өмнөх Эрүүгийн хуулиудаас онцлогтой болсон байна.

¹¹ <https://www.icnl.org/wp-content/uploads/2021.03-Disinformation-Policy-Prospectus-final.pdf>

Доромжлох, гүтгэх гэмт хэргийг Эрүүгийн хуулиас халахыг НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбарт зөвлөсөн. Түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2015 онд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлэг явуулах үед найман улс “нэр төр гутаахтай холбоотой заалтыг Эрүүгийн хуулиас халах”-ыг Монгол Улсад зөвлөсөн¹² байгааг анхаарах шаардлагатай.

Доктор О.Мөнхсайхан “Эрүүгийн хуулиар эсхүл Зөрчлийн тухай хуулиар доромжлол, гүтгэлгийг гэмт хэрэгт тооцож шийтгэх зохицуулалт нь үндсэн эрхийг хязгаарлахад тавигдах дээрх зургаан гол нөхцөлийн нэг болох тохирсон (зайлшгүй) байх зарчмыг зөрчдөг учраас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчдөг”¹³ хэмээн байр сууриа илэрхийлжээ. Мөн Жон Стюарт Милль “Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нухчин дарахын онцгой хор уршиг нь хүн төрөлхтнийг тэр чигээр нь дээрэмдэхтэй адил юм. Өөрөөр хэлбэл, төөрөгдлийнхөө учрыг олох явцад үнэн зөвийг илүү тодорхой олж харах, мэдрэх боломжийг нь алдагдуулдаг байна”¹⁴ гэж хэлжээ.

Судалгааны ажлын зорилгын хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд Худал мэдээлэл тараах гэмт хэргийн “илт худал мэдээлэл” гэсэн ойлголтыг тодруулахын тулд 1986, 2002, 2015 оны Эрүүгийн хуульд заасан “гүтгэх”, “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн зүйл, заалт, түүний объектив, субъектив талын шинж байдлыг харьцуулан шинжлэв.

Монгол Улсын 1986 оны Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлд заасан Гүтгэх гэмт хэргийг “Бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тараасан бол” ял шийтгэхээр, 2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд заасан Гүтгэх гэмт хэргийг “Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол” гэмт хэрэгт тооцож ял шийтгэхээр тус тус зүйлчилжээ.

¹² Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2016, 59 дэх тал.

¹³ О.Мөнхсайхан, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь, Эрх зүй сэтгүүл, №2, 2017, 30 дахь тал.

¹⁴ Жон Стюарт Милль, Эрх чөлөөний тухай, УБ., 2021, 40 дэх тал.

*Хүснэгт 1. Гүтгэх, худал мэдээлэл тараах
гэмт хэргийн зүйл, заалтын харьцуулалт*

№	Эрүүгийн хууль, зүйл, нэр	Агуулга
1.	1986 он, 117 дугаар зүйл. Гүтгэх	Бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тараасан бол
2.	2002 он, 111 дүгээр зүйл. Гүтгэх	Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол
3.	2015 он, 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах	Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол

Монгол хэлний их тайлбар толь бичигт “мэдээлэл” гэдгийг 1. Ямар нэгэн үйл хэргийн тухай амаар болон бичгээр дэлгэрэнгүй мэдээлэх явц, мэдээ дамжуулах, түгээх нь: мэдээлэл хийх (мэдээ гаргах, олон түмэнд сонгох), мэдээллийн сан (мэдээ мэдээллийн хуримтлал), хэвлэлийн мэдээлэл (хэвлэлийн газраас гаргасан нийтэд түгээх мэдээ бичиг), хэвлэл мэдээлэл [хоршоо] (хэвлэн мэдээлэх хэрэгсэл), мэдээ мэдээлэл [хоршоо] (олон түмэнд хүргэх, сонгох үйл хэргийн товч, тойм), мэдээлэл зүй (аливаа мэдээллийг хүлээн авах, боловсруулан гаргах салбар ухаан) гэжээ.¹⁵

Эрх зүйн эх толь бичигт мэдээлэл гэдэгт этгээд, эд зүйл, үйл баримт, үйл явдал, үзэгдэл ба үйл явцын тухай тэдгээрийн хэлбэрээс үл шалтгаалах мэдээ сэлтийг¹⁶ ойлгоно, Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичигт мэдээлэл гэж (латин. *informatio*; англ. *information*) толилуулсан хэлбэрээс үл шалтгаалах мэдээ сэлт (мэдээ, тоо баримт)¹⁷ гэжээ.

¹⁵ <https://mongoltoli.mn>

¹⁶ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ., 2008, 285 дахь тал.

¹⁷ С.Нарангэрэл, Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, УБ., 2021, 252 дахь тал.

Нэрт эрдэмтэн Б.Чимэд, С.Нарангэрэл гэх зэрэг хуульчид *информация (information)* гэдэг үгийг “мэдээлэл”, *данные (data)* гэдэг үгийг “баримт сэлт, мэдээлэл”, *сведения* гэдэг үгийг “мэдээ”, *сообщение* гэдэг үгийг “мэдээ, мэдээлэл” гэж тус тус тайлбарлах буюу орчуулжээ. Оросын мэргэжилтнүүдийн тайлбарласнаар *данные (data)* хэмээх үгийн агуулга нь факт буюу үйл баримтаас үндэслэлтэй. Жишээлбэл, статистикийн мэдээ баримт, аж ахуйн нэгжийн мэдээ (*сведения*) гэх мэт. *Информация (information)* гэдэг үг нь янз бүрийн мэдээ баримт (*данные/data*)-аас сонгон боловсруулж задлан шинжилж гарган авсан, тэдгээрийн нийлбэр цогцсыг илэрхийлдэг байна. К.Шеноны мэдээллийн онолын сонгодог тодорхойлолтоор *информация (information)* гэдэг үг нь авагдахаас өмнөх үеийн тодорхой бус байдлыг бүрэн буюу аль нэг хэмжээгээр багасгаж байдаг мэдээ баримт, өгөгдөл, мэдээнүүдийн цогц нийлбэр ажээ. Энэ бүхэнд тулгуурлаад бид *информация (information)* гэдэг үгийг “мэдээлэл”, *данные (data)* гэдэг үгийг “мэдээ баримт, өгөгдөхүүн, өгөгдөл”, *сведения, сообщение* хэмээх үгсийг “мэдээ” гэж тус тус орчуулан дээр дурдсан утгаар хэрэглэж хэвших, хууль эрх зүйн орчинд оруулж хэрэглэхийг санал болгож болохоор байна.¹⁸

Худал гэдгийг:

- худал үг (бодит байдлыг гуйвуулсан үг);
- худал хэлэх (бодит байдлыг зориуд гуйвуулан хэлэх);
- худал яриа (хуудуутай, үнэн бус яриа);
- худал ярих (худал хэлэх);
- худал ташаа [хоршоо үг] (үнэн биш, хуурмаг);
- худал хуурамч [хоршоо үг] (үнэн биш, хуурмаг);
- худал хуумгай [хоршоо үг] (лавтай үнэнийг мэдэж хянахгүй, хааш яаш хэлж, хийх байдал)¹⁹ гэж тайлбарлажээ.

¹⁸ Ц.Ган-Оч, Б.Доньжчимбуу, Мэдээллийн эрх зүй, УБ., 2019, 34-35 дахь тал.

¹⁹ <https://mongoltoli.mn>

Гүжирдлэг гэдгийг:

- Гүтгэх явдал, гүтгэлэг: оргүй гүжирдлэг (оргүй гүтгэлэг), үндэслэлгүй гүжирдлэг (үндэсгүй гүтгэлэг), худал гүжирдлэг (худал гүтгэлэг)²⁰ гэжээ.
- оргүй гүжирдлэг - оргүй гүтгэлэг
- үндэслэлгүй гүжирдлэг - үндэсгүй гүтгэлэг
- худал гүжирдлэг - худал гүтгэлэг

Илт гэдгийг:

- ил бүхий, юмны тодорхой, нууц биш;
- илт аюул тохиолдох (зайлшгүй аюул тохиолдох);
- илт мэдэх (илэрхий мэдэх, мэдэж буй нь тодорхой байх);
- илт үнэн (а. Лавтай үнэн; б. Тооны ухаанд магадлах шаардлагагүй ил тоо, байрыг нь соливч эцсийн дүн нь хувьсахгүй тоо)²¹ гэж тайлбарлажээ.

Илтэд гэдгийг:

- ил тодорхой, илэрхий болох байдал;
- илтэд амжилт олох (харагдахуйц илэрхий амжилт олох);
- илтэд зөв хэлэх (гарцаагүй зөв хэлэх);
- илтэд мэдэгдэх (тодорхой мэдэгдэх);
- илтэд хулгай (дээрэм тонуул) гэжээ.²²

БНМАУ-ын 1986 оны Эрүүгийн хууль, Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуульд Гүтгэх гэмт хэргийн объектив талыг “илт худал гүжирдлэг” тараах гэж, субъектив талыг бусдын нэр төрийг гутаах зорилгоор шууд санаатай тарааж буй хэлбэрээр тодорхойлж ирсэн

²⁰ мөн тэнд.

²¹ <https://mongoltoli.mn>

²² мөн тэнд.

байдаг. Илт худал гүжирдлэг гэдэг бол хүний нэр төр, алдар хүндийг гутаасан шинжтэй, бодит байдалд огт нийцээгүй, ор үндэслэлгүй, худал мэдээлэл гэж ойлгож иржээ.

БНМАУ-ын 1986 оны Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлд заасан гүтгэх гэмт хэргийн талаар Эрүүгийн хуулийн онолын тайлбарт:²³

1. Гүтгэх гэж бусдын нэр алдрыг гутаахаар зориуд худал, хуурамч мэдээ тараахыг хэлнэ. Объектив талын шинж нь бусдын нэр хүндийг гутаасан худал, зохиомол мэдээ сэлт тараах идэвхтэй үйл ажиллагаагаар илэрнэ. Тараах гэдэг нь худал хуурамч мэдээ сэлтийг ямар нэг аргаар нэг буюу хэд хэдэн хүнд мэдээлэхийг хэлнэ. Мэдээ сэлтийг хиймлээр зохиох гэдэг нь амьдралд үнэн хэрэгтээ байхгүй зүйлийн талаар худал хуурмаг зүйл зохиох явдал юм.
2. Бусдын нэр хүндийг гутааж бузарласан өөрөөр хэлбэл, орчин тойрных нь хүмүүсийн дунд хүний нэр хүндийг унагах, хохирогчийг ёс суртахуунд харш юм хийсэн юм шиг бусад хүмүүст итгэл төрүүлсэн мэдээ сэлт тараах нь гүтгэх гэмт хэргийн нэг ноцтой шинж мөн. Бусдын нэр хүндийг гутаасан мэдээ сэлтийг ямар нэг хэлбэрээр тараасан бол түүнийг гүтгэлгийн төгссөн гэмт хэрэгт тооцно. Харин хэн нэгний нэр алдрыг гутаасан шинжтэй боловч үнэн бодит мэдээ сэлт тараах нь гүтгэлгийн гэмт хэрэг болохгүй.
3. Энэ гэмт хэргийн субъектив тал нь шууд санаатай хэлбэрээр илэрнэ. Гэм буруутай этгээд бусдын нэр алдрыг гутаасан худал хуурамч мэдээ сэлт тарааж байгаагаа ухамсарлаж, түүнийг хүсэж үйлддэг байна. Сэдэлт нь өш хонзон, хардлага, атаа жөтөөний аль нэг байх бөгөөд ял оногдуулахад ач холбогдолтой юм гэжээ.

2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд заасан гүтгэх гэмт хэргийн талаар Улсын дээд шүүх, Ханнс-Зайделийн сангаас хамтран гаргасан Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбарт:

²³ БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 1989.

1. Энэ хэргийн шууд объект нь хүний нэр төр, алдар хүнд байна.
2. Энэ гэмт хэргийн объектив тал нь хохирогчийн нэр төр, алдар хүндийг гутаасан, муучилсан, худал мэдээлэл тараасан үйлдэл байна. Уг үйлдэл нь амаар, бичгээр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон элдэв дуу, дүрс бичлэгийн хэлбэрээр илэрч болно. Гүтгэлгийг хэнд тараасан тухайлбал, ойр тойрны хүмүүс, танилууд, хөндлөнгийн этгээдэд мэдээлсэн зэргийн аль нь болох нь хэргийн бүрдэлд онцын нөлөөлөхгүй бөгөөд бусдад тарааснаар төгссөн гэмт хэрэг болно.
3. Гүтгэх гэдэг нь бодит байдалд нийцээгүй, илт худал мэдээлэл, гүжирдлэгийг бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор тараасан үйлдэл юм. “Гутаах” гэдэг нь уг хүний нийгэмд үнэлэгдэх зүй ёсны бодит үнэлгээг муутган, гажуудуулсан ойлголт тараахад чиглэсэн үйлдэл байна. Ингэхдээ субъект уг мэдээллийг өөрөө зохиосон эсхүл бусдаас санаа авсны аль нь болох нь энэ хэргийн бүрдэлд нөлөөгүй. Гагцхүү уг мэдээлэл илт худал гэдгийг ухамсарлаж мэдсээр байж тараасан байдаг онцлогтой.
4. Тарааж буй мэдээ нь худал боловч уг хүний нийгэмд үнэлэгдэх чанарыг дордуулаагүй, харин ч хоосон магтаалын шинжтэй болсон бол гүтгэлэг гэж үзэхгүй. Учир нь энэ тохиолдолд тухайн үйлдэл нь хүний нэр төр, алдар хүндийг гутаасан шинж байхгүй. Тухайн тараасан мэдээ нь хүний нэр төр, алдар хүндийг гутаахаар боловч бодит байдалд тухайн хүний зан төлөв, үйл ажиллагаанд илэрсэн зүйл байсан бол гүтгэлэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй.
5. Энэ гэмт хэргийн субъектив тал нь бусдын нэр төр, алдар хүндийг гутаах гэсэн гэм буруугийн шууд санаатай, хэлбэртэй байдаг. Сэдэл нь өс хонзон санах, үзэн ядах, өрсөлдөөн, сөргөлдөөн, атаархал гэх мэт янз бүрийн байж болно. Гэхдээ бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой байдаг.
6. Гүтгэлгийг бодит байдалд андуу ташаа, алдаатай дүгнэлт хийснээс болж тараасан бол энэ зүйлд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, бусад хууль тогтоомжид тухайлан заасан

байвал тэр төрлийн хариуцлага хүлээлгэж, хохирогчоос уучлалт хүсэхийг үүрэг болгож болох юм²⁴ гэжээ.

Монгол Улсын дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 40 тоот тогтоолоор²⁵ Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлийн зарим заалтыг тайлбарласан бөгөөд уг тогтоолд “... худал гүжирдлэг ...” гэдэгт илт худал мэдээлэл, баримт сэлтийг ойлгоно гэжээ. Монгол Улсын эрүүгийн эрх зүйд “илт худал гүжирдлэг” гэдэг ойлголт нь “илт худал мэдээлэл” гэсэн агуулгыг давхар агуулж байна.

Улсын дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 14 тоот тогтоолд “Хүндээр доромжлох” гэж хүмүүсийн хоорондын харилцааны нийгэмд тогтсон болон ёс суртахууны шаардлагын хэм хэмжээ, үндэсний зан заншил, уламжлалд харшилсан, тухайн хүний нэр төр, алдар хүндийг ичгүүр сонжуургүйгээр гутаасан үйлдлийг хэлнэ. Энэ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрүүл мэнд, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан зэргээр илэрнэ гэж тайлбарлажээ.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан Худал мэдээлэл тараах гэмт хэргийн “илт худал мэдээлэл” гэх ойлголтыг Улсын дээд шүүхийн 2007 оны 40 тоот тогтоолыг үндэс болгож “илт худал мэдээлэл” гэдэгт “илт худал гүжирдлэг”, “гүтгэх”, “гүжирдэх” гэсэн хууль зүйн ойлголт онолын хувьд багтаж байна.

2002 оны Эрүүгийн хуулиар “гүтгэх” гэж “хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор” илт худал гүжирдлэг тараасан бол гэмт хэрэгт тооцохоор заасан байсан.

<p>2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйл. Гүтгэх</p>	<p>Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол</p>
--	---

²⁴ УДШ, Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010, 304-305 дахь тал.

²⁵ Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхэтгэл (1959-2010), УБ., 2015, 840 дэх тал.

Харин 2015 оны Эрүүгийн хуулиар субъектив тал (гутаах санаа зорилго) бүрхэг болж, “хүний нэр төр, алдар хүндэд халдсан” илт худал мэдээллийг тараасан бол “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна. Үүнд:

<p>2015 оны Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах</p>	<p>Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол</p>
---	---

Хүний нэр төр, алдар хүндэд “халдах”, “халдсан” гэдэг нь хэт ерөнхий ойлголт бөгөөд санаатай халдах үйлдлээс гадна санамсаргүй, болгоомжгүй, хайхрамжгүй байдлаар хүний нэр төр, алдар хүндэд халдсан, мөн тухайн хүний нэр төр, алдар хүнд хөндөгдсөн, дурдагдсан байж болно. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 1-д “Энэ хуульд заасан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцно”, 2.3-т “Гэм буруу нь санаатай эсхүл болгоомжгүй хэлбэртэй байна” гэж заасан. Онолын хувьд худал мэдээлэл тараах үйлдэл нь санаатай үйлдэх гэмт хэрэгт хамаарч байгаа боловч хүний нэр төр, алдар хүндийг гутаах санаа зорилгогүй, худал мэдээлэл тараасан үйлдэл ч уг зүйлээр эрүүгийн хариуцлагад татагдаж болох эмзэг байдалтай болжээ. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч илт худал мэдээлэл тарааж, хүний нэр төрд халдсан этгээдийн субъектив санаа зорилгод ач холбогдол өгөлгүй орхигдуулж, харин нэр төрд халдсан, тараасан буюу объектив талын шинжээр нь гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан явдал нь ухралт болжээ. Субъектив талын хувьд гэмт этгээд бусдын нэр төр, алдар хүндэд хохирол учруулах гэсэн шууд санаатай үйлдлээр илрэх ёстой боловч сэдэл болон санаа зорилгыг хууль тогтоогч заагаагүй тул заавал шаардах нөхцөл биш юм.

Гэм буруу нь субъектийн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив шинжүүдэд (үйлдэл, эс үйлдэхүй, хор уршиг) хандаж буй сэтгэхүйн харьцааг илэрхийлэх сэтгэл зүйн элементүүдийн цогц бүрдэл юм.²⁶

²⁶ Монгол Улсын Дээд Шүүх, Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010, 87 дахь тал.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн зургаадугаар зүйлд Шударга ёсны зарчмыг заасан бөгөөд энэ зарчим нь Эрүүгийн хуулийн шударга байдал, шүүгдэгчид оногдуулж буй ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ оновчтой шударга байхын бодит илэрхийлэл юм. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хуульд хүн, нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, ашиг сонирхолд хохирол учруулахуйц аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцсон, хэм хэмжээ нь нийгэм, эдийн засаг, эрх зүйн (криминологи) хувьд хангалттай үндэслэлтэй, нийгмийн шударга ёсны шаардлагад бүрэн нийцсэн байвал сая шударга сайн хууль болно. Амьдралын бодит шаардлагад нийцээгүй эрүүгийн хууль нь нийгмийн эрх зүйн ухамсрын тусгал болохгүй, тэдний ашиг сонирхлыг хамгаалж чадахгүйд хүрнэ.²⁷

Гэмт хэргийн субъектив тал нь гэмт хэргийн дотоод агуулгыг илэрхийлнэ.²⁸ Мэдээллийн олон талт харилцаанд оролцож буй өнөөгийн нөхцөл байдал, мэдээллийг хурдтай дамжуулж, түгээж буй технологи, түүний хөгжил, өөрчлөлтийн бодит хандлагыг хүлээн зөвшөөрч, цаг үетэйгээ нийцсэн хууль батлах шаардлагатай байна.

Илт худал мэдээлэл гэдэг ойлголт нь тодорхой, ойлгомжтой байх асуудал бөгөөд харин уг илт худал мэдээллийг ямар санаа, зорилгоор тарааж байгаа нь худал мэдээлэл тараах үйлдлийг гэмт хэрэгт тооцох эсэхэд ач холбогдолтой. Иймд Эрүүгийн хуулийн “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн бүрэлдэхүүнд субъектив шинжийг илэрхийлэх хэлбэрийг тодорхой болгож нэмэх нь зүйтэй.

Халдах гэдэг үгийг Монгол хэлний их тайлбар тольд:²⁹

- ойртон очих, дэргэд нь очих, тулж очих;
- халдаж чадахгүй (ойртож чадахгүй);
- хүнд халдах (а. Хүнд ойртож очих; б. Хүн рүү дайрах);
- түрэмгийлэх, хүчлэх, түрэх, эзэрхэх;

²⁷ Монгол Улсын Дээд Шүүх, Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010, 45-46 дахь тал,

²⁸ С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, Ерөнхий анги, УБ., 1996, 98 дахь тал.

²⁹ <https://mongoltoli.mn>

- халдан өнгөлзөх (түрэмгийлэн эзэрхийлэхийг хүсэх),
- халдан довтлох (зүй бусаар хүч түрэн хил хязгаар, эрх чөлөөнд нь халдах);
- халдан түрэмгийлэх (халдан довтлох);
- хилд халдах (хил рүү довтлох);
- улсад халдах (улс руу довтлох, түрэмгийлэх);
- аминд халдах (аминд хүрэх);
- биед халдах (биед хүрэх, биед хүч хэрэглэх);
- халдвал хар халзандаа [зүйр цэцэн үг] (а. Байгаа ганцыгаа, сайныг нь; б. Буруутгавал мэддэг, таньдгаа гэсэн санаа);
- өдөх халдах [хоршоо] (бусдыг элдэвлэн оролдох) гэжээ.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл” тараах гэмт хэрэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг тараасан бол” гэсэн нь өмнөх Эрүүгийн хуульд тодорхойлж байсан “Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараах” гэж гэмт санаа, зорилгыг тусгасантай адилгүй томъёологджээ. Хууль тогтоогч “худал мэдээлэл” гэсэн нэр томъёог хэрэглэсэн нь уг гэмт хэрэгт хамрах худал мэдээллийн хүрээг өргөжүүлсэн бөгөөд монгол хэл, хууль зүйн нэр томъёоны хувьд худал мэдээллийн ноцтой хэлбэр буюу илт худал мэдээллийг гүтгэх, илт худал гүжирдлэг гэж тодорхойлж ирсэн ойлголтыг баримтлаагүй байна. Уг нэр томъёоны сонголт, ойлголтын зөрүүнээс үүдэлтэйгээр эрх зүйн хийдэл бий болж, иргэдийн үг хэлэх, мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хүндрэл үүсгэжээ.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн заалт нь Монгол Улсын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлд “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй”, Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4-т “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэсэн заалтуудтай зөрчилдөж байна

(*Cogitationis poenam nemo patitur*).³⁰

Орчин үед нийгмийн онцлог, мэдээллийн хурд, цахимжилт, технологи хөгжихийн хэрээр мэдээллийн талаарх уламжлалт тогтсон ойлголт, хүрээ өөрчлөгдөж байна. Энэ нь худал мэдээлэл, гүтгэх гэсэн эрх зүйн ойлголт, асуудалд ч нөлөөлж байгаа юм.

АНУ-д төвтэй Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төвөөс (*International Center for Not for Profit law*) боловсруулан 2021 оны 3 дугаар сард гаргасан “Хуурамч мэдээллийн эсрэг Хууль зүйн хариу арга хэмжээ” бодлогын танилцуулгад³¹ мэдээллийн эмх замбараагүй байдал нь хуурамч мэдээлэл төдийгүй, алдаатай болон буруу сэдэлтэй мэдээлэл ихэссэнээс үүдэлтэй. Эдгээр нэр томъёоны нийтээр хүлээн зөвшөөрсөн, түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолт байхгүй боловч тэдгээр нэр томъёог бүрдүүлдэг элементүүдийг нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэхүү товч тоймын зорилгыг хангах үүднээс хуурамч болон алдаатай мэдээлэл, буруу сэдэлтэй мэдээллийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- *Хуурамч мэдээлэл (Disinformation)*: Санаатайгаар төөрөгдүүлсэн, буруу мэдээллийг хэлнэ. Хуурамч мэдээллийг зориуд төөрөгдүүлэх замаар дэлгэж эсхүл төөрөгдүүлэх сэдлээр хийсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хуурамч мэдээлэл гэдэг нь хор уршиг учруулахын тулд мэдсээр байж хуваалцдаг эсхүл болзошгүй хохирлыг үл тоомсорлон хийсэн худал эсхүл мэхлэн өдөөх мэдээлэл юм. Хуурамч мэдээллийн зарим хэсэг үнэн эсхүл “хагас үнэнийг” агуулсан байх нь цөөнгүй тохиолддог. Энэ нь хуурамч мэдээллийг хэрэглэгчид танихад илүү төвөгтэй болгодог. Хуурамч мэдээллийн нэг төрөл нь улс төрийн хуурамч мэдээлэл эсхүл суртал ухуулга бөгөөд улс төрийн ярианы зарим өнцгийн талаарх ойлголтыг бий болгохын тулд худал мэдээллийг зориудаар тарааж буй явдал юм.

Хуурамч мэдээлэл = худал мэдээлэл + хор уршиг учруулах сэдэл

³⁰ Монгол Улсын Дээд Шүүх, Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010, 42 дахь тал.

³¹ <https://www.icnl.org/wp-content/uploads/2021.03-Disinformation-Policy-Prospectus-final.pdf>

- *Алдаатай мэдээлэл (Misinformation)*: Төөрөгдүүлсэн мэдээллийг санамсаргүйгээр тараах явдал. Энэ нь шалгаж тогтоож болохуйц фактуудын талаарх нийтэд тогтсон ойлголттой зөрчилдсөн, мушгин гуйвуулсан мэдээлэл бөгөөд үүнийг хүмүүс бусдыг хууран мэхлэх сэдэлгүйгээр, алдаа гаргаж тараадаг. Алдаатай мэдээлэл нь худал агуулгатай боловч тухайн мэдээллийг хуваалцаж буй хүн худал эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл агуулж байгааг ухааж ойлгоогүй байдаг. Алдаатай мэдээлэл нь бүхэлдээ худал байх албагүй, үүнд алдаа гаргасан нь зориуд бус, санамсаргүй байдалтай буюу мэдээллийг алдаа гаргасны улмаас хийсэн байдаг.

Алдаатай мэдээлэл = худал мэдээлэл + алдаа

- *Буруу сэдэлтэй мэдээлэл (Mal-information)*: Үнэн зөв мэдээллийг хууран мэхлэх арга замаар төөрөгдүүлэхийг оролдож хийдэг. Хэдийгээр мэдээлэл нь бодит боловч үүнийг хор уршиг учруулах сэдлээр хийж, бусадтай хуваалцдаг.

Буруу сэдэлтэй мэдээлэл = үнэн мэдээлэл + хор уршиг учруулах сэдэл

Худал мэдээлэл гэсэн ойлголтыг дотор нь (i) хуурамч мэдээлэл (*disinformation*), (ii) алдаатай мэдээлэл (*misinformation*), (iii) буруу сэдэлтэй мэдээлэл (*mal-information*) гэж ангилан авч үзжээ.

Батлагдаж, нотлогдоогүй аливаа агуулгыг боловсруулж, түгээж байгаа зорилгоор нь хуурамч мэдээллийг хуудуутай (ташаа) мэдээллээс ялгах боломжтой. Хувийн ашиг сонирхлын үүднээс эмчилгээний талаар худал агуулга боловсруулах нь хуурамч мэдээллийн нэг жишээ юм. Гэхдээ үүнтэй ижил агуулгыг үнэн гэж итгээд түүнийгээ бусдад хэрэгцээтэй хэмээн хуваалцсан ч үүнийг мөн адил хуурамч мэдээлэл гэж тодорхойлж болно. Гэхдээ зорилгоосоо үл хамааран хуурамч агуулгын үр нөлөө ижил байх боломжтой. Аль ч тохиолдолд хуурамч мэдээлэлд эрчимтэй автсанаар хүмүүс мэдлэг мэдээлэлгүй хоцрох бөгөөд энэ нь улмаар ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй.

Хуурамч мэдээллийн сэдэл нь янз бүр бөгөөд зарим нь мөнгө олохын тулд байдаг бол нөгөө хэсэг нь улс төрийн давуу байдал олж авах, өөртөө итгэх итгэлийг бууруулах, буруутган зэмлэх, хүмүүсийг

туйлшруулах, цар тахлын эсрэг хариу үйлдлийг сулруулах зэрэг сэдэл агуулж болно. Нөгөөтгээгүүр зарим залилагч мунхаглах, хувийн эго эсвэл тус болох санаатайгаар бусдыг төөрөгдүүлдэг. Хувь хүн, зохион байгуулалттай бүлэг, зарим хэвлэл мэдээлэл, албан ёсны сувгууд санаатайгаар ч санамсаргүйгээр ч хуурамч мэдээлэл түгээх тохиолдол бий. Хуурамч мэдээллийн цар тахал буюу дисинфодемик нь ихэвчлэн үнэн мэдээллийн дунд худал хуурмагийг нуун дарагдуулж байдаг бөгөөд хувцсаар биеэ далдлахтай адил юм. Үүнд хуурамч эсвэл төөрөгдүүлсэн, худал эх сурвалжаас өгсүүлээд, хүмүүсийг урхинд оруулж хуурамч холбоос дээр даруулан залилах гэмт хэрэг хүртэлх сайн танигдсан аргууд багтдаг байна. Тэд шалтгаан бус итгэл үнэмшил дээр, үр дагаварт бус мэдрэмж дээр төвлөрөх замаар хүмүүсийн ухамсарт худал хуурмагийг далдуур суулгаж байдаг. Мөн өрөөсгөл хандлага, хэт туйлшрал, улс төрийн чиг шугам, мөн түүнчлэн бусдын гэнэн итгэмтгий зан, увайгүй явдал, асар их өөрчлөлт, төвөгтэй байдал тулгарсан тохиолдолд энгийн зүйлсийг эрэлхийлэх байдлыг ашигладаг.³²

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан худал мэдээллийн хэлбэрүүд болох (i) хуурамч мэдээлэл, (ii) алдаатай мэдээлэл, (iii) буруу сэдэлтэй мэдээлэл тараасан үйлдлийг хамруулан хуулийг хэрэглэх боломжтой байна. Учир нь бусдыг гутаах зорилгоор тараасан байх шаардлага хуулиар тавигдаагүй тул ямар нэг байдлаар тараасан буюу нэр төрд халдсан бол “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт шалгагдах, хариуцлагад татагдах эрсдэлтэй. Илт худал мэдээлэл тараасан бол хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилго шаардахгүй бөгөөд тараасан буюу халдсан бол гэмт хэрэгт тооцогдох боломжтой гэсэн үг юм. Хуульд заасан халдсан байх гэсэн энэ ойлголт нь өргөн хүрээг хамрах бөгөөд үүнд хүний нэр эерэг, сөрөг ямар ч байдлаар нийтлэлд гарах, дурдагдах явдал гарч болно. Тухайн мэдээлэл нь илт худал боловч хүний нэр төрийг гутаасан агуулга байхгүй байсан ч мөн мэдээллийг гутаах санаа, зорилго агуулахгүйгээр тараасан, дамжуулсан байсан ч “нэр төрд халдсан” гэж худал мэдээлэл тараасан гэмт хэрэгт тооцогдохоор томьёолжээ.

³² UNESCO, Дисинфодемик буюу хуурамч мэдээллийн цар тахал (Ковид 19-тэй холбоотой хуурамч мэдээллийг ухаж ойлгох нь), Бодлогын хураангуй, Орчуулсан Глоб интернэшнл төв, 2021.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн талаар зохицуулсан агуулга нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг хөндөж байна. Энэ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх иргэдийн хүсэл сонирхолд дарамт үүсгэж байгаа болно.

Энэ талаар МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор М.Зулькафиль “Манай улсад багийн даргаас эхлээд төрийн тэргүүнээ хүртэл чөлөөтэй шүүмжилдэг. Харин шүүмжилсний дараа дарамт шахалт багагүй ирнэ. Улс төрийн эсхүл эдийн засгийн дарамт нүдэнд харагдахуйцаар шууд байхгүй. Бүгд далд хэлбэрт шилжсэн”³³ гэж дурдсаныг дэмжиж байна.

Бодит байдалд огт үнэн биш, худал, хуурамч мэдээ сэлт боловсруулан бусдыг гутаан доромжлох, хохирол учруулах зорилгоор тарааж байгаа идэвхтэй үйлдэл бол эрх зүйн зөрчлийн хувьд ноцтой, хүнд хэлбэр, мөн ёс суртахууны хувьд зөвтгөх боломжгүй үйлдэл юм. Ийм үйлдэлд хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүйн хэрэг ч хэрэв тохирсон хариуцлага байхгүй бол санаатай гүтгэгч, худал мэдээлэл тараагчдад боломж олгож, хүний нэр төр, алдар хүндийн халдашгүй байх баталгааг хамгаалалтгүй орхисонтой адил хэрэг болох билээ. Гэсэн ч хүний нэр төр, алдар хүндийг санаатайгаар гутаах зорилгоор худал хуурамч мэдээллийг боловсруулж, санаатайгаар тараасан үйлдлийг Эрүүгийн, Зөрчлийн эсхүл Иргэний хуулийн алинаар шийдвэрлэх нь тухайн улс орны баримталж буй байр суурь, эрх зүйн бодлогоос хамааралтай.

Илт худал мэдээлэл тараах гэдэгт зориуд санаатайгаар зохиосон буюу амьдрал, бодит байдалд байхгүй зүйлийн талаар бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах зорилгоор бусдыг гутаасан агуулгатай худал хуурмаг мэдээлэл бэлтгэн боловсруулж идэвхтэй тарааж буй мэдээлэл гэж онолын хувьд тайлбарлаж болно. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг нь хохирол шаардахгүй хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг бөгөөд илт худал мэдээлэл тараасан тохиолдолд төгссөнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдэнэ. Хохирлын тухайд хүний нэр төр, алдар хүндэд материаллаг бус хохирол учирдаг учраас эрүүгийн

³³ М.Зулькафиль, Монголын хэвлэл мэдээллийн салбарт тулгарч буй гол асуудал бол эзэмшил, <https://ikon.mn/1a3s>, 2018.5.2.

шүүхээс хохирлыг шууд шийдвэрлэхгүй, иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэйг шийтгэх тогтоолд дурдах замаар шийдвэр гаргадаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн зохицуулалтын хувьд өнөөдөр үүссэн эрх зүйн хийдэл, сөрөг үр дагаврыг арилгах үүднээс одоо үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтын хүрээнд уг зүйлийн нэрийг “Гүтгэх” болгон өөрчлөх, уг гэмт хэрэгт зөвхөн гүтгэх буюу хуурамч мэдээлэл гэсэн ойлголтыг хамруулан (i) алдаатай мэдээлэл, (ii) буруу сэдэлтэй мэдээлэл тараасан асуудлыг эрүүгийн хариуцлагад татахгүй байх эрх зүйн хамгаалалтыг бүрдүүлж, уг зүйлд заасан “илт худал мэдээлэл” гэсэн ойлголтыг “илт худал гүжирдлэг” гэж өөрчлөх шаардлагатай нь харагдаж байна.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт тооцогдох худал мэдээллийн хүрээ нь өмнөх Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцож байсан гүтгэх гэмт хэргийн ойлголтоос агуулга, хамрах хүрээний хувьд илт өргөжсөн байх тул Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасан нэр төрийг гутаасан мэдээ иргэний маргаан болон худал мэдээлэл тараах гэмт хэрэг нь хоорондоо ямар ялгаатай болох, ялгагдах шинж, хэрхэн ялгаж зүйлчлэх асуудлаар Улсын Дээд Шүүх албан ёсны тайлбар гаргах шаардлага үүссэн байна.

Худал мэдээлэл тараах гэмт хэргийн талаар зохицуулсан заалтын агуулга, томъёолол нь Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг Монгол Улсын иргэн баталгаатай эдлэх хууль зүйн баталгааг дордуулж, хязгаарласан.

Зөвхөн Эрүүгийн хуульд “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг хуульчилж оруулснаар нийгэмд тархаж буй худал мэдээллийн цар хүрээг багасгаж, таслан зогсоож чадна гэж үзэж болохгүй юм. Харин ч нийгмийн чөлөөт дуу хоолойг боогдуулж, олон талт мэдээллийн хүрээг хумих, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөнд илүү айдас, дарамт бий болгож, улс төрийн эрх мэдэл, засаглалыг гажуудуулах, эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг бий болгох эрсдэлтэй. Худал мэдээлэлтэй тэмцэхийн зэрэгцээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалах шаардлагатай.

Шинэ технологийн дунд хувь хүмүүс, бүлэг этгээд мэдээ, мэдээллийг өмнөхөөс илүү хурдан, илүү өргөн хүрээнд түгээх боломжтой болсноор хуурамч мэдээлэл шинэ төрлийн аюул учруулж байна. Хуурамч мэдээллийн кампанит ажил нь тухайн мэдээллийн агуулгатай асар олон хүн, бүлэг этгээд харьцах боломж олгож, улмаар бусадтай агуулгаа хуваалцан, байршуулах явдлыг өдөөдөг. Хуурамч мэдээллийг бүрэн хориглох, устгах нь зохицуулалтын хувьд биелэгдэхүйц зорилго биш юм. Хуурамч мэдээллийг таслан зогсоох цорын ганц арга зам гэж үгүй. Үүний оронд хуурамч мэдээллийн тархалт, хүрээгээ тэлж буй явдлыг шийдвэрлэхийн тулд хууль зүйн болон зохицуулалтын хэд хэдэн төрлийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Интернэт дэх үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой хууль зүйн болон зохицуулалтын хөгжил нь хуурамч болон алдаатай мэдээлэл тархах шинэ гарцыг бий болгосон технологийн дэвшлээс хоцорч байна³⁴ гэснийг анхаарч үзэх нь зүйтэй.

Судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд заасан “сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэргийг мөн авч үзлээ. Нийгмийн мэдээллийн сүлжээгээр түгээж буй өрөөсгөл, гүйвуулсан, дэгсдүүлсэн, хуурамчаар үйлдсэн мэдээлэл сонгуулийн үеэр эрс нэмэгдэж ард иргэдийн чөлөөт сонголт, улмаар ардчилалд итгэх итгэл үнэмшилд ч сөргөөр нөлөөлж буй талаар олон улсад асуудал болгон ярьж байгаа билээ.³⁵

Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс манай судалгааны багт ирүүлсэн мэдээллээр Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд заасан “сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэргийг 2018-2020 оны бүтэн жилийн байдлаар хянан шийдвэрлээгүй,³⁶ Улсын ерөнхий прокурорын газраас ирүүлсэн мэдээллээр 2020 оны байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.8 дугаар зүйлд заасан “сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” 11 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулснаас

³⁴ <https://www.icnl.org/post/report/responding-to-the-disinformation-dilemma>

³⁵ <https://freedomhouse.org/report/freedom-net/2017/manipulating-social-media-undermine-democracy> Samantha Bradshaw, Philip N. Howard (2020) “2019 Global Inventory of Organized Social Media Manipulation” University of Oxford. <https://comprop.oii.ox.ac.uk/wp-content/uploads/sites/93/2019/09/CyberTroopReport19.pdf>

³⁶ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 01/507 албан бичиг

есөн хэргийг хааж, хоёр хэргийг нэгтгэж шийдвэрлэсэн бөгөөд хэрэгсэхгүй болгосон, яллах дүгнэлт үйлдсэн хэрэг байхгүй байна. 2021 оны эхний дөрвөн сарын байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.8 дугаар зүйлд заасан “сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэрэг байхгүй байна³⁷ гэжээ.

Монгол Улсын Эрүүгийн хууль

14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах

1. Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Энэ гэмт хэргийг төрийн албан хаагч, сонгуулийн хорооны албан тушаалтан, ажилтан үйлдсэн бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар нийтийн албанд томилогдох эрх хасаж нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

Өнгөрсөн 2020 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны албан ёсны хугацаанд буюу 2020 оны 6 дугаар сарын 2-ноос 22-ны хооронд фейсбүүкээр түгээсэн, сонгуультай холбоотой мэдээллийг шинжилж үзэхэд 80 гаруй хувь нь төрөл бүрийн ил, далд ухуулга, сурталчилгаа болон өрөөсгөл, дэгсдүүлсэн, бүрэн бус, гуйвуулсан мэдээлэл байв.³⁸

³⁷ УЕПГ-ын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 4/3650 албан бичиг

³⁸ Хэвлэлийн хүрээлэн, 2020 оны “УИХ-ын сонгуулийн үеэр түгээсэн мэдээллийн мониторинг-2020”.

ИТХ-ын сонгуулийн сурталчилгааны албан ёсны хугацаа буюу 2020 оны 9 дүгээр сарын 30-наас 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд фейсбүүкээр түгээсэн, сонгуультай холбоотой судалгаанд хамрагдсан мэдээллийн 76 хувь нь төрөл бүрийн ил, далд ухуулга, хувь хүний үзэл бодол, мөн бусдын үзэл бодлыг баримт мэт харагдуулах, нэр дэвшигч, нам, эвслийн нэр хүнд, итгэл үнэмшлийг унагах, дөвийлгөх, буруутгах, эргэлзээ төрүүлэх зорилго, нэр дэвшигчийн нэр, лого бүхий хууль ёсны сурталчилгаа болон өрөөсгөл, дэгсдүүлсэн, бүрэн бус, гуйвуулсан мэдээлэл байв. Эдгээрээс зөвхөн 24 хувь нь сэтгүүл зүйн бүтээл байлаа. Сонгуультай холбоотой бүрэн бус, гуйвуулсан, төөрөгдүүлсэн, худал мэдээллийг аль болох олон хүний анхааралд хүргэхийн тулд 7-8 төрлийн арга ашиглаж байна. Эдгээрээс фейсбүүк хэрэглэгчдийг төөрөгдүүлэхийн тулд хэтрүүлэх, хэт ерөнхийлөн хялбаршуулах, шоолох, гоочлох, эрс тэс зүйлсийг харьцуулах, баримт нотолгоогүй мэдээлэл түгээх буюу хөзөр холих арга техникийг хамгийн түгээмэл ашиглажээ. Үүний дараа хэн нэгний үзэл бодлыг баримт мэтээр тунхаглах арга орж байна.

Худал, төөрөгдүүлсэн мэдээллийг түгээж буй анхдагч эх сурвалжаас гадна зохион байгуулалттайгаар бусдад дамжуулах замаар ийм төрлийн мэдээллийн тархалтыг дэмжсэн байх магадлал фейсбүүкээр түгээсэн судалгаанд хамрагдсан нийт мэдээллийн есөн хувьд тогтоогдсон. Цаг үеийн мэдээллийн хэрэгслийн фейсбүүк хуудсаар ИТХ-ын сонгуулийн албан ёсны сурталчилгааны үеэр түгээсэн нийт мэдээллийн 62 хувьд нь хэн нэгэн нэр дэвшигч, улс төрчийн тухай дурджээ. Нэр дурдагдсан байдлыг хүйсээр авч үзвэл 40 хувьд эрэгтэй, эмэгтэй аль алиныг, 57 хувьд нь зөвхөн эрэгтэй, гурван хувьд нь зөвхөн эмэгтэй нэр дэвшигч, улс төрчийн талаар шууд болон шууд бусаар хамаатуулан дурдсан байлаа. Мөн өдөр тутмын сонин болон телевизээр түгээсэн сонгуультай холбоотой нийт мэдээлэл, сурталчилгааны 31 орчим хувь нь эмэгтэй нэр дэвшигчдийн тухай байв. Гэвч фейсбүүкээр түгээж буй хамгийн олон хүнд хүрсэн постын агуулгыг твиттерт хэрхэн хэлэлцсэнийг судлахад нэр дэвшигч эмэгтэйчүүдийг царай зүсээр нь эрэмбэлж, хочилж, ёжилсон текст, үл итгэсэн тайлбар түгээмэл байв.³⁹

³⁹ www.pressinst.org.mn

Сонгуулийн үеэр худал, төөрөгдүүлсэн мэдээлэл их түгж, тараагдаж байдаг. Гэтэл ийм төрлийн гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэсэн зүйл байхгүй байгаа нь анхаарал татлаа. Сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах гэмт хэргийн өргөдөл, гомдлыг эрх бүхий байгууллага хүлээн авч шалгаж байгаа боловч шүүхэд шилжүүлсэн, шүүхээр шийдвэрлэсэн хэрэг байхгүй байна. Иймд цаашид үүний шалтгаан нөхцөлийг шинжлэн судлах, Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай.

2.3. ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ПРАКТИК, ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

2.3.1. Эрүүгийн хуулийн хэрэглээ ба худал мэдээлэл

Улсын ерөнхий прокурорын газраас манай судалгааны багт ирүүлсэн мэдээллээр 2020 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” 251 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулснаас 121 хэргийг хааж, найман хэргийг нэгтгэн, 17 хэрэгт яллах дүгнэлт үйлджээ. Үлдсэн 105 хэрэг шийдэгдээгүй байна. 2021 оны эхний дөрвөн сарын байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” хэрэг өмнөх оны үлдэгдэл 105, шинээр нээсэн 119, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан зургаа, нийт 230 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулснаас 89-ийг хааж, дөрвөн хэргийг нэгтгэн, нэг хэргийг хэрэгсэхгүй болгож, найман хэрэгт яллах дүгнэлт үйлдсэн байна. Одоо ажиллагаанд 128 хэрэг шалгагдаж байна⁴⁰ гэжээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс манай судалгааны багт ирүүлсэн мэдээллээр Монгол Улсад 2020 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” 10 гэмт хэрэг хянан шийдвэрлэгдсэн байна.⁴¹

⁴⁰ УЕПГ-ын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 4/3650 албан бичиг

⁴¹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 01/507 албан бичиг

Манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг гол онцлог бол ганц эх газрын эрх зүйн (мөрдөн шүүх) тогтолцоонд хамаардаг гэхээсээ илүүтэй шүүх мэтгэлцээний үндсэн дээр бодит байдлыг тогтоодог, шүүгчид шүүхийн практик, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн жишгийг харгалздаг зэргээс дүгнэхэд холимог эрх зүйн тогтолцооны загварт шилжиж байна гэж дүгнэж болохоор юм. Нотлох баримтыг шүүгч өөрийн дотоод итгэлээр үнэлэх нь сэтгэхүйн ажиллагаа төдийгүй тодорхой шийдвэр гаргахад нөлөөлөх гол хүчин зүйл билээ. Шүүх хийсвэр бус, харин шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээнд нэгэнт шалгагдсан буюу бэхжүүлж, хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан шинжлэн нягталж үзсэний үндсэн дээр хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгон үйл баримтыг тогтоодог. Дээрх байдлыг нягт нямбай хянасны үндсэн дээр шүүхээс гэмт хэргийг сэргээн дүрслэх замаар уг хэргийн болж өнгөрсөн жинхэнэ нөхцөл байдлыг бүрэн, бодитой тогтоож, тухайн асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргадаг.

Шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn сайтаас 2020, 2021 онд шийдвэрлэгдсэн худал мэдээлэл тараах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх тогтоолыг хайн шүүлт хийж үзэхэд 2020 онд тав, 2021 онд долоо, нийт 12 шийтгэх тогтоол орсон байх бөгөөд судалгааны ажлын хүрээнд бид сүүлийн хоёр жилийн хугацаанд шийдвэрлэгдсэн гэмт хэргийн шүүхийн шийдвэрийг шинжилж судалгааны ажлыг үргэлжлүүлэв. Харин давж заалдах болон хяналтын шатны журмаар шийдвэрлэгдсэн хэргийн магадлал, тогтоол шүүхийн нээлттэй мэдээллийн санд байхгүй байв. Үүний нэг гол шалтгаан нь анхан шатны шүүхээр шийтгэгдсэн шүүгдэгчид ихэнх тохиолдолд гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэм буруу дээр маргадаггүй, шүүх хуралд өмгөөлөгчгүй оролцож байгаа нь нөлөөлж байна. Үүнтэй холбоотойгоор анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах асуудал бараг гардаггүй ажээ.

Судалгааны баг 2020, 2021 онд шүүхээр шийдвэрлэгдсэн худал мэдээлэл тараах гэмт хэргийн зарим шүүхийн шийдвэрт шинжилгээ хийсэн болно. Шүүхийн шийдвэрт хийсэн дэлгэрэнгүй дүн шинжилгээг Хавсралт 1-ээс үзнэ үү. Шүүхээр шийдвэрлэгдсэн худал мэдээлэл тараах

гэмт хэрэг, түүний шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийн, нэгтгэн дүгнэж дор дурдсан дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

1. Бусдын нэр төрийг гутаах зорилгоор санаатайгаар илт худал гүжирдлэг зохиох, илт худал мэдээлэл, гүтгэлгийг нэр төр гутаах сэдлээр олон нийтийн сүлжээгээр тараах зөрчил цөөнгүй гарч байна. Шүүхийн практикт хүний нэр төр, алдар хүндийг илтэд гутаасан агуулгатай худал мэдээлэл, гүжирдлэг, гүтгэлгийг олон нийтэд тараах үйлдлийг санаатай хийсэн холбогдох этгээдийг гэм буруутайд тооцож, ял шийтгэлийг оногдуулан шийдвэрлэж байгаа зөв жишиг байна.
2. Хууль хэрэглээ, шүүхийн практикт энэ төрлийн хэргийг шийдвэрлэхэд хүний эрхийг зөрчсөн, мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан цөөнгүй тохиолдол гарчээ. Нэр хүндэд халдсан гэдэг нь заавал нэр төрийг гутаасан гэсэн агуулгыг бүрэн илэрхийлэхгүй, гутаасан агуулга байхгүй ч нэр хүнд, эрх ашиг хөндөгдсөн бол халдсан гэж үзэж гомдол гаргах, түүнийг цагдаагийн байгууллага хүлээн авч шалгах тохиолдол их байна. Тодорхой, бодитой үйл явдалд тулгуурласан, үндэслэл бүхий үзэл бодол, таамаг, шүүмжлэлт сөрөг мэдээлэл тараасан, иргэний хэргийн шинжтэй зарим асуудлыг эрүүгийн журмаар шалгах нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд дарамт, цензур болж байна. Энэ нь гаргасан өргөдөл, гомдлын тоо олон, харин шүүхээр шийдвэрлүүлж буй хэргийн тоо харьцангуй цөөн байгаагаас харагдаж байгаа юм. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шалгах, шийдвэрлэхдээ “илт худал мэдээлэл” гэсэн ойлголтод тодорхой үйл баримт, болсон үйл явдалд үнэлэлт дүгнэлт өгсөн, шүүмжилсэн, тодорхой үндэслэл бүхий боловч нэр хүндийг гутаасан, түүнд халдсан, бодит баримтыг бүрэн гүйцэт бус, алдаатай мэдээлэл тараасан, сөрөг мэдээллийг хамруулан эрүүгийн журмаар шалгаж, шүүхээс гэм буруутайд тооцох асуудал гарч байгаа нь үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөөний зарчимд нийцэхгүй байна.
3. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэт нэг талыг барьсан, хэргийн нотолбол зохих

нөхцөл байдлыг бүрэн шалгаж тогтоохгүй, зөвхөн гомдол, өргөдөл гаргагч этгээдийн өгсөн мэдээлэл, баримтад тулгуурлан үнэн, худлыг шүүн дүгнэлт хийх, мэдээлэл тараасан этгээдийг буруутгах хандлага, практик мөрдөн шалгах, прокурор, шүүхийн шатанд бодитой байна.

4. Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хохирогч нь нэр бүхий тодорхой этгээд биш харин хорио цээрийн дэглэмийн үед уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа нийт төрийн албан хаагчийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон илт худал мэдээллийг тараасан гэж иргэнийг буруутган яллаж ял шийтгэсэн тохиолдол гарчээ. Эрүүгийн хуульд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн зүйл, заалтыг төрийн алба, төрийн алба хаагчдыг үл хүндэтгэх, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэсэн үзэл хандлагын үүднээс төрийн байгууллага ашиглан, иргэдийн эсрэг гомдол, өргөдөл гаргах тохиолдол гарсан байна (Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, 2020.4.3, №00112).
5. Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт доромжлох гэсэн агуулга шууд тусгагдаагүй, харин шүүхийн практикт худал мэдээлэл тараах гэдэгт доромжлох үйлдлийг хамруулан хэрэглэж байна. Доромжлох гэдэг нь хууль зүйн хувьд нийтээр тогтсон ёс суртахуун, зан үйлийн хэм хэмжээг үл хүндэтгэн, хүнийг доог тохуу болгох зорилгоор сөргөөр буюу зүй бус, зохисгүй байдлаар нэрлэж, дуудаж, үнэлж бичих, хүний зан үйл, зан төлөвийн үнэн бодит байдал, хүний алдар хүндэтгэлийг гуйвуулан үгүйсгэж буй явдал юм. Жишээ нь, хүнд хоч өгөх, гарал үүсэл, яс үндэс, биеийн гадаад хэлбэр, бие эрхтний гажиг, ажил мэргэжил зэргээр нь доромжлох явдал гардаг. Цаашид бусдыг доромжлох замаар нэр хүндэд халдах асуудлыг худал мэдээлэл тараах гэмт хэргээс ялгах шаардлага харагдаж байна.
6. Энэ төрлийн хэрэгт шалгагдаж байгаа иргэд хууль зүйн туслалцаа авахгүй, өмгөөлөгчгүйгээр хэрэг шалгах ажиллагаанд оролцох явдал түгээмэл байх бөгөөд үүний улмаас яллах, буруутгах ажиллагаа илүү давамгайлж буй байдал ажиглагдлаа. Мөн иргэд маргаж мэтгэлцэхгүйгээр гэм буруугаа шууд хүлээн,

хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх, уг асуудлыг хурдан дуусгавар болгох хүсэлтээ илэрхийлдэг байна. Ингэж шийдвэрлэгдэх үед илтэд иргэний хэргийн шинжтэй байж болох нэр төр гутаасантай холбоотой асуудлыг эрүүгийн хэргийн журмаар шийдвэрлэсэн тохиолдол гарч байна.

7. ЭХХШтХ-ийн 2.2 дугаар зүйлийн 1-д “Хэргийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ”, 4-т “Хэрэг тухайн шүүхэд харьяалагдахгүй байвал шүүгчийн шийдвэрээр харьяалах шүүхэд шилжүүлнэ”, 8-д “Уг хэрэг адил эрх бүхий өөр шүүхэд харьяалагдах нь шүүх хуралдааны үед мэдэгдсэн бөгөөд хэргийн байдлыг бүрэн бодитойгоор тогтооход нөлөөлөхгүйгээр байвал шүүх хуралдааныг үргэлжлүүлж, хэргийг эцэслэн шийдвэрлэнэ” гэж заасан. Хэргийн харьяалал анхнаасаа тодорхой байхад харьяалал зөрчиж өргөдөл, гомдлыг хүлээн авах, хэргийг шалгах ажиллагаа явуулах, шүүхийн шатанд шүүгдэгч уг асуудлаар маргаагүй, хэргийн бодит байдлыг тогтооход нөлөөлөхгүй гэж үзэж хэргийг шийдвэрлэсэн тохиолдол гарсан байна. Энэ байдал нь өргөдөл, гомдол гаргагч этгээдэд илүү таатай нөхцөлийг бүрдүүлж ЭХХШтХ-ийг ноцтой зөрчсөн асуудал юм.
8. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд тараасан мэдээллийг худал мэдээлэл тараах гэмт хэрэгт сэрдэн шалгах, улмаар шүүхээр ял шийтгэх тохиолдол гарчээ. Сэтгүүлч мэдээллийг хайх, олж авах, түгээх, хэвлэн нийтлэх эрхтэй бөгөөд энэ нь сэтгүүлчийн үндсэн ажил, мэргэжлийн үйл ажиллагаа болно. Сэтгүүлчийн үйл ажиллагаа нь бусдын нэр төрийг санаатай гутаах зорилготой үйлдэл биш юм. Мэргэжлийн үйл ажиллагаанаас үүдсэн худал мэдээлэлтэй холбоотой асуудлыг Эрүүгийн гэмт хэрэгт холбогдуулан шалгах, гэм буруутайд тооцсон явдал нь хэвлэл мэдээллийн чөлөөт байдлыг хангах зарчимд нийцэхгүй байна.
9. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол хүлээн авах, шалгах, шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан журмаар шийдвэрлэгдэх иргэний маргааны шинжтэй бол энэ төрлийн өргөдөл, гомдлыг хүлээн авахгүй байх, уг

асуудлаар үүсгэсэн эрүүгийн хэргийг шууд хэрэгсэхгүй болгож байх, цаашид хууль хэрэглээний хувьд Эрүүгийн хуульд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-г заасан журмаар шийдвэрлэгдэх хэрэг маргааныг зөв ялган зүйлчлэх, иргэний шинжтэй маргааныг эрүүгийн журмаар шалгахгүй байх, эрүүгийн хариуцлагад татахгүй байх шаардлагатай.

2.3.2. Зөрчлийн тухай хуулийн хэрэглээ ба худал мэдээлэл

УИХ-аас 2015 онд баталсан Эрүүгийн хуулиар гүтгэх, доромжлох үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй болж, УИХ-аас 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Зөрчлийн тухай хуулийг баталсан ба уг Зөрчлийн хуулийн 6.21 дүгээр зүйлд “гүтгэх” зөрчлийг заасан.

6.21 дүгээр зүйл. Гүтгэх

1. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Төрийн албан тушаалтан, иргэд эсхүл иргэд хоорондын асуудлыг эрүүгийн хуульд байлгах боломжгүй гээд хассан. Гэтэл тухайн үед УИХ-ын гишүүдийн санал хуваагдсан тул завсрын зохицуулалт болгоод Зөрчлийн хуульд оруулсан байна. Энэ нь Зөрчлийн хуулийн үндсэн үзэл баримтлал болох төр, иргэний хоорондын маргааныг зохицуулдаг харилцаа байтал үүнтэй зөрчилдүүлж хоёр иргэний хоорондын маргааныг оруулж ирсэн. Шилжилтийн үеийн зохицуулалт болгоод ядаж хүн гүтгэсэн гээд ял шийтгэл авахгүй, цагдан хоригдохгүй, гүйцэтгэх ажил хийгдэхгүй гэж үзсэн байна.⁴²

⁴² ННФ, Чухал сэдэв хэлэлцүүлгийн тэмдэглэл, 2019.

УИХ-аас баталсан 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Зөрчлийн тухай хуулиас гүтгэх зөрчлийг хасаж, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд худал мэдээлэл тараах гэсэн гэмт хэргийг тусгасан билээ. Тиймээс 2017 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд л Зөрчлийн тухай хуулиар гүтгэх зөрчилд шийтгэл оногдуулж байсан.

Улсын ерөнхий прокурорын газраас манай судалгааны багт 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн мэдээллээр:⁴³

- Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 6.21 дүгээр зүйлд заасан “гүтгэх” зөрчил 2018 онд 496 гарснаас хялбаршуулсан журмаар 10 зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчлийн 486 хэрэг нээн шалгаж, 76 хүнд шийтгэл оногдуулсан. 2019 онд 520 гарснаас хялбаршуулсан журмаар 10 зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчлийн 512 хэрэг нээн шалгаж, 101 хүнд шийтгэл оногдуулсан. 2020 онд 95 гарснаас хялбаршуулсан журмаар таван зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчлийн 90 хэрэг нээн шалгаж, 35 хүнд шийтгэл оногдуулжээ.
- Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйл “Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих” (гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэлийн талаар олон нийтийг төөрөгдүүлэх мэдээ, мэдээлэл түгээх зэрэг асуудал) зөрчил 2018 онд 51 гарснаас хялбаршуулсан журмаар 49 зөрчлийг шалган шийдвэрлэж, хоёр хэрэг нээн шалгаж, 56 хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан. 2019 онд 14 гарснаас хялбаршуулсан журмаар 12 зөрчлийг шалгаж шийдвэрлэж, хоёр хэрэг нээн шалгаж, 13 хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан. 2020 онд 1790 гарснаас хялбаршуулсан журмаар 667 зөрчлийг шалган шийдвэрлэж, 1123 хэрэг нээн шалгаж, 1480 хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан байна.

⁴³ УЕПГ-ын 2021.6.18-ны өдрийн 4/3650 албан бичиг

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс манай судалгааны багт 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр ирүүлсэн мэдээллээр:⁴⁴

- Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийн 1-д заасан “гүтгэх” зөрчлөөр 2019 онд нэг зөрчлийн хэрэг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн байна.
- Мөн Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих” (олон нийтийг төөрөгдүүлэх мэдээ, мэдээлэл түгээсэн) зөрчлөөр 2020 онд 190 зөрчлийн хэрэг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгджээ.

Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлд заасан “Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих” зөрчлийн “Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэлийн талаар олон нийтийг төөрөгдүүлэх мэдээ, мэдээлэл түгээсэн” гэдгийг онолын болон хууль хэрэглээний практикт хэрхэн ойлгож хэрэглэж байгаа нь анхаарал татаж байна.

Шүүхийн шийдвэрийн санд⁴⁵ тухайн үед Зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн 49 шийдвэр орсон байх бөгөөд эдгээрээс зарим шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Цагдаагийн ерөнхий газрын Нийгмийн хэв журам хамгаалах Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас 2020 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр иргэн Л.Наранбаатарыг Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “гүтгэх зөрчил үйлдсэн” гэж 2,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна. Уг торгох шийтгэлийг эс зөвшөөрч иргэн Л.Наранбаатар Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан ба шүүх гомдлыг хүлээн авч 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хянаад Л.Наранбаатар нь иргэн З.Энхболдын нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон мэдээллийг нийтийн сүлжээгээр тарааж гүтгэх зөрчил үйлдсэн болохыг тогтоож, эрх бүхий албан тушаалтнаас шийтгэл оногдуулсан шийдвэр нь үндэслэлтэй

⁴⁴ ШЕЗ-ийн 2021.6.8-ны өдрийн 01/507 албан бичиг

⁴⁵ www.shuukh.mn

байна гэж дүгнэжээ. Гэсэн ч 2020 оны 1 дүгээр сарын 10-нд УИХ-аас Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулж Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийг хүчингүй болгосон байх тул шийтгэлээс чөлөөлж шийдвэрлэх нь зүйтэй гэж шийдвэрлэжээ.

2. 2018 оны 11 дүгээр сарын 6-нд “Айсол” ХХК-ийн <https://newspress.mn> сайтад “...Хөдөлмөрийн баатар Л.Чинбат ТЭДС-гийн урамшууллын талыг авчээ” гэсэн мэдээлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдаж дээрх мэдээллийг нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаах зорилгоор гүтгэсэн гэж СБД-ийн цагдаагийн хэлтэст гомдол гаргажээ. Уг нийтлэлд “2017 онд улсын төсөвт улаан буудайн урамшуулалд 16 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд нэр бүхий найман компаниараа дамжуулан 7,6 тэрбум төгрөг буюу нийт урамшууллын 48 хувийг Л.Чинбат ганцаараа хүртсэн нь шударга ёс гэж үү” хэмээн бичжээ. Холбогдогч Б.Батбаяр, Г.Улсболд нар тайлбартаа үйл явдлын мэдээ байсан, Л.Чинбатын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгогүй гэж мэдүүлсэн. Бодит байдалд дээрх мэдээлэл батлагдсан бөгөөд гагцхүү урамшууллын 48 бус 30 орчим хувийг эзэлж байсан, мөн урамшууллыг зохих журмын дагуу авсан нөхцөл байдал тогтоогджээ. Уг мэдээлэл цацагдсаны дараа мэдээллийн доор 50 орчим иргэн уурлаж хилэгнэсэн сэтгэгдэл бичиж “Гацуурт” ХХК болон Л.Чинбатын нэр хүнд унасан хэмээн тэрээр мэдүүлэгтээ дурджээ. Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсээс зөрчлийн хэргийг шалгаж дуусаад холбогдогч Б.Батбаярыг 2,000,000 төгрөгөөр, мөн “Айсол” ХХК-ийг 0030085 тоот шийтгэлийн хуудсаар 20,000,000 төгрөгөөр торгож шийдвэрлэснийг эс зөвшөөрч СБД-ийн ЭХАШШ-д ханджээ. Шүүхээс Зөрчлийн хэргийг хянаж үзээд гүтгэх зөрчил нь “...гутаан доромжилсон худал мэдээллийг” гэдэг шинжийг агуулж байна, холбогдогчид нь олдсон мэдээллийг шүүрч авч мэдээлсэн, уг мэдээлэл нь бага зэргийн зөрүүтэйгээс бус агуулгын хувьд бодит байдалд тохирч байгаа учир хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Эндээс дүгнэж үзвэл Зөрчлийн тухай хуулийн “гүтгэх” заалт хүчин төгөлдөр үйлчилж байхад иргэдийн зүгээс иргэний хэргийн шинжтэй нэр төр, алдар хүндтэй холбоотой иргэний маргааныг зориуд Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлүүлэх хандлага бий болжээ. Нэгэнт иргэний хэргийн шинжтэй тул Зөрчлийн хэрэг шалгах ажиллагааны явцад, мөн шүүхийн шатанд тухайн зөрчлийн хэрэг нь иргэний хэргийн шинжтэй маргаан бүхий нөхцөл байдал болох нь тогтоогдож, улмаар зөрчлийн хэргийн шинжгүй тул тухайн зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож байв.

Монгол Улсад Зөрчлийн тухай хуулиар гүтгэх зөрчлийг шийдвэрлэх болсон цагаас хойш 2017 онд 28, 2018 онд 486, 2019 онд 355 энэ төрлийн зөрчил бүртгэгдсэн байна.⁴⁶ Гүтгэх зөрчлийг Зөрчлийн тухай хуульд оруулсан нь нэр төр, алдар хүндтэй холбоотой иргэний маргааныг давхардуулан Зөрчлийн хуулиар шийдвэрлэх нөхцөл, шалтгааныг бий болгосон бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 21.6 дугаар зүйлд заасан гүтгэх зөрчил болон Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн зохицуулалт зарчмын онцлог ялгаа нь тодорхой бус, эрх зүйн давхардал үүсгэн, эрх зүйн хийдэл бий болгожээ. Үүнээс шалтгаалан Зөрчлийн тухай хуулийн “гүтгэх” заалтыг хүчингүй болгох шаардлага үүссэн болно.

2.3.3. Иргэний хуулийн хэрэглээ ба худал мэдээлэл

Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ” гэж заасан.

Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасан “гутаасан мэдээ” нь “худал мэдээлэл” болон “үнэн мэдээлэл”-ийг давхар агуулдаг. Иргэний хуулийн 21.3-т бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол няцаах үүрэг хүлээхээр зохицуулсан. Иргэний хуулиар зохицуулж буй гутаасан мэдээ буюу бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол уг асуудал нь Эрүүгийн

⁴⁶ Глоб интернейшнл төв, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан, 2020.

хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт тооцогдох ёсгүй юм.

2.4. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Гадаадын зарим улс орноос төлөөлөл болгож ХБНГУ-ын Эрүүгийн хуульд заасан хүний нэр төрийг гутаах, доромжлох, гүтгэх гэмт хэрэг, мөн ОХУ-ын Эрүүгийн хуульд заасан гүтгэх, нэр төр гутаахтай холбоотой заалтыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.14-т заасан “худал мэдээлэл тараах гэмт хэрэг”-ийн заалттай харьцуулан авч үзлээ. ХБНГУ-ын Эрүүгийн хуулиар нэр төрийг гутаах, гүтгэх, худал мэдээлэл, доромжлох зэрэгтэй холбоотой 11 гэмт хэргийг тусад нь арван дөрөвдүгээр бүлэгт зохицуулжээ. Уг бүлэгт бусдыг гүтгэх (187), доромжлох (185), худал цуу яриа тараах (186), нас барсан хүний дурсгалыг доромжлох (189), шүүхийн шийдвэрээр үнэнийг нотлох (190), улс төрчтэй холбоотой худал цуу яриа болон гүтгэлэг (188), харилцан бие биеэ доромжлох (199), үнэн байдал нотлогдсоныг үл харгалзан доромжлох (192), эрүүгийн хэрэг үүсгэх өргөдөл, гомдол (194), хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах (193), шийтгэх тогтоол гаргах (200) зэрэг өргөн хүрээг хамарсан байна. Эдгээрээс гүтгэх, худал мэдээлэл, доромжлохтой холбоотой зохицуулалтыг авч үзье.

Хүснэгт 2. ХБНГУ-ын Эрүүгийн хууль⁴⁷

№	АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДОРОМЖЛОХ
1.	<p>§185. Доромжлох</p> <p>Доромжлох гэмт хэрэг үйлдсэн бол нэг жил хүртэл хугацаагаар хорих эсхүл торгох ял шийтгэх ба хүч хэрэглэх замаар доромжилсон бол... ял шийтгэнэ.</p>
2.	<p>§186. Худал цуу яриа тараах</p> <p>Бусдын нэр хүндийг унагаж, олон нийтийн өмнө гутаан доромжлуулахын тулд түүний талаар нотлогдоогүй баримт зарласан эсхүл тараасан бол... ял шийтгэнэ.</p>

⁴⁷ Монгол, Орос, Хятад, Герман улсуудын Эрүүгийн хууль, УБ., 2021.

3. §187. Гүтгэх

Бусадтай холбоотой баримт худал гэдгийг мэдсээр байж түүнийг олон нийтийн өмнө гутаан доромжлуулж, зээлийн чадварт нь эрсдэл учруулахын тулд түүний талаар худал баримт зарласан эсвэл тараасан бол... ял шийтгэнэ.

Тус Эрүүгийн хуулиар гүтгэх, доромжлох гэмт хэргийг тусад нь хуульчилжээ. Монгол Улсын хувьд доромжлох гэмт хэргийг Эрүүгийн хуулиас халсан ч шүүхийн практикаас харахад доромжлох үйлдлийг худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хамруулан шийдвэрлэж байна. ХБНГУ-ын Эрүүгийн хуульд заасан “гүтгэх гэмт хэрэг”-г баримт худал гэдгийг мэдсээр байж, олон нийтийн өмнө гутаан доромжлуулж, зээлийн чадварт нь эрсдэл учруулахын тулд тараасан бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилжээ. Уг гүтгэх гэмт хэрэгт хүний нэр төр, алдар хүндийг гутаах субъектив санаа зорилгыг гэмт хэрэгт тооцох гол шинж байхаар тусгасан. ХБНГУ-ын Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэргийн бүрэлдэхүүн нь санаатай үйлдэл байх нөхцөлийг шаардлага болгодог бөгөөд энэ нь хэрэгтэн хэргийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэх гэж хүссэн, уг хэргийн объектив нөхцөл байдлыг мэдсэн байх ёстой гэсэн үг юм.⁴⁸

Германы эрүүгийн эрх зүйн эртний онол ёсоор хэргийн бүрэлдэхүүн нь зөвхөн объектив шинж чанарыг авч үздэг, аливаа гэмт хэргийн субъектив элементийг гэм буруугийн шатанд авч үздэг байжээ. ХХ зууны дунд үеэс энэ нь зөвхөн гэм буруугийн асуудал бус тухайн хэргийг санаатай үйлдсэн үү, болгоомжгүйн улмаас үйлдсэн үү гэдэг нь уг хэргийн зүй бусын хамаарлын эзлэх жинд чухал ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрсөн. Ингэснээр гэмт хэргийн ухагдахууныг субъектив бүрэлдэхүүнээр өргөтгөж хэрэгтний хэрэг үйлдэх дотоод сэдэлт, гэмт санаа, зорилго, сэтгэл санааны нөхцөлийг авч үзэх болжээ. Субъектив хэргийн бүрэлдэхүүний хамгийн чухал элемент бол гэмт санаа юм. Эдүгээ давамгайлж байгаа олонхын үзлээр гэмт санаа гэдэг нь хэргийн объектив нөхцөл байдлыг мэдэж байгаа ч хэргийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэхийг хүссэн хүсэл зорилго юм. Энэ ойлголт ёсоор гэмт санаа нь хэрэгтний тухайн хэргийн нөхцөл байдлын

⁴⁸ Э.Хилгендорф, Д.Чанцалдулам, Германы Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, УБ., 2015, 31 дэх тал.

тухай юу мэдэж байгааг илтгэх “мэдэх” нэг элементээс гадна хэргийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэхийг хүссэн, дотоод хүсэл зорилгыг илтгэх “хүсэх” бас нэг элементийг тус бүр өөртөө агуулж байна. Хэргийн бүхий л объектив нөхцөл байдлыг мэдсэн хэр нь хэргийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэхийг хүссэн тэр санааг буюу товчоор хэргийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэхийг мэдсэн бөгөөд хүссэн тэр санаа зорилгыг гэмт санаа гэнэ.⁴⁹

ОХУ-ын Эрүүгийн хуулийн арван долоодугаар бүлэгт хувь хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэргүүдийг багтаасан байх бөгөөд тус хуулийн 128.1 дугаар зүйлд “гүтгэх гэмт хэрэг”-ийн талаар заажээ. Гүтгэх гэсэн ойлголтыг “нэр төрийг санаатайгаар гутааж буюу нэр хүндэд нь халдаж”, “хуурамч мэдээлэл” тараасан бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна. Уг зүйлд нэр төрийг санаатай гутаасан байх субьектив санаа зорилгыг гэмт хэргийн гол шинж болгож заасан байна.

⁴⁹ Э.Хилгендорф, Д.Чанцалдулам, Германы Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, УБ., 2015, 51 дэх тал.

Хүснэгт 3. ОХУ-ын Эрүүгийн хууль⁵⁰

№ **АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХУВЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ
ЧӨЛӨӨ, НЭР ТӨР, АЛДАР ХҮНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**

1. **128.1 дүгээр зүйл. Гүтгэх**

1. Бусдын нэр төрийг санаатайгаар гутааж буюу нэр хүндэд нь халдаж, хуурамч мэдээлэл тараасан бол таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны зургаан сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл зуун жаран цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.

2. Олон нийтийн өмнө ярьсан, эсхүл нийтэд бүтээлээр үзүүлсэн, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүний нэр төрд халдсан бол нэг сая хүртэл рубль эсхүл ялтны нэг жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.

3. Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэн бол хоёр сая хүртэл рубль эсхүл ялтны хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл гурван зуун хорин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.

4. Бусдад аюул учруулж болзошгүй хүнд өвчтэй гэж гүтгэсэн бол гурван сая хүртэл рубль эсхүл ялтны гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5. Бэлгийн хүчирхийллийн хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж гүтгэсэн бол таван сая хүртэл рубль эсвэл ялтны гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар баривчлах эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

⁵⁰ Мөн тэнд.

ХБНГУ, ОХУ-ын Эрүүгийн хуулийн гүтгэхтэй холбоотой зүйл, заалтыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн зүйл, заалттай харьцуулан авч үзэхэд манай улс худал мэдээлэл тараах гэмт хэрэгт гүтгэлэг тарааж буй этгээдийн субъектив санаа зорилгыг шаардахгүй байхаар хуульчилснаараа ялгаатай байна. Манай улсын Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан уг гэмт хэрэг нь онолын хувьд санаатай гэмт хэрэг мөн боловч хууль зүйн техникийн хувьд бусдын нэр төрийг гутаах зорилгоор тараасан байх шалгуурыг орхигдуулсан нь сул тал болж, практикт сөрөг үр дагавар үүсгэж байгаа болно. Уг гэмт хэрэгт худал мэдээлэл тарааж буй этгээдийн субъектив санаа зорилго чухал ач холбогдолтой юм. Үүнийг ХБНГУ, ОХУ-ын Эрүүгийн хуульд илүү тодорхой тусгасан байгаа нь манайхаас дэвшилттэй байна. Харин манай улс худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хэргийн объектив шинж чанарыг гол шинж болгон авч үзэж, хэргийн чухал бүрэлдэхүүн болсон гэмт санаа зорилго болох субъектив талыг орхигдуулсан нь ХБНГУ, ОХУ-ын Эрүүгийн хуультай харьцуулан авч үзэхэд ухралт болжээ.

2.5. ҮГ ХЭЛЭХ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ЖИШИГ, СТАНДАРТ

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний НҮБ-ын Тусгай мэдээлэгч, OSCE-ийн (Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага) Хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч, OAS-ын (Америкийн муж улсуудын байгууллага) Хэвлэлийн эрх чөлөөний тусгай мэдээлэгчдийн баталсан хамтарсан тунхаглалд “Нэр төр гутаахын эсрэг хуулиуд олон нийтэд ач холбогдолтой асуудлаар нээлттэй маргахын ач холбогдол, төрийн зүтгэлтнүүд иргэдтэй харьцуулахад илүү их шүүмжлэл хүлээн зөвшөөрөх шаардлагатай байх зарчмыг тусгасан байх, хэнийг ч үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө нэр төр гутаасан хэрэгт хариуцлагад татаж үл болно”⁵¹ гэжээ.

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 34 тоот Ерөнхий тайлбарын 47-д “Нэр хүнд гутаасантай холбоотой хууль тогтоомжийг маш хянамгай, гурав дахь хэсэгт нийцүүлэн боловсруулах ёстой бөгөөд тэдгээр нь практикт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг боомилоход

⁵¹ “Глоб интернейшнл ТББ, Олон нийтийн мэдэх эрх: мэдээллийн эрх чөлөө, УБ., 2002, 61 дэх тал.

үйлчлэх ёсгүй. Ийм бүх хууль тогтоомж, ялангуяа нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хууль нь үнэнийг хамгаалах хамгаалалтыг багтаасан байх бөгөөд мөн чанарын болон нотолгооны субъектын хувьд илэрхийллийн хэлбэрүүдтэй холбоотойгоор хэрэглэгдэх ёсгүй. Үгүйдээ нийтийн албан тушаалтнуудтай холбоотой тайлбар сэтгэгдлийн хувьд шийтгэх, санамсаргүй алдаа гарган, хорон санаа агуулалгүйгээр хэвлэн нийтэлсэн материалыг үнэн бус, хууль бус гэж үзэхээс зайлсхийвэл зохино. Ямар ч тохиолдолд шүүмжлэлийн сэдвийн асуудалд олон нийтийн эрх ашиг хамгаалалт болохыг хүлээн зөвшөөрвөл зохино” гэжээ.⁵²

Энэ хэсэгт олон улсын жишиг практикт үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн ойлголт, зарчмыг хэрхэн баталгаажуулсан болон шаардлагатай жишиг, зарчим, практикийг Монгол Улсад нэвтрүүлэх, нутагшуулах асуудлыг авч үзлээ. Үүний нэг жишээ нь Салливаны хэрэг⁵³ юм.

АНУ-ын Дээд шүүх 1964 онд Нью-Йорк Таймс сонин болон Салливан нарын хэргийг шийдвэрлэсэн байна. Нью-Йорк Таймс сонин Алабама мужийн Монтгомери хотын хууль сахиулах албаны ажилтнууд иргэний эрхийн төлөө тэмцэгчдийн эсрэг хүч хэрэглэж байгааг эсэргүүцсэн агуулгатай төлбөртэй сурталчилгаа нийтэлсэн. Уг сурталчилгаанд Монтгомери хотын цагдаагийн газрын комиссар Л.Б.Салливаны нэрийг дурдаагүй ч сурталчилгаанд орсон үг хэллэг нь түүний нэр төрийг гутаасан гэх үндэслэлээр шүүхэд ханджээ. Анхан шатны шүүх хэргийг Салливаны талд шийдвэрлэж, түүний нэр төрийг гутаасны хохиролд 500,000 ам.доллар төлөх шийдвэр гаргажээ. Уг шийдвэрт Нью-Йорк таймс сонин гомдол гаргаснаар АНУ-ын Дээд шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүйд тооцсон. Дээд шүүх шийдвэрийнхээ үндэслэлийг “Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа асуудлаар нээлттэй, ширүүн маргаан, мэтгэлцээн өрнөх нь зүйн хэрэг, худал мэдээлэл нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа асуудлаар эрүүл мэтгэлцээн өрнөх нөхцөлийг хангахад ач холбогдолтой учраас АНУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлтээр худал мэдээллийг ч хамгаалах ёстой. Түүнчлэн төрийн албан тушаалтнууд уг гүтгэлгийн

⁵² <https://www.globeinter.org.mn/images/upld/Article19commentsMong21dec2015.pdf>

⁵³ <https://supreme.justia.com/cases/federal/us/376/254/>

мэдээллийг тухайн этгээд санаатайгаар тараасан гэдгийг өөрөө нотлох ёстой” гэж үзсэн. АНУ-ын Дээд шүүх үүнээс хойш энэ төрлийн хэргийг шийдвэрлэхдээ гүтгэлгийн чанартай худал мэдээллийг нэр төрийг нь гутаах зорилгоор санаатай тараасан нь нотлогдсон байх ёстой, энэ тохиолдолд нөхөн төлбөр олгох үндэслэлтэй гэж үзэх болжээ.

Төрийн албан тушаалтан нэр төрийг нь гутаасан худал мэдээлэл, гүтгэлгийн хохирогч болсон тохиолдолд уг худал мэдээллийг тухайн этгээд худал гэдгийг мэдсээр байж, хор хохирол учруулах зорилгоор санаатайгаар бичсэн, ийм санаа зорилготойгоор тараасан гэдгийг батлах, нотлох шаардлагатай. Ийм зарчмыг баримтлахгүй бол Үндсэн хуульд заасан үг хэлэх эрх чөлөө эрсдэлд орно гэж шүүх үзсэн нь өнөөдөр ч олон улсад жишиг болсоор байна.

АНУ-ын Дээд шүүх “Үндсэн хуульд зааснаар иргэд болон хэвлэл нь төрийн үйл ажиллагааг ямар ч болзолгүйгээр шүүмжлэх эрхтэй, иргэн бүр өөрийн санал бодлыг, сонин хэвлэл нь олон нийтийн анхаарал татсан асуудлаар байр сууриа илэрхийлэх эрхтэй. Харин Засгийн газар иргэн болон хэвлэлийн бичсэн, илэрхийлсэн зүйлийг ухаалаг бус, шударга бус, худал хуурамч, хор хохиролтой гэсэн үндэслэлээр хэвлэн нийтлэхийг нь хориглож болохгүй. Ардчилсан нийгэмд гүйцэтгэх засаглал, хууль тогтоох, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд иргэд өөрсдийн шүүмжлэл, санал бодлоо илэрхийлэх эрхтэй, үүнийг гүтгэлэг, худал мэдээлэл гэж хаан, таслан зогсоох ёсгүй” гэж дүгнэсэн юм.

Европын хүний эрхийн шүүх Европын Конвенцын 10 дугаар зүйлийг үндэслэл болгон гүтгэлгийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэхийг буруутгасан шийдвэр гаргасан байна. Уг хэрэг Европын хүний эрхийн шүүхээр 1986 оны 7 дугаар сарын 8-ны өдөр шийдвэрлэгдсэн.⁵⁴ Шүүхээс Лингес Австрийн эсрэг нэртэй хэргийг шийдвэрлэсэн гол үндэслэлээ тайлбарлахдаа улс төрч хүн сэтгүүлчид болон олон нийтийн өмнө нээлттэй байдаг учраас хатуу шүүмжлэлийг ч хүлээн авах бэлтгэлтэй байх ёстой гэж үзжээ. Мөн гүтгэлгийн хэрэгт эрүү үүсгэснээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгмийн “хоточ нохой”-н үүргээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагддаг гэж тайлбарласан байна.

⁵⁴ <http://hudoc.echr.coe.int/fre?i=001-57523>

Гүтгэлгийн холбогдолтой асуудлыг нэг хуулиар, нэг арга замаар шийдэх боломжгүй. Тухайлбал, хэвлэлийн эрх чөлөөнд хамаарах, иргэд төрөө хянах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй холбоотойгоор учир дутагдалтай зохицуулалт олон байна. Бусад улс оронд төрийн албан хаагч болон олон нийтийн зүтгэлтэн (*public figure*) ямар нэг асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэгт өртвөл эхлээд аль нэг шүүхэд хандахаасаа өмнө хэлэлцэгдэж байгаа асуудалтай холбогдуулан тайлбар хийх үүрэгтэй байдаг. Монголд энэ төрлийн зохицуулалт байхгүй тул өөрийг нь шүүмжилсэн эсхүл төрийн албыг ил тод болгох гэсэн үйлдлийг шууд хуулийн байгууллагаар таслан зогсоолгох гэж оролдож байна.⁵⁵

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэхдээ “илт худал мэдээлэл” гэсэн ойлголтод илт худал мэдээлэл, худал мэдээлэл гэсэн аль ч хэлбэрийг хамруулан тодорхой үйл баримт, болсон үйл явдалд тулгуурласан, үнэлэлт дүгнэлт өгсөн, шүүмжилсэн, нэр хүндэд халдсан сөрөг мэдээлэл, гутаасан агуулгагүй мэдээлэл түгээсэн асуудлыг бүхэлд нь хамруулан гэм буруутайд тооцож ял шийтгэж байна. Мөн худал мэдээлэл тараах гэмт хэргийг хууль тогтоогч тодорхойлохдоо субъектив талыг орхигдуулсан байдал (үг гэмт хэргийн объектив болон субъектив талыг тэнцвэргүй тодорхойлсон), шүүх хуулийн практикт худал мэдээлэл тараасан гэмт хэргийг шалгах, шийдвэрлэхдээ мэдээллийг тараасан субъектив санаа зорилгод ач холбогдол өгөхгүй, объектив талын шинжээр буруутгаж байгаа нь олон улсын жишиг, зарчимд нийцэхгүй байна.

Үндсэн хуулийн аравдугаар зүйлд олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ сахин биелүүлэхээр тунхагласны дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах талаар хүлээн авсан Зөвлөмжөө хэрэгжүүлэх, олон нийтийн зүтгэлтнүүд нээлттэй шүүмжлэлд хүлээцтэй хандах, олон нийтийн хараа хяналтад байхаар өөрсдөө сонголт хийснийг хүлээн зөвшөөрсөн хууль тогтоомж санаачлах⁵⁶ шаардлагатай.

⁵⁵ ННФ, Чухал сэдэв хэлэлцүүлгийн тэмдэглэл, 2019.

⁵⁶ [//www.forum.mn/res_mat/2019/UPRFoE-Mongolia2019-RevisedMongLastOct%202019.pdf](http://www.forum.mn/res_mat/2019/UPRFoE-Mongolia2019-RevisedMongLastOct%202019.pdf)

Эрүүгийн хуульд худал мэдээлэл тараах гэмт хэргийг хуульчилж оруулснаар худал мэдээллийн цар хүрээг багасгаж, таслан зогсоож чадна гэж үзэж болохгүй юм. Харин ч нийгмийн чөлөөт дуу хоолойг боогдуулж, олон талт мэдээллийн хүрээг хумих, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөнд илүү айдас, дарамт бий болгон, улс төрийн эрх мэдэл, засаглалыг гажуудуулах эрсдэлтэй. Худал мэдээлэлтэй тэмцэхийн хамт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалах шаардлагатай. Эрүүгийн хуульд заасан “худал мэдээлэл тараах гэмт хэрэг”-ийн зохицуулалт нь мэдээлэгч, шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг дордуулж байна.

Иймд Монгол Улс нь Европын хүний эрхийн шүүх, АНУ-ын Дээд шүүхээр шийдвэрлэж байсан дээрх хэргийн шилдэг жишиг, практик, тэргүүлэх эрдэмтдийн судалгааны бүтээл, дүгнэлт; худал мэдээлэлтэй тэмцэх, үг хэлэх эрхийг хамгаалах талаарх олон улсын байгууллагуудаас гаргаж буй бодлогын зөвлөмж, стандарт зэрэгт тулгуурлан үзэл бодлоо илэрхийлэх эрх, мэдээллийн эрх чөлөөг хамгаалахын зэрэгцээ худал мэдээлэлтэй зөв арга хэлбэрээр тэмцэх бодлого, зарчмыг зөв тодорхойлж, тууштай баримтлах шаардлагатай.

ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны ажлын үр дүнд гарч буй дүгнэлтийг товчлон харуулбал:

1. Хуурамч мэдээлэл нь ардчилсан институт, засаглалд итгэх итгэлийг сулруулж, олон нийтийн санаа бодлыг хутган үймүүлж, мэдээллийн эмх замбараагүй байдлыг үүсгэж, үг хэлэх эрх, хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээ ашиглан хүмүүсийг төөрөгдүүлэн өдөөн турхирч байдаг. Үүний улмаас үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөө нь хуурамч мэдээллийн “хохирогч” болдог байна. Улс орнууд худал мэдээллийн эсрэг баталгаатай, үнэн зөв мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж (мэдээллийн боловсрол олгох, мэдээллийн технологийн шинэчлэл, өөрчлөлт ашиглах, мэдээллийг нягтлах үйл ажиллагаа, эрх зүйн арга гэх мэт), үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалахын зэрэгцээ гадаад, дотоодын гарал үүсэлтэй худал мэдээлэлтэй идэвхтэй тэмцэх болжээ.
2. Монгол Улсад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн хүрээнд 2020 онд 251, 2021 оны эхний дөрвөн сарын байдлаар 119 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэснээс 25 хэрэгт л яллах дүгнэлт үйлджээ.⁵⁷ 2020 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан 10 гэмт хэрэг хянан шийдвэрлэсэн байна.⁵⁸ Эндээс худал мэдээлэл тараасан асуудлаар цагдаагийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, хэрэгсэхгүй болсон хэргийн тоо олон, харин шүүхэд шилжүүлсэн хэрэг цөөн байгаа нь анхаарал татлаа. Учир нь үг хэлэх эрх, нэр төртэй холбоотой иргэний хэргийн шинжтэй асуудлыг хамруулан

⁵⁷ УЕПГ-ын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 4/3650 албан бичиг

⁵⁸ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 01/507 албан бичиг

эрүүгийн журмаар хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, удаан хугацаагаар шалгаж байгаа нь мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг “дарамт”-д оруулж байна. Илтэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээний асуудал, иргэний маргааны шинжтэй өргөдөл, гомдлыг хүлээн авахгүй байх, эрүүгийн журмаар шалгахгүй байх асуудлыг нэн даруй шийдвэрлэх нь тулгамдсан асуудал болжээ.

Нөгөө талаас олон нийтийн сүлжээнд бусдын нэр төрийг гутаах, доромжлох агуулгатай, иргэний хэргийн шинжтэй худал мэдээлэл цацагдсан тохиолдолд уг этгээдийг иргэний журмаар хариуцагчаар татаж шүүхэд өгөхөд хариуцагчийн нэр, хаяг нь тодорхойгүй тул шүүхэд хандахад ихээхэн хүндрэлтэй байгаа тул иргэд цагдаагийн байгууллагад шууд хандах тохиолдол ихэсжээ.

3. Хууль тогтоогч 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг нэмэлтээр оруулсан бөгөөд энэ гэмт хэрэг нь “нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэж объектив талын шинжээр тодорхойлогдсон, 2002 оны Эрүүгийн хуульд байсан “гүтгэх” гэмт хэргээс өргөн агуулга, хүрээтэй, шинэ хэв шинж бүхий гэмт хэрэг болжээ.
4. Хууль тогтоогч уг гэмт хэргийг “олон нийтэд тараасан бол” гэж объектив талын шинжээр нь тодорхойлж, субъектив талын шинжийг бүрхэгдүүлэн, худал мэдээлэл нь “гутаасан, гутаах” зорилго, агуулга, шинжтэй байх эсэхийг бүрэн гүйцэд тодорхойлоогүй орхигдуулж, нэр томьёо, ойлголтын зөрүүтэй байдал, мөн уг хуулийн төслийг боловсруулан анх өргөн мэдүүлэхэд төсөлд тусгагдсан байсан уг зүйлийн “Энэ гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллага хамаарахгүй. Үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийг гэмт хэрэгт хардсан, сэрдсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй” гэсэн тайлбарыг хассан. Энэ нь хууль зүйн техникийг бүрэн бүрдүүлэх шаардлагыг алдагдуулж, хууль бүтээх ажиллагааны алдаа буюу эрх зүйн хийдэл үүсгэж, үг хэлэх эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн байдлыг дордуулан,

өнөөдөр хууль хэрэглээ, шүүхийн практикт сөрөг үр дагавар үүсгэж буй гол шалтгаан болжээ гэж үзэх үндэстэй байна.

Онолын хувьд худал мэдээлэл тараах гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрт хамаарч байгаа боловч хүний нэр төр, алдар хүндийг гутаах санаа зорилгогүй, алдаатай, худал мэдээлэл тараасан үйлдэл ч уг зүйлээр эрүүгийн хариуцлагад татагдаж байна. Субъектив талын хувьд гэмт этгээд бусдын нэр төр, алдар хүндэд хохирол учруулах гэсэн шууд санаатай үйлдлээр илрэх ёстой боловч сэдэлт болон хүний нэр, алдрыг гутаах зорилгыг хууль тогтоогч заагаагүй тул заавал шаардах нөхцөл биш юм. Цаашид Эрүүгийн хуулийн “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн бүрэлдэхүүнд субъектив шинжийг нэмж тусгах шаардлагатай.

5. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт хууль тогтоогч “худал мэдээлэл” гэсэн ерөнхий нэр томъёог хэрэглэсэн нь уг гэмт хэрэгт хамрах худал мэдээллийн хүрээг илтэд өргөжүүлжээ. Хууль зүйн нэр томъёоны хувьд “гүтгэх”, “илт худал гүжирдлэг” гэж тодорхойлж ирсэн хууль зүйн уламжлалт нэр томъёо, ойлголтыг анхаарч үзээгүй. Худал мэдээллийн хэлбэрүүд болох (i) хуурамч мэдээлэл, (ii) алдаатай мэдээлэл, (iii) буруу сэдэлтэй мэдээлэл тараасан бүхий л үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэс бүрджээ. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг, мөн Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасан “нэр төрийг гутаасан мэдээ” бүхий иргэний маргаан, эрх зүйн зөрчил нь хоорондоо ямар ялгаатай болох, ялгагдах шинж, хэрхэн ялгаж зүйлчлэх асуудлаар Улсын Дээд Шүүх албан ёсоор тайлбарлах шаардлагатай байна. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасан “гутаасан мэдээ” нь худал мэдээлэл болон үнэн мэдээллийг давхар агуулдаг. Иргэний хуулийн 21.3-т бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол няцаах үүрэг хүлээхээр зохицуулсан. Иргэний хуулиар зохицуулж буй гутаасан мэдээ буюу бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол уг асуудал нь Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт тооцогдох ёсгүй. Энд тодорхой түвшинд эрх зүйн давхардал үүсжээ.

6. Эрүүгийн хуульд зөвхөн “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг хуульчилж оруулснаар нийгэмд тархаж буй худал мэдээллийн цар хүрээг багасган, таслан зогсоож чадна гэж үзэж болохгүй юм. Харин ч нийгмийн чөлөөт дуу хоолойг боогдуулж, олон талт мэдээллийн хүрээг хумих, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөнд илүү айдас, дарамт учруулж, улс төрийн эрх мэдэл, засаглалыг гажуудуулах, эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах явдалд олон нийтийн хяналтыг үгүй болгон, шийдвэр гаргагчийн зүгээс шүтэл үлээгч, шүүмжлэлт дуу хоолойг хааж боох, дарамт шахалт үзүүлэх арга хэрэгсэл болж, нийгэмд сөрөг үр дагавар бий болгож байгааг анхаарах шаардлагатай байна.
7. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг 2020, 2021 онд шийдвэрлэсэн шүүхийн зарим шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийж үзэхэд бусдын нэр төрийг гутаах зорилгоор илт худал мэдээлэл, гүтгэлгийг санаатай зохиож тараасан этгээдэд хариуцлага оногдуулж байгаа шийдвэр, зөв жишиг байна. Гэхдээ хууль хэрэглээ, шүүхийн практикт энэ төрлийн хэргийг шийдвэрлэхдээ хүний эрхийг зөрчсөн, мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан цөөнгүй тохиолдол гарчээ. Нэр хүндэд халдсан гэдэг нь заавал нэр төрийг гутаасан гэсэн агуулгыг бүрэн илэрхийлэхгүй. Гутаасан агуулга байхгүй ч нэр хүнд, эрх ашиг хөндөгдсөн бол халдсан гэж үзэж гомдол гаргах, түүнийг цагдаагийн байгууллага хүлээн авч шалгах, “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг үйлдэгдсэн хэмээн цагдаагийн байгууллага үзэж, уг мэдээллийг олон нийтийн сүлжээгээр гаргасан, тараасан этгээдийг дуудах, тайлбар, мэдүүлэг авах болжээ. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхдээ “илт худал мэдээлэл” гэсэн ойлголтод тодорхой үйл баримт, болсон үйл явдалд үнэлэлт дүгнэлт өгсөн, шүүмжилсэн, тодорхой үндэслэл бүхий боловч нэр хүндийг гутаасан, түүнд халдсан, бодит баримтыг бүрэн гүйцэд бус, алдаатай мэдээлэл тараасан, сөрөг мэдээллийг хамруулан тухайн мэдээлэл худал боловч тухайн хүний нийгэмд үнэлэгдэх чанарыг дордуулаагүй, тухайн этгээдийн нэр төрийг гутааж байгаа боловч уг этгээдийн зан төлөв, үйл ажиллагаанд илэрсэн

асуудлыг хөндсөн, бодит байдалд андуу ташаа, алдаатай дүгнэлт хийх, эх сурвалжаа нягтлаагүй алдаа гаргаж мэдээлэл тараасан зэрэг асуудлыг эрүүгийн журмаар шалгаж, шүүхээс гэм буруутайд тооцох асуудал гарч байгаа нь үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөөнд ихээхэн хор уршиг учруулж байна.

8. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэт нэг талыг барьсан, хэргийн нотолбол зохих нөхцөл байдлыг бүрэн шалгаж тогтоохгүйгээр зөвхөн гомдол, өргөдөл гаргагч этгээдийн өгсөн мэдээлэл, баримтад тулгуурлан үнэн, худлыг шүүн дүгнэлт хийж, мэдээлэл тараасан этгээдийг буруутгах хандлага, практикт нийтлэг байна. Мөн энэ төрлийн хэрэгт гомдол гаргах, шалгах, шийдвэрлэхэд төрийн байгууллага, албан тушаалтан давуу байдалтай оролцох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдөх, хэрэгт шалгагдаж байгаа иргэд нь хууль зүйн туслалцаа авахгүй, өмгөөлөгчгүйгээр хэрэг шалгах ажиллагаанд оролцох явдал түгээмэл байх бөгөөд үүний улмаас яллах, буруутгах ажиллагаа илүү давамгайлж байгаа байдал ажиглагдлаа.
9. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд тараасан мэдээллийг “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт сэрдэн шалгах, улмаар шүүхээр ял шийтгэх тохиолдол гарчээ. Сэтгүүлч бол мэдээллийг хайх, олж авах, түгээх, хэвлэн нийтлэх эрхтэй бөгөөд энэ нь сэтгүүлчийн үндсэн ажил, мэргэжлийн үйл ажиллагаа болно. Сэтгүүлчийн үйл ажиллагаа нь бусдын нэр төрийг санаатай гутаах зорилготой үйлдэл биш юм. Мэргэжлийн үйл ажиллагаанаас үүдсэн худал мэдээлэлтэй холбоотой асуудлыг Эрүүгийн гэмт хэрэгт холбогдуулан шалгах, гэм буруутайд тооцсон явдал нь хэвлэл мэдээллийн чөлөөт байдлыг хангах зарчимд нийцэхгүй байна.
10. Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйл “Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих” (Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэлийн талаар олон нийтийг төөрөгдүүлэх мэдээ, мэдээлэл түгээх зэрэг асуудал) зөрчил 2020 онд 1790 гарснаас, хялбаршуулсан журмаар 667 зөрчлийг шалган шийдвэрлэж,

зөрчлийн 1123 хэрэг нээн шалгаж, 1480 хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулжээ. 2020 онд 190 зөрчлийн хэрэг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн байна. Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлд заасан “Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих” зөрчлийн “Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэлийн талаар олон нийтийг төөрөгдүүлэх мэдээ, мэдээлэл түгээсэн” гэдгийг онолын болон хууль хэрэглээний практикт хэрхэн ойлгож хэрэглэж байгаа нь анхаарал татаж байгаа бөгөөд энэ чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байна.

11. ХБНГУ, ОХУ-ын Эрүүгийн хуулийн гүтгэхтэй холбоотой зүйл, заалтыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн зүйл, заалттай харьцуулан авч үзэхэд уг гэмт хэргийн субъектив талын шинжийг илүү тодорхой тусгасан байна. Харин манай улс худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хэргийн объектив шинж чанарыг гол шинж болгон авч үзэж, хэргийн чухал бүрэлдэхүүн болсон гэмт санаа зорилго болох субъектив талыг орхигдуулсан нь ХБНГУ, ОХУ-ын Эрүүгийн хуультай харьцуулан авч үзэхэд ухралт болжээ. Монгол Улсын хувьд 1986 оны болон 2002 оны Эрүүгийн хуулиудад гүтгэх гэмт хэргийн объектив талыг “илт худал гүжирдлэг” тараах гэж, субъектив талыг “бусдын нэр төрийг гутаах зорилгоор” гэж тодорхойлж байжээ.

12. Олон улсад үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөөний тулгуур зарчим, жишиг, стандарт тогтож хөгжсөн байна. Монгол Улсад нутагшуулах шаардлагатай жишиг зарчим, стандарт нь манай ардчиллын цаашдын зөв хөгжилд тулгуур болох ач холбогдолтой.

Европын хүний эрхийн шүүх Европын Конвенцын 10 дугаар зүйлийг үндэслэл болгон гүтгэлгийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэхийн эсрэг шийдвэр гаргасан байдаг. Шүүхээс Лингес болон Австрийн эсрэг нэртэй хэргийг шийдвэрлэхдээ “улс төрч хүн сэтгүүлчид болон олон нийтийн өмнө нээлттэй байдаг учраас хатуу шүүмжлэлийг ч гэсэн хүлээн авах бэлтгэлтэй байх ёстой” гэж үзсэн. Гүтгэлгийн хэрэгт эрүү үүсгэснээр хэвлэл мэдээллийн

хэрэгслийн нийгмийн хоточ нохойн үүргээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагддаг гэж тайлбарласан. Уг жишиг стандарт бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон олон нийтийн зүтгэлтэн, улс төрчид холбогдох зарчим юм. Шүүхээс хэвлэлийн эрх чөлөө нь олон нийтэд улс төрийн удирдагчдын үзэл санаа, хандлагыг олж илрүүлэх, санал бодлыг нь хүргэх хамгийн сайн арга хэрэгсэл болдог. Ерөнхийдөө улс төрийн мэтгэлцээний эрх чөлөө нь ардчилсан нийгмийн үзэл баримтлалын гол цөм юм. Конвенцоор хувь хүний нэр хүндийг хамгаалах боломжийг олгодог ч энэ хамгаалалт нь улс төрчдөд ч гэсэн хувь хүнийх нь хувьд хамаатай. Гэхдээ энэ нь улс төрийн асуудлыг нээлттэй хэлэлцэх ашиг сонирхлыг хаах үндэслэл болохгүй гэж үзсэн. Олон нийтийн зүтгэлтэн, улс төрчид нь олон нийтийн өмнө нээлттэй байдаг бөгөөд эдгээр улс төрч ард иргэдийн санал, итгэлээр сонгогдож, томилогдсон тул олон нийтийн хараа хяналт дор, тэдний өмнө нээлттэй байж, иргэдийн хатуу шүүмжлэл, хардлагад тэвчээртэй хандах учиртай гэж дүгнэжээ.

Мөн АНУ-ын Дээд шүүхийн 1964 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн шийдвэрийг энд дурдаж болно.

Энэхүү судалгааны ажлын үр дүнд дор дурдсан санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн зүйл, заалтыг судалгааны дүгнэлт, шинжилгээнд тулгуурлан үг хэлэх, мэдээллийн эрх чөлөөг хамгаалах зарчмыг хангах үүднээс эрх зүйн хийдлийг арилгаж шинэчлэн найруулах арга хэмжээ авах, цаашид олон улсын хүний эрхийн байгууллагын зөвлөмж, саналын дагуу Эрүүгийн хуулиас халах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
2. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, цагдаагийн мөрдөгч, алба хаагчдыг үг хэлэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөө, худал мэдээлэл, түүний төрөл хэлбэр, түүнтэй тэмцэх арга механизмын тухай мэдлэг боловсрол олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах;

3. Улс төрийн мэтгэлцээний эрх чөлөө, иргэдийн хувьд үгээ чөлөөтэй хэлэх, шүүмжлэх, хардах эрхийг хамгаалах, улс төрч, шийдвэр гаргагчийг шүүмжлэн хардсан үзэл бодлоо илэрхийлж, улмаар цагдаагийн байгууллагад дуудагдан, шалгагдаж буй өнөөгийн бодит нөхцөл байдлыг арилгах үүднээс Монгол Улсын хууль тогтоомжид ард иргэдийн санал, итгэлээр сонгогдсон улс төрчид, томилогдсон албан тушаалтан нь иргэдийн хатуу шүүмжлэл, хардлагад тэвчээртэй хандах, уг асуудлаар цагдаагийн байгууллагад гомдол, өргөдөл гаргаж иргэдэд дарамт шахалт үзүүлэх биш харин нэн даруй мэдэгдэл, хариу тайлбар өгөх, холбогдох нотлох баримтыг ил тод болгох, олон нийтэд түгээх, гаргах үүргийг зарчим, зохицуулалт болгож тусгах;
4. Эрүүгийн хуульд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргээр шалгагдаж буй иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээ авах;
5. Худал мэдээлэлтэй тэмцэх, түүнийг таньж мэдэх, шалгаж нягтлах, няцаах оролдлого, үйл ажиллагааг дэмжих үүднээс иргэд, олон нийтэд зориулсан хэвлэл мэдээллийн мэдлэг дээшлүүлэх хөтөлбөр, нийгмийн сүлжээний компаниудтай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах;
6. Үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалахын зэрэгцээ худал мэдээлэлтэй тэмцэж буй олон улсын туршлага, зохицуулалтын талаар нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийх;
7. Олон нийтийн сүлжээнд бусдын нэр төрийг гутаах, доромжлох агуулгатай, иргэний хэргийн шинжтэй худал мэдээлэл цацагдсан тохиолдолд уг этгээдийг иргэний журмаар хариуцагчаар татаж, шүүхэд өгөхөд хариуцагчийн нэр, хаяг тодорхойгүй байх нь иргэд, байгууллагад хүндрэл учруулж байгааг анхаарч, энэ төрлийн хэрэг маргааныг шуурхай шийдвэрлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах, хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах;

8. Эрүүгийн хуулийн “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг Иргэний болон Зөрчлийн тухай хуульд заасан нэр төр гутаах, худал мэдээлэл тараах эрх зүйн бусад зөрчлөөс хэрхэн ялгаж тайлбарлах, зөв хэрэглэх талаар Улсын дээд шүүхээс тайлбар гаргах;
9. Гадаад, дотоодын гарал үүсэлтэй худал мэдээлэлтэй тэмцэх бодлого, стратегийн баримт бичиг боловсруулах.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Монгол Улсын Иргэний хууль, 2002.
3. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015.
4. Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, 2017.
5. Жон Стюарт Милль, Эрх чөлөөний тухай, УБ., 2021.
6. Монгол, Орос, Хятад, Герман улсуудын Эрүүгийн хууль, МУИС-ийн ХЗС, орчуулсан Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Батбаяр, Т.Золбоо, УБ., 2021.
7. Глоб интернейшнл төв, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан, 2020.
8. Нээлттэй Нийгэм Форум, “Чухал сэдэв” хэлэлцүүлгийн тэмдэглэл, 2019.
9. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 1989.
10. Т.В.Кашанина, Хууль зүйн техник, УБ., 2016.
11. УДШ, Ханнс-Зайделын сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010.
12. Нью Йорк Таймс болон Л.Б.Сулливаны хэргийг шийдвэрлэсэн АНУ-ын Дээд шүүхийн шийдвэр (1964).
13. Лингес болон Австрийн хэргийг шийдвэрлэсэн Европын хүний эрхийн шүүхийн шийдвэр (1986).
14. Парламентын судалгааны хүрээлэн, Цахим болон мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төрийг гутаах, гүтгэх, доромжлох, хуурамч мэдээлэл тараах үйлдэлд хүлээлгэх хариуцлага, Боть 24 (2017).
15. МУИС, Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг, УБ., 2020.
16. Ц.Ган-Оч, Б.Доньжчимбуу, Мэдээллийн эрх зүй, УБ., 2019.
17. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2016.

ХАВСРАЛТ

Хавсралт 1

Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шийдвэрлэсэн
шүүхийн шийдвэрийн дэлгэрэнгүй шинжилгээ

№	Шийтгэх тогтоол	Огноо, дугаар	Тогтоолын агуулга
2020 он			
1.	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол	2020.4.3, №00112	Б өөрийн фейсбүүк хаягаас “Хөвсгөл аймгийн нэгдсэн зар” группэд “Аймаг тойрсон эргүүлийн албаныхан яагаад бизнес эрхлээд байгаа юм бэ, та нар орж гарахад хармааны мөнгө хийх зүгээр үү?” гэсэн илт худал мэдээллийг олон нийтэд тарааж, хорио цээрийн дэглэмийн үед уртагдсан цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 550,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.
2.	Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол	2020.4.30, №98	Т.Ц нь фейсбүүкийн “Сэлэнгэ зар” гэх бүлэг дээр “Тог Тог” гэх фейсбүүк хаягаас иргэн Э, Д нарын зургийг оруулаад түүнийхээ дор “...гэр бүл салгаж, ажил дээрээ явалддаг ...дүгээр цэргийн ангийн алба хаагчид” гэсэн пост оруулсан нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан” илт худал мэдээллийг олон нийтэд тараасан учир ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.

3. Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол	2020.5.13, №82	Т.М нь https://urug.mn мэдээллийн сайтад өгсөн “Франц Улсын иргэн хоёр биеэ үнэлэгч аваагүй болох нь тогтоогдсон” хэмээн ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн төвийн ажилтан М-ийн ярилцлага доор нь “өөрөө янхан юм байна шүү дээ энэ цагдаа хүүхэн чинь” гэсэн сэтгэгдэл бичсэн нь худал мэдээлэл тараах гэмт хэрэг мөн гэж дүгнээд 500 нэгжээр торгох ялаар шийтгэсэн.
4. Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол	2020.7.3, №106	Н.М-ийг Увс аймгийн нэгдсэн групп фейсбүүк хаяг ашиглаж Э, Б, С, Х, И нарын таван иргэний нэр төр, алдар хүндэд халдсан илтэд худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн гэж дүгнээд 900,000 төгрөгөөр торгох ял оногдуулжээ.
5. Ховд аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол	2020.8.19, №143	Б нь фейсбүүк сүлжээ ашиглан иргэн О-гийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг (энэ эмэгтэй бол янхан, худлаа хэлээд янхандаж явдаг, айлын нөхөртэй явалдана, 3-4 залуутай зэрэг явалдах чинь янхандалт мөн биз дээ) олон нийтэд тараасан буюу худал мэдээлэл тараах гэмт хэрэг үйлдсэн учир ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.

2021 он

<p>1. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол</p>	<p>2021.1.12, №48</p>	<p>Э нь үргэлжилсэн үйлдлээр Б.У-тай бүлэглэн “У” компанийн захирал Л-ийн талаар “...энэ хүнд ухамсрын шанаа өгөөч Ерөнхий сайдаа, энэ хүн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёрыг би харцаараа хөдөлгөдөг гээд цээжээ дэлддэг болжээ, арай ч тиймдээ тулаагүй байлгүй дээ”. Мөн “...төрийн агентлагаас дээгүүр эрх мэдэлтэй Л нь Богд уулын аль ч аманд газар авч чадна хэмээн бусдыг залилдаг ба ямар ч хариуцлага хүлээгээгүй байна, жишээ дурдахад Зайсанд барьсан “ХТ” хотхоныг улсын комисс хүлээж аваагүй байхад Ерөнхий сайдын баруун гар гэж өөрийгөө ярьдаг дүү нь дур мэдэн айлуудыг оруулсан байх юм, тэднийг дураараа дургихад хотын дарга Амарсайхан толгойг нь илдэг” гэсэн илт худал мэдээлэл, гэрэл зургийн хамт нийтэлсэн нь гэмт хэргийн шинжтэй гэж үзээд 1,300,000 төгрөгөөр тус тус торгох ялаар шийтгэжээ.</p>
<p>2. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шийтгэх тогтоол</p>	<p>2021.2.25, №09</p>	<p>Б.У нь Улаанбаатар хотод байхдаа фейсбүүк хаягаасаа “УИХ-ын гишүүн Д нь хайрганы уурхай дээрээ гурван автобус хятад иргэдийг оруулж ирсэн мэдээлэл бидэнд ирлээ, мөн Д-гийн Төмөртэйн ордны нөөцийг хятад эзэд зарсан” гэж Д-гийн нэр төр, алдар хүндэд халдан, илт худал мэдээллийг олон нийтэд, цахим сүлжээ фейсбүүкээр тараасан гэмт хэрэг үйлдсэн гэж дүгнээд ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.</p>

3.	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол	2021.3.15, №2021/ШЦТ/340	Г.М-ийг иргэн Ц-гийн царай төрх бүхий зургийг ашиглаж “...энэ хүнийг таних уу, утас хулгайлчихлаа, бичлэг нь байгаа, арай ч ийм юм хийхгүй байх гэж бодсон чинь авсан байх юм” гэсэн сэтгэгдэл фейсбүүк хуудсандаа байршуулж хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн.
4.	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн шийтгэх тогтоол	2021.3.19, №149 /ШТ/ 0022	Х нь фейсбүүкийн “Гурван төв зар” гэх нэртэй олон нийтийн сүлжээнд насанд хүрээгүй Э, О нарын зургийг байршуулж “...энэ охидоос болгоомжил, гэр эзгүйчилж хүний нөхөртэй явалдаж айл гэр үймүүлдэг балиар юмнууд, ...дүгээр сургуульд сурдаг эцэг эхийг нь таньж мэддэг хүн байна уу, би олон удаа сануулж хэлсэн” гэх мэдээллийг байршуулж хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэгт холбогджээ.
5.	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол	2021.3.29, №414	Б нь өөрийн фейсбүүк хуудсандаа “...УИХ-ын сонгуульд нэр дэвшигч Г-гийн талаар залилах гэмт хэрэгт хамтран оролцсон, Х намын гишүүн байсан, М-ийн дэд захирал байхдаа оюутны дүн зассан” зэрэг мэдээллийг нийтэлсэн учир ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар торгох ялаар шийтгэжээ.

<p>6. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол</p>	<p>2021.3.30, №427</p>	<p>Т гэгч нь өмнө үерхэж байсан О-гийн гэрэл зургийг ашиглан хуурамч фейсбүүк хаяг нээж садар самуун агуулга бүхий нийтлэл бичиж түүний нэр төрд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан. О-гийн нэр дээр нээсэн фейсбүүк хаягаасаа Санхүү, тусламж гэсэн бүлэгт нэгдэж улмаар биеэ үнэлж санхүү авна гэсэн утгатай зар байршуулсан ба уг зарын дагуу олон хүн холбогдсоны улмаас гар утасны дугаараа сольсон байна.</p>
<p>7. Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол</p>	<p>2021.4.8, №2021 /ШЦТ /229</p>	<p>С нь иргэн О-гийн гар утасны дугаарыг “Халуухан дагина” гэх фейсбүүк бүлэгт “...санхүү авна, дуудлагаар үйлчилнэ, 35 настай царайлаг бүсгүй, утас 91.....” гэх утгатай байршуулж хүний нэр төрд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан.</p>

№1. ИРГЭН Б-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч агуулга

Шүүгдэгч Б.Б нь 2020 оны 2 дугаар сарын 29-ний өдөр “Б.Б” гэсэн өөрийн фейсбүүк хэрэглэгчийн хаягаас “Хөвсгөл аймгийн нэгдсэн зар” группэд “Аймаг тойрсон эргүүлийн албаныхан яагаад бизнес эрхлээд байгаа юм бэ, та нар орж гарахад хармааны мөнгө хийх зүгээр үү?” гэсэн илт худал мэдээлэл олон нийтэд тарааж, хорио цээрийн дэглэмийн үед уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож Хөвсгөл аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн №00112 тоот шийтгэх тогтоолоор 550,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.

Дүн шинжилгээ

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу иргэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хардах, шүүмжлэх эрхтэй бөгөөд иргэн өөрийн үгийн ухамсарласан эсвэл таамагласан үзэл бодлын улмаас ямар ч хүн ИБУТЭОУП-аар хамгаалагдсан аливаа эрхээ эдлэхдээ хохирох ёсгүй. Үүнтэй холбоотойгоор өөр үзэл бодолтой байхыг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэн хариуцлага хүлээлгэх нь буруу. Төр засгийн алба хаагчид хатуу шүүмжлэл, хардлагад тэвчээртэй хандах хэрэгтэй бөгөөд энэ тохиолдолд хариу няцаалт, тайлбар хийж, олон нийтийг бодитой мэдээллээр хангах нь зөв юм.

Монгол Улс Үндсэн хуулиараа олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх бөгөөд нэгдэн орсон гэрээ, конвенц нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэхээр заасан.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “...хүнийг үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэсэн заалт нь энэ эрхийг хамгаалж буй зохицуулалт мөн. Үзэл бодол, хардлага, шүүмжлэл, алдаатай мэдээлэл тараасан шалтгаанаар баривчлах, саатуулах, шүүж шоронд хорих, торгох, дарамт

үзүүлэх, айлган сүрдүүлэх нь Пактын 19 дүгээр зүйлийг зөрчсөнд тооцогдоно.

Иргэний өөрийн цахим хуудсаараа бичсэн сэтгэгдэл нь иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн хэлбэр болно. Шүүхийн шийдвэрт энэ гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд хэнийг хамаатуулж ойлгож байгаа нь тодорхой бус байна. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол” гэх гэмт хэрэгт тооцохоор заасан. Нэр хүндэд халдсан гэдэг нь заавал гутаасан гэсэн агуулгыг бүрэн илэрхийлэхгүй бөгөөд харин нэр хүнд нь хөндөгдсөн бол халдсан гэж гомдол гаргах үндэслэл болжээ.

Тухайлбал, “Хорио цээрийн дэглэмийн үед уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон үйлдэл хийгдсэн байна” гэж шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт дурджээ. Шүүх хуулийн этгээдийн болон хувь хүний нэр төрийн аль нь хохирсон болохыг тодорхойлолгүйгээр төрийн албан хаагчдын нэр хүнд гэж авч үзэхдээ өөрийн дотоод итгэл үнэмшлээр “уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэж байгаа” гэх ач холбогдолгүй урьдчилсан нөхцөлийг оруулж хэт яллах талыг барьж хэргийг шийдвэрлэсэн байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад нотолбол зохих байдлыг бүрэн хангасан гэж шүүх дүгнэсэн ч бодит байдалд үнэхээр 30,000 төгрөгөөр торгуулаад Хөвсгөл аймагт орж ирсэн, гарч явсан хүн байгаа эсэхийг огт тодруулалгүйгээр “худал мэдээлэл” гэсэн дүгнэлт хийж, шийдвэрлэжээ.

Үүнээс дүгнэхэд анхан шатны шүүхийн шийдвэр нь гэм буруугийн зарчмыг үндэслээгүй бөгөөд хэт нэг талыг барьсан, хэргийн нотолбол зохих нөхцөл байдлыг бүрэн шалгаж тогтоолгүй шийдсэнээс гадна шүүгч хэдий өөрийн дотоод итгэлд үндэслэн хэргийг шийдэх ч шийдвэр нь ямагт үндэслэлтэй, тэрхүү үндэслэл нь хууль зүйн шинжлэх ухаанд тулгуурласан байх учиртай.

Шүүгчийн дотоод итгэл гэдэг нь хувь хүний асуудалд хандах сэтгэл зүйн хандлага биш, хувийн итгэл үнэмшил ч биш бөгөөд аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой баримтын хүрээг

зөв тодорхойлж, эх сурвалжийг тогтоосон, тэдгээр нь хөдөлбөргүй нотлогдсон талаар хуульчийн мэргэжлийн ур чадварт тулгуурласан итгэл үнэмшил юм. Уг итгэл үнэмшлээ хуульд нийцүүлж гаргасан шийдвэрээр баталгаажуулж байдаг.

Шүүхийн шийдвэрийн чанар нь шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтад хийсэн дүгнэлт, харьцуулалт, хууль тогтоомжийн агуулгыг тайлбарласан байдал, шийдвэр бүхэлдээ эргэлзээгүй, ойлгомжтой, тодорхой байх шинжээр хэмжигддэг.

Үндсэн эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд олон улсын хэм хэмжээг баримтлаагүй бөгөөд дотоодын хууль тогтоомжид л үндэслэн, яллах нэг талыг барьж шийдвэрлэжээ. Иргэн Б нь илт худал мэдээллийг санаатай зохиож тараагаагүй бөгөөд тодорхой эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн санал бодол, шүүмжээ илэрхийлсэн байна. Түүний тараасан мэдээлэл алдаатай байж болох ч түүний энэ үйлдлийг гэмт хэрэгт тооцох нь Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, олж авах, түгээх, интернэтийн эрх чөлөөг хязгаарласан хэрэг юм.

Алдаатай мэдээлэл (Misinformation) гэдэг нь төөрөгдүүлсэн мэдээллийг санамсаргүйгээр тараах явдал юм. Энэ нь шалгаж тогтоож болохуйц фактуудын талаарх нийтэд тогтсон ойлголттой зөрчилдсөн, мушгин гуйвуулсан мэдээлэл бөгөөд үүнийг хүмүүс бусдыг хууран мэхлэх сэдэлгүйгээр, алдаа гаргаж тараадаг. Алдаатай мэдээлэл худал агуулгатай боловч тухайн мэдээллийг хуваалцаж буй хүн худал эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл агуулж байгааг ухаж ойлгоогүй байдаг. Алдаатай мэдээлэл нь бүхэлдээ худал байх албагүй бөгөөд алдаа гаргасан нь зориуд бус, санамсаргүй байдалтай буюу мэдээллийг алдаа гаргасны улмаас тараасан байдаг.

Алдаатай мэдээлэл = худал мэдээлэл + алдаа

Иргэн Б алдаатай мэдээлэл тараасан гэдгээ ойлгомогц уг мэдээллийг оруулснаас хойш удалгүй өөрийн фейсбүүк хуудаснаас устгасан байдаг. Иргэн Б санаанаасаа худал зүйл зохиож, бусдын нэр хүндийг гутаах зорилго агуулаагүй, тодорхой эх сурвалж буюу бусдын ярьсан зүйл,

мэдээ сэлтэд тулгуурлан мэдээлэл тараасан. Уг мэдээлэл нь тодорхой үйл явдал, гэрчийн мэдээлэлд тулгуурласан нь худал мэдээлэл тараасан гэмт хэрэгт тооцох үндэслэл болохгүй.

Хэрэг хянан шийдвэрлэх явцад иргэн Б хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлээгүй, өмгөөлөгчгүйгээр шүүх хуралд оролцжээ. Шүүх шийтгэх тогтоолдоо “...шүүгдэгч нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэхдээ өөрийн үйлдлийн хууль бус шинжийг ухамсарлаж, илтэд худал мэдээллийг олон нийтэд тарааж, хор уршигт хүргэж үйлдсэн нь гэм буруугийн санаатай, хэлбэртэй, төгссөн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэлтэй байна” гэжээ.

Уг хэрэгт хохирогч тодорхойгүй буюу хорио цээрийн дэглэмийн үед уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон илт худал мэдээллийг тараасан хэмээн үзэж, ял шийтгэсэн нь “төрийг үл хүндэтгэх үзэл баримтлал”-ыг шийтгэж буй хэлбэр гэж үзэхээр байна. Төрийн нэр хүндийг гутаасан, гүтгэсэн, доромжилсон, худал мэдээлэл тараасан гэж иргэнийг яллах нь Үндсэн хууль зөрчсөн хэрэг болно. Гүтгэлгийн эсрэг хуулийн хэд хэдэн үзэл баримтлал байх бөгөөд энэ дотроос хамгийн эртнийх нь төрийн эрх мэдэл бол бурхны таалал, хаан бол бурхны хүү, бурхны хүүг шүүмжилж, эсэргүүцэж болохгүй гэх үзэл юм. Тус үзлээр эзэн хааны нэр хүндэд халдсан, төрийг шүүмжилсэн, доромжилсон хүнийг хатуу шийтгэдэг.

АНУ 200 жилийн өмнө “төрийг үл хүндлэх үзэл баримтлал”-аас татгалзсан бөгөөд профессор Харри Калвен “төрийг үл хүндлэх гэдэг нь дэлхийн хэмжээний нийт хаалттай нийгмүүдийн таних тэмдэг бөгөөд хуульд төрийг үл хүндлэх гэсэн үзэл баримтлал орсон эсэхээр тухайн нийгмийг тодорхойлдог” гэжээ. Энэ шүүхийн шийдвэрээс үзэхэд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг “төрийг үл хүндлэх үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлжээ гэж үзэх үндэслэлтэй байна.

№2. ИРГЭН Ц-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч агуулга

Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 98 тоот шийтгэх тогтоолоор Т.Ц нь фейсбүүкийн “С зар” гэх бүлэг дээр “Т... Т...” гэх фейсбүүк хаягаас иргэн Э, Д нарын зургийг оруулаад түүнийхээ дор “...гэр бүл салгаж, ажил дээрээ явалддаг ...дүгээр цэргийн ангийн алба хаагчид” гэсэн пост оруулсан нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан” илт худал мэдээллийг олон нийтэд тараасан учир ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.

Дүн шинжилгээ

Шүүгдэгч Т.Ц хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, тэрээр өөрөөс нь мөнгө зээлээд өгөхгүй байсан Э-рүү гар утсаараа удаа дараа залгасан боловч Э нь утсаа авахгүй зугтаж, харин өмнөөсөө Д-ээр утсаа авхуулж Д нь “...мөнгө өгөхгүй, чи мэдрэл муутай гээ биз дээ, шар хаданд очиж эмчлүүл” гэсэн доромжлол хэлсний хариуд дээрх байдлаар фэйсбүүк хуудаснаа худал мэдээлэл тараажээ. Энэ нь Э, Д нарын нэр хүндийг гутаасан мэдээлэл байв.

Шүүх шийтгэх тогтоолдоо “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан нь хавтаст хэрэгт цуглуулж бэхжүүлсэн баримтуудаар нотлогдсон, шүүгдэгч Т.Ц-гийн гэмт үйлдлийн улмаас албан байгууллага, хувь хүнд материаллаг хор уршиг учруулаагүй боловч тэдний нэр төр, алдар хүндийг гутаасан, доромжилсон үйлдэл болсон бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг нь материаллаг хор уршиг шаардахгүй юм” гэжээ.

Гэрч Д.Б мэдүүлэхдээ “2020 оны 3 дугаар сард манай байгууллагын нэр бүхий хоёр алба хаагчдын фэйсбүүк хаягийн зургийг “С зар” группт байршуулан тайлбар хэсэгт нь “Гэр бүл салгаж ажил дээрээ явалддаг ...дүгээр ангийн алба хаагчид” гэсэн утгатай мэдээллийг оруулсан явдал нь алба хаагчдын болон анги байгууллагын өгсөн үүргийн дагуу албан

бичиг, өргөдөл, гомдлыг Захиргаа, хүний нөөцийн тасгийн дарга, дэд хурандаа Э-гийн хамт Цагдаагийн газарт өгсөн. Тухайн мэдээллийг фэйсбүүк цахим сүлжээнд орсон даруид нь манай байгууллага цагдаагийн байгууллагад шалгуулахаар хүлээлгэн өгсөн юм. Түргэн шуурхай арга хэмжээ авсан болохоор манай байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдаагүй” гэжээ.

Гэрч Т.Ч мэдүүлэхдээ “Тухайн этгээд тус зарыг оруулахдаа хилийн ...дүгээр ангийн нэр хүндэд халдаж, нийгэмд буруу ташаа мэдээлэл тараасан гэж үзэж байна. Тус алба хаагчид нь тус тусын гэр бүл, үр хүүхэдтэй хэвийн тогтуун амьдралтай. Тухайн зарыг оруулсан этгээдэд хуулийн дагуу хариуцлагыг хүлээлгэмээр байна” гэжээ.

“Гэр бүл салгаж ажил дээрээ явалддаг ...дүгээр ангийн алба хаагчид” гэсэн утгатай мэдээлэлд төрийн байгууллага өргөдөл, гомдол гаргасан нь анхаарал татаж байна. Энэ нь төрийг үл хүндэтгэх, төр, түүний байгууллагын нэр хүндийг гутаасан, доромжилсон, төрийн нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараасан иргэнийг буруутгах үзэл баримтлалын илэрхийлэл юм.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол” гэмт хэрэгт тооцохоор заасан нь хуулийн этгээдийн нэр хүндэд халдсан иргэнийг буруутгах үндэслэл болж байна. Нэр хүндэд халдсан гэдэг нь заавал гутаасан гэсэн агуулгыг бүрэн илэрхийлэхгүй бөгөөд харин нэр хүнд нь хөндөгдсөн бол халдсан гэж гомдол гаргаж болох үндэслэлтэй болжээ. Шүүх хуралдаанд шүүгч, улсын яллагч, нарийн бичгийн дарга нар оролцсон гэх бөгөөд шүүгдэгч шүүх хуралдаанд оролцсон эсэх нь шүүхийн шийдвэрт тусгагдаагүй байна.

Иргэн Б-гийн үйлдэл нь хувийн харилцаанаас үүссэн, бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан хэрэг юм. Иргэн Б буруу зүйл хийсэн гэдгээ ойлгож, оруулсан мэдээллээ 40 минутын дараа устгасан байдаг. Цаашид ийм агуулга бүхий маргааныг иргэний хуулиар шийдвэрлэх нь зүйтэй. Бусдын нэр төрийг гутаасан илт худал мэдээлэл тараах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд санаа зорилгын хувьд санаатай үйлдэх бөгөөд түүний санаа зорилго нь тогтвортой, хүчтэй байдлаар илэрч харагддаг. Гэтэл худал,

алдаатай мэдээ тараасан гэдгээ ойлгоод тэр даруй устгаж байгаа үйлдэл бол гэмт хэргийн хувьд субъектив санаа зорилгыг үгүйсгэж байгаа нөхцөл байдал мөн. Үүнийг анхаарч үзэх шаардлагатай юм.

№3. ИРГЭН М-ИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч агуулга

Налайх дүүргийн ЭХАШШ-ийн 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 82 тоот шийтгэх тогтоолоор Т.М гэгчийг ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэм буруутайд тооцож 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.

Т.М-ийн үйлдсэн хэрэг нь <https://urug.mn> мэдээллийн сайтад өгсөн “Франц Улсын иргэн хоёр биеэ үнэлэгч аваагүй болох нь тогтоогдсон” хэмээн ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн төвийн ажилтан М-ийн ярилцлагын доор “Өөрөө янхан юм байна шүү дээ энэ цагдаа хүүхэн чинь...” гэсэн сэтгэгдэл бичсэн нь гэмт хэргийн шинжтэй гэж шүүхээс дүгнэжээ.

Дүн шинжилгээ

Иргэн Т.М 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр <https://urug.mn> мэдээллийн сайтад өгсөн “Франц Улсын иргэн хоёр биеэ үнэлэгч аваагүй болох нь тогтоогдсон” хэмээн ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн төвийн ажилтан М-ийн ярилцлагын доор “Өөрөө янхан юм байна шүү дээ энэ цагдаа хүүхэн чинь...” гэсэн сэтгэгдэл бичжээ. Шүүгдэгч Т.М нь шүүхийн хэлэлцүүлэгт “Пост доор л сэтгэгдэл бичсэн. Тухайн үедээ архи уусан байдлаасаа болоод болчимгүй үйлдэл гаргасан. Энэ хэрэгтээ маш их харамсаж, мөн уучлал хүсэж байна. Өөрөөсөө маш их ичиж байна. Хохирогчид хандаж уучлаарай гэж хэлэхийг хүсэж байна” гэжээ.

Хохирогч М мэдүүлэгтээ “Би энэ хүнд ямар нэгэн байдлаар ч гэм хор учруулж байгаагүй, би энэ хүнийг ч, энэ хүн намайг ч огт таньж мэдэхгүй атлаа янхан гэж муухай гутаан доромжилсон үгээр олон нийтийн сүлжээгээр доромжилсон, үүнийг нь скриншот хийгээд буюу зургийг нь аваад хүмүүс хошигнож доромжилсон мэдээллийг

фейсбүүкээр тараасан. Үүнийг нь манай нөхөр, гэр бүлийнхэн, найз нөхөд бүгд шахуу л харцгаасан байсан, энэ миний нэр хүндэд ноцтойгоор халдсан гэж үзэж байна” гэжээ.

Шүүхээс шүүгдэгч Т.М-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээлэл олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, торгосон байна. Энэ нь эрх зүйн хувьд илт худал мэдээлэл тараах үйлдэл биш, бусдыг доромжлох шинжтэй үйлдэл юм. 2002 оны Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлд “доромжлох” гэмт хэргийг заасан байсан. 2015 оны Эрүүгийн хуулиар “доромжлох” гэмт хэргийг халж, 13.14 дүгээр зүйлд “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шинээр заасан. Худал мэдээлэл тараах гэмт хэргийн ойлголтод доромжлох гэсэн эрх зүйн агуулга бүрэн тусгагдаагүй.

Доромжлох гэдэг нь хууль зүйн хувьд нийтээр тогтсон ёс суртахуун, зан үйлийн хэм хэмжээг үл хүндэтгэн, хүнийг доог тохуу болгох зорилгоор сөргөөр буюу зүй бус, зохисгүй байдлаар нэрлэж, дуудаж, үнэлж бичих, хүний зан үйл, зан төлөвийн үнэн бодит байдал, хүний алдар хүндэтгэлийг гуйвуулан үгүйсгэж буй явдал юм. Жишээ нь, хүнд хоч өгөх, гарал үүсэл, яс үндэс, биеийн гадаад хэлбэр, бие эрхтний гажиг, ажил мэргэжил зэргээр нь доромжлох явдал гардаг.

Доромжлол нь хохирогчид өөртөө гутрах сэтгэл төрүүлж, үүний үр дагавараар хүмүүс хохирогчоос зайлсхийх, уулзахгүй байх, дайжих зэрэг явдал гардаг. Иргэн Т.М нь бусдыг доромжлох үйлдэл хийсэн бөгөөд түүний бусдыг доромжилсон үйлдэлд хариуцлага хүлээлгэх нь зүйн хэрэг хэдий ч бусдыг доромжлох замаар нэр хүндэд халдах асуудлыг худал мэдээлэл тараах гэмт хэргээр зүйлчлэх бус доромжлох эрх зүйн зөрчлийг тодорхой болгох шаардлагатай байна.

№4. ИРГЭН Н.М-ИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч агуулга

Увс аймгийн сум дундын ЭХАШШ-ийн 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 106 тоот шийтгэх тогтоолоор Н.М-ийг Увс аймгийн нэгдсэн групп фейсбүүк хаяг ашиглаж Э, Б, С, Х, И нарын таван иргэний нэр төр, алдар хүндэд халдан, илтэд худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн гэж дүгнээд 900,000 төгрөгөөр торгох ял оногдуулжээ.

Шүүгдэгч Н.М нь өөрийн гар утсанд байсан Я-гийн чатуудыг уншиж байгаад гэрч Л-ийн “L ... L ... i” гэх фейсбүүк хаяг болон түүний нууц кодыг мэдсэн ба уг хаягийг ашиглаж Увс аймгийн нэгдсэн групп гэх фейсбүүк бүлэгт хохирогч Э, Б нарын зургийг тавьж “...энэ хүн эхнэрээ араар нь тавьж манай эгчтэй явалдчихаад ичихгүй үгүйсгэж байна, хүний амьдралыг бусниулаад...” гэх пост нийтэлсэн. Мөн хохирогч Х, С нарын хүүтэйгээ хамт авхуулсан зургийн доор “...энэ бас их явдалтай, дандаа эрийн араас гүйдэг өрөвдөлтэй хүмүүс нөхрөө их хуурсан даа” гэх пост, таван хохирогчийн зургийн доор “...ах эгч нараараа хүн луйварддаг муу малууд” гэсэн пост нийтэлсэн болох нь тогтоогджээ.

Дүн шинжилгээ

Шүүхээс хэрэгт үндэслэл бүхий дүгнэлт хийж хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн байна. Иргэн Н.М-ийн хийсэн үйлдэл нь илт худал мэдээлэл тарааж бусдын нэр хүндийг гутаасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл гэж үзэх үндэслэлтэй байна.

№5. ИРГЭН Э.Б-ГИЙН ҮЙЛДСЭН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч агуулга

Ховд аймгийн Сум дундын ЭХАШШ-ийн 2020 оны 8 дугаар сарын 19-ний 143 тоот шийтгэх тогтоолоор Э.Б-г фейсбүүк сүлжээ ашиглан иргэн О-гийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг (энэ эмэгтэй бол янхан, худлаа хэлээд янхандаж явдаг, айлын нөхөртэй явалдана, 3-4 залуутай зэрэг явалдах чинь янхандалт мөн биз дээ) олон нийтэд тараасан буюу худал мэдээлэл тараах гэмт хэрэг үйлдсэн учир ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.

Дүн шинжилгээ

Шүүхээс хэрэгт үндэслэл бүхий дүгнэлт хийж хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн байна. Иргэн Э.Б-гийн хийсэн үйлдэл нь илт худал мэдээлэл тарааж бусдын нэр хүндийг гутаасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл гэж үзэх үндэслэлтэй байна.

№6. ИРГЭН Г, У НАРЫН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч агуулга

Чингэлтэй дүүргийн ЭХАШШ-ийн 2021 оны 1 дүгээр сарын 12-ны 48 тоот шийтгэх тогтоолоор шүүгдэгч Г, У нарыг ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1,000,000 болон 1,300,000 сая төгрөгөөр тус тус торгох ялаар шийтгэжээ.

Дүн шинжилгээ

Болсон явдлын тухайд иргэн Г нь үргэлжилсэн үйлдлээр У-тай бүлэглэн компанийн захирал Л-ийн талаар “...энэ хүнд ухамсрын шанаа өгөөч Ерөнхий сайдаа, энэ хүн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёрыг би харцаараа хөдөлгөдөг гээд цээжээ дэлддэг болжээ, арай ч тиймдээ

тулаагүй байлгүй дээ”, мөн “...төрийн агентлагаас дээгүүр эрх мэдэлтэй Л нь Богд уулын аль ч аманд газар авч чадна хэмээн бусдыг залилдаг ч хариуцлага хүлээгээгүй байна, жишээ дурдахад Зайсанд барьсан “Х ...” хотхоныг улсын комисс хүлээж аваагүй байхад Ерөнхий сайдын баруун гар гэж өөрийгөө ярьдаг дүү нь дур мэдэн айлуудыг оруулсан байх юм, тэднийг дураараа дургихад хотын дарга Амарсайхан толгойг нь илдэг” гэсэн илт худал мэдээлэл, гэрэл зургийг нийтэлсэн.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Ц-ийн талаар “...төрийн ажил хийдэггүй морины ажил хийдэг даргыг төрөөс зайлуулъя, төрийн ажлыг хувийн компани шигээ санаж сард ганц хоёр удаа гэгээн дүрээ харуулчхаад бусад цагт мориныхоо жүчээнд бөртөлзөж байдаг, газрын наймааны мөнгөөрөө хэдэн зуун саяар ч хамаагүй морь худалдан авч цуглуулах хоббитой газрын мафийн нууц эзэн Ц-тэй танилц” гэсэн илт худал мэдээлэл, гэрэл зургийг зааварчилгаа өгч Б.У-гаар бэлтгүүлсэн.

Уг мэдээлэл, гэрэл зургийг хэд хэдэн фейсбүүк группт байршуулж хүний нэр төр, алдар хүндэд халдсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ. Иргэн Г, У нарын хийсэн үйлдэл нь шүүмжлэлт, сөрөг мэдээлэл байх бөгөөд бусдыг гүтгэсэн, илт худал мэдээлэл тараасан гэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал биш бөгөөд Иргэний хуулиар шийдвэрлэх маргаан гэж үзэх үндэслэлтэй. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг мөрдөн шалгах явцад иргэн Г, У нарыг тус бүр 53 хоног цагдан хорьсон нь анхаарал татаж байна. Гомдол гаргагч тал нь төрийн албан тушаалтан байгаа болно. Хэрэг шалгах ажиллагаа нэг талыг барьж, хөнгөрүүлэх, цагаатгах нотлох баримтыг цуглуулсан асуудал бага, шүүмжлэлт, үзэл бодлоо илэрхийлсэн асуудлыг “илт худал мэдээлэл тараасан” гэж ял шийтгэсэн нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг хөндсөн байна.

№7. ИРГЭН У-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч агуулга

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын сум дундын шүүхийн 2021 оны 2 дугаар сарын 25-ны 09 тоот шийтгэх тогтоолоор Б.У нь Улаанбаатар хотод байхдаа фейсбүүк хаягаасаа “УИХ-ын гишүүн Д нь хайрганы уурхай дээрээ гурван автобус хятад иргэдийг оруулж ирсэн мэдээлэл бидэнд ирлээ. Мөн Д нь Төмөртэйн ордны нөөцийг хятад эздэд зарсан” гэж Д-гийн нэр төр, алдар хүндэд халдаж, илт худал мэдээллийг олон нийтийн цахим сүлжээ фейсбүүкээр тараасан гэмт хэрэг үйлдсэн гэж дүгнээд ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.

Дүн шинжилгээ

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч Б.Б нь Д-гийн өмнөөс гомдол гаргаж, гэрчээр мэдүүлэг өгчээ. Хэдийгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд хохирогч өөрийн эрхийг хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэгжүүлж болно гэж заасан ч хохирогч этгээдийн гомдол, мэдүүлэг байхгүйгээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь учир дутагдалтай юм.

Болсон үйл баримт нь үнэхээр бодит байдалд нийцэж байгаа эсэхийг шалгалгүйгээр Д-гийн бие төлөөлөгчийн гаргасан гомдол, мэдээллийг үндэслэн, харьяалал зөрчин хүнийг ял шийтгэсэн шүүхийн тогтоол үндэслэлгүй болжээ. Б.У нь Улаанбаатар хотод ирсэн байхдаа дээрх нийтлэлийг фейсбүүк хуудастаа бичсэн байхад яагаад нийслэлд бус Замын-Үүд суманд Д-гийн төлөөлөгч гомдол гаргаж, тус сумын шүүхээр ял шийтгэсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн хэрэг бөгөөд шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн гэх үндэслэлээр хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэжээ.

Мөн уг илт худал мэдээлэл гутаасан агуулга байхгүй байсан ч эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой. Онолын хувьд “илт худал мэдээлэл” гэдэгт гутаасан агуулгатай мэдээллийг ойлгоно гэж тайлбарлаж болох ч хуульд ийм агуулга байхгүй. Харин энэ заалтыг үзэмжээрээ тайлбарлах

боломжтой байгааг залруулахын тулд Улсын Дээд Шүүх уг зүйлийг албан ёсоор тайлбарлах шаардлагатай.

Эрүүгийн хуульд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шүүх шийдвэрлэхдээ “илт худал мэдээлэл” гэсэн ойлголтыг “илт худал мэдээлэл”, “худал мэдээлэл” гэсэн аль аль хэлбэрийг хамруулан тайлбарлаж байна. Шүүх Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 511 дүгээр зүйлийн 511.2-т зааснаар шүүгдэгч Б.У-г хохирогч Б.Д нэр төрд халдсан, худал мэдээлэл тараасан хэлбэрээр няцаалт хийхийг үүрэг болгосугай гэж шийдвэрлэсэн.

Шүүгдэгч Б.У нь хууль зүйн туслалцаа аваагүй, өмгөөлөгчгүй шүүх хуралдаанд оролцож, хууль зүйн хувьд мэтгэлцэж чадаагүй байна. Шүүгдэгч өөрийн гэм буруугаа хүлээж, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хүсэлт гаргажээ. Энэ төрлийн хэрэгт шалгагдаж байгаа иргэн нь хууль зүйн туслалцаа авахгүй, өмгөөлөгчгүйгээр хэрэг шалгах ажиллагаанд оролцох явдал түгээмэл байх бөгөөд гэмт хэрэг гэдэг утгаар төрийн зүгээс яллах, буруутгах ажиллагаа нэг талыг барьж явагдаж байгаа байдал ажиглагдлаа. Мөн маргаж мэтгэлцэхгүйгээр гэм буруугаа хүлээж, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлж, уг асуудлыг хурдан дуусгавар болгох хүсэлтийг яллагдагч, шүүгдэгч тал илэрхийлдэг байна.

Шүүгдэгч Б.У нь мэдүүлэгтээ “Би худлаа мэдээлэл түгээсэн гэдгээ хүлээн зөвшөөрч байгаа, хууль, хяналтын байгууллага шалгаад хууль бус үйлдэл гэдгийг тогтоосон. Худал мэдээлэл тараасандаа уучлалт хүсэж байна. Гэм буруугийн тал дээр ямар нэг маргаан байхгүй, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр шүүхэд шилжүүлсэн, худлаа мэдээлэл түгээсэн гэдгээ хүлээн зөвшөөрч байгаа, хууль, хяналтын байгууллага шалгаад хууль бус үйлдэл гэдгийг тогтоох тухай хүсэлтийг хүлээн зөвшөөрч байна, би өөрийн цахим хуудсаараа дамжуулан худал мэдээлэл тараасан бичлэгийн талаар залруулга хийнэ. Би энэ мэдээллийг түгээхдээ Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт байсан, хэргийн харьяаллын талаар маргаан байхгүй, хэргээ энэ шүүхээр шийдвэрлүүлэхэд татгалзах зүйл байхгүй” гэжээ.

ЭХХШТХ-ийн 2.2 дугаар зүйлийн 1-д “Хэргийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ”, 4-т “Хэрэг тухайн шүүхэд харьяалагдахгүй байвал шүүгчийн шийдвэрээр харьяалах шүүхэд

шилжүүлнэ”, 8-д “Уг хэрэг адил эрх бүхий өөр шүүхэд харьяалагдах нь шүүх хуралдааны үед мэдэгдсэн бөгөөд хэргийн байдлыг бүрэн бодитойгоор тогтооход нөлөөлөхгүйгээр байвал шүүх хуралдааныг үргэлжлүүлж, хэргийг эцэслэн шийдвэрлэнэ” гэжээ.

Шүүгдэгчийн мэдээллийг тараасан буюу хэрэг гарсан, гэмт хэрэг үйлдсэн газар нь нийслэлийн Хан-Уул дүүрэг байсан бөгөөд иймд уг хэрэгт хяналт тавих, мөрдөн шалгах газар нь Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын прокурорын газар, цагдаагийн байгууллага биш, харин Хан-Уул дүүргийн Цагдаа, Прокурорын газар юм. Гэтэл анхнаасаа хэрэг шалгах харьяалал зөрчигдсөн байх магадлалтай.

№8. ИРГЭН Г-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч агуулга

Баянзүрх дүүргийн ЭХАШШ-ийн 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 340 тоот шийтгэх тогтоолоор шүүгдэгч Г.М-ийг иргэн Ц-гийн царай төрх бүхий зургийг ашиглаж “...энэ хүнийг таних уу, утас хулгайлчихлаа, бичлэг нь байгаа, арай ч ийм юм хийхгүй байх гэж бодсон чинь авсан байх юм” гэсэн пост фейсбүүк хуудсандаа байршуулж хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээлэл олон нийтэд тараасан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхээс Г.М-ийн гэм буруутай болохыг хангалттай нотолж тогтоосон, шүүгдэгч нь гэм буруугаа хүлээн зөвшөөрснийг харгалзан ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож улмаар ЭХЕА-ийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан ялаас чөлөөлж шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ

Иргэн Г.М “Би нөхрийнхөө нөүтбүүкийг ашиглахад түүний фейсбүүк нээлттэй байсан. Би чамд хайртай, чи миний амь амьдрал гэсэн чат ирсэн байсан. Би ухаад үзтэл 10 сараас хойш уулздаг байсан. Тэгээд би эхлээд С.Ц-д ингэж болохгүй гэж хэлсэн. Нэлээд хэдэн группт

зургийг нь тавьсан. Утас хулгайлсан асуудлын тухайд эхлээд би гэр бүл үймүүлсэн гэхээс илүү айлгах гээд гар утас хулгайлсан гэж тавьсан” гэж мэдүүлэг өгсөн байдаг. Хувийн харилцаатай холбоотой асуудлаас үүдэн бусдыг утас хулгайлчихлаа гэж гүтгэсэн нь эрх зүйн зөрчлийн шинжийг агуулж байна.

№9. ИРГЭН Х-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААСАН” ГЭМТ ХЭРЭГ

Товч мэдээлэл

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 22 тоот шийтгэх тогтоолоор Х-д холбогдох хэргийг хянан шийдвэрлэж ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэн, насанд хүрээгүй хохирогч Э, О нараас уучлал гуйж гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авч шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ

Иргэн Х нь фейсбүүкийн “Гурван төв зар” гэх нэртэй олон нийтийн сүлжээнд насанд хүрээгүй Э, О нарын зургийг байршуулж “...энэ охидоос болгоомжил, гэр эзгүйчилж хүний нөхөртэй явалдаж айл гэр үймүүлдэг балиар юмнууд, ...дүгээр сургуульд сурдаг эцэг эхийг нь таньж мэддэг хүн байна уу, би олон удаа сануулж хэлсэн” гэх мэдээллийг байршуулж хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэгт холбогдсон байна.

Иргэн Х-гийн тараасан мэдээлэл тодорхой болсон үйл явдалд тулгуурласан бөгөөд хувийн харилцааны шинжтэй үл ойлголцол, маргаанаас үүдсэн. Насанд хүрээгүй гэрч Б.Б мэдүүлэгтээ “Ж ахын гэрт байх хугацаанд түүний эхнэр Х нь О-гийн утас руу “Чи манай гэрт байгаа юм уу, одоо манай гэрээс яв” гэсэн утгатай чат бичсэн гэсэн. О-гийн утсаар Ж ах эхнэр Х-тэйгээ чатаар харьцаад байсан гэсэн. Тэр шөнөдөө О бид хоёр Ж-гийн гэрт хоносон. О явахгүй гээд байсан. Шөнө үүр цайж байхад О “Миний зургийг фейсбүүкт тавьчихсан байна”

гэж ярьж байсан. Х нь О, Э нарын зургийг нөхөртэй нь явалдаж байна гэх утгатай пост оруулж тавьсан байсан. Надтай цуг О л Ж ахын гэрт очсон. Э тэдний гэрт очоогүй. Түүнийг хэлмэгдчихсэн гэж бодож байна” гэжээ.

Иргэн Х нь өөрийн үзэл бодол, бусдын нэр төрд халдсан санал шүүмжлэлээ илэрхийлсэн бөгөөд түүнийг шууд илт худал мэдээлэл тараасан гэмт хэрэгт буруутгах үндэслэлгүй юм. Мөн алдаатай мэдээлэл түгээсэн асуудал нь ч түүнийг худал мэдээлэл тараах гэмт хэрэгт тооцох үндэслэл болохгүй. Учир нь түүний үйлдэл бол тодорхой, бодитой үйл явдалд тулгуурласан, үндэслэл бүхий үзэл бодол, таамаг, шүүмжлэл юм. Илт худал мэдээлэл гэдэг бол ямар ч ор үндэслэлгүй, зохиомол мэдээлэл юм. Тодорхой үйл баримт, болсон үйл явдалд үнэлэлт дүгнэлт өгсөн, шүүмжилсэн, нэр хүндэд халдсан, сөрөг мэдээллийг илт худал мэдээлэл гэж үзэж болохгүй. Бусдын нэр төрд халдсан энэ төрлийн хэргийг иргэний хэргийн журмаар шийдвэрлэх ёстой. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шийдвэрлэхдээ “илт худал мэдээлэл” гэсэн ойлголтод тодорхой үйл баримт, болсон үйл явдалд үнэлэлт дүгнэлт өгсөн, шүүмжилсэн, нэр хүндэд халдсан, сөрөг мэдээллийг хамруулан гэм буруутайд тооцох шүүхийн практик тогтсон байна.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт ял шийтгэгдсэн иргэн давж заалдах гомдол гаргаагүй байна.

№10. ИРГЭН Б-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААСАН” ГЭМТ ХЭРЭГ

Товч мэдээлэл

Баянзүрх дүүргийн ЭХАШШ-ийн 2021 оны 3 дугаар сарын 29-ний 414 тоот шийтгэх тогтоолоор Б нь өөрийн фейсбүүк хуудсандаа “...УИХ-ын сонгуульд нэр дэвшигч Г-гийн талаар залилах гэмт хэрэгт хамтран оролцсон, “Х” намын гишүүн байсан, М сургуулийн дэд захирал байхдаа оюутны дүн зассан” зэрэг мэдээллийг нийтэлсэн учир ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 1000 нэгжээр торгох ялаар шийтгэжээ.

Дүн шинжилгээ

Болсон үйл баримт нь үнэхээр бодит байдалд нийцэж байгаа эсэхийг сайтар шалгалгүйгээр гомдол гаргагчийн гомдол, мэдүүлгийг үндэслэн Б-г илт худал мэдээлэл тараасан гэж дүгнэсэн шүүхийн тогтоол үндэслэлгүй болжээ.

Иргэн Б-гийн тараасан мэдээлэл нь илт худал мэдээлэл биш, тодорхой үйл баримт, мэдээлэл, эх сурвалжид тулгуурласан, мэдээллийн эх сурвалж, баримт нотолгоог бүрэн шалгаагүй алдаатай мэдээлэл байна. Түүний тараасан мэдээлэлд дурдсан үйл явдалд хамааралтай хэрэг, маргаан шийдвэрлэгдэж байжээ.

Шүүхээс дүгнэлт хийхдээ “Шүүгдэгч З.Б нь иргэн Г-гийн талаар “Х” намын гишүүн байсан гэх зэргээр хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээлэл олон нийтэд тараасан болох нь хавтаст хэрэгт цугларсан дараах нотлох баримтуудаар нотлогдож байна” гэжээ. Хохирогч Г мэдүүлэгтээ “2012 оны С аймгийн “Х” намын залуучуудын холбооны чуулганы өмнө тус холбооны тэргүүн өөрийн найзын хүсэлтээр очиж манлайлал хувь хүний хөгжлийн талаар хичээл орж дуусаад надад талархал илэрхийлээд бэлэг батламж зэрэг эд зүйлс гардуулсан үеийн бичлэгийг дүрсжүүлж аваад “Х” намд өмнө нь байсан одоо “А” намд байгаа бөгөөд ялсан нам руу урваж ордог гэсэн утгатай 37 секундйн видео бичлэгийг ӨС гэсэн фейсбүүк хаягаас оруулсан байсан. Миний улс төрийн карьерт сөрөг муу нөлөө үзүүлж байгаа бөгөөд хүнд гэмт хэрэг болон худал хуурамч зүйлд гүтгэж олон нийтийн сүлжээгээр мэдээ мэдээлэл тараасанд гомдолтой байна. “Т” холбооны дэд тэргүүнийг томилох тухай С аймгийн “Т” холбооны хурлын тогтоол гэх алдаатай бичиглэл бүхий нотариатаар батлуулсан баримт нь Г-г “Х” намын гишүүн байсан гэдгийг нотлох баримт биш юм” гэжээ.

Шүүх уг мэдээллийг илт худал мэдээлэл гэж үзэж, иргэн Б-г гэм буруутайд тооцсон нь үндэслэлгүй юм. Онолын хувьд “илт худал мэдээлэл” нь хүний нэр төрийг гутаасан, доромжилсон агуулга, үр дагавартай мэдээлэл байх учиртай. Гэтэл “Х” намын гишүүн байсан, байгаагүй гэсэн асуудал нь өөрөө илт худал мэдээллийн шинжийг агуулахгүй юм. Харин уг мэдээлэл нь алдаатай мэдээлэл бөгөөд алдаатай мэдээлэл түгээсэн этгээдийн үйлдлийг гэмт хэрэгт тооцох нь Үндсэн

хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүний мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг зөрчсөн хэрэг болно. Энэ бол гэмт хэргийн шинжтэй үйлдэл биш бөгөөд уг зөрчлийг иргэний хэргийн журмаар шийдвэрлэх ёстой.

Шинэ Лексус-570 маркийн автомашиныг Г-гийн нөхөр Н нь Э гэдэг хүнээс хүлээн авсан атлаа түүнд амласан бартерын орон сууцныг хүлээлгэн өгөлгүй гурван жил гаруй болсон ба Э нь шүүхийн шийдвэр гарах хүртэл автомашин болон орон сууцны алиныг ч аваагүй хохирсон гэж цагдаагийн байгууллагад гомдол гаргаж байсан болох нь тодорхой байхад уг мэдээллийг илт худал мэдээлэл гэж шүүхээс дүгнэсэн нь ойлгомжгүй байна. Хэдийгээр Г автомашиныг өөрөө хүлээн аваагүй боловч гэр бүлийн хүн нь хүлээн авсан бөгөөд мэдээлэлд дурдахдаа гэр бүлийн хамт залилж, хамтран оролцсон гэж бичсэн нь илт худал бус, бодит байдалд нийцсэн мэдээлэл байна.

Түүнчлэн М сургуулийн дэд захирал байхдаа оюутны дүн зассан гэх мэдээлэл ч Б-гээс өмнө байнга яригдаж байсан мэдээлэл бөгөөд Б нь уг мэдээллийн үнэн зөвийг нягталж шалгаагүй нь түүний буруутай үйлдэл мөн, гэхдээ энэ үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл биш юм. Тиймээс мэдээллийг нягтлалгүйгээр иргэн Г-гийн өөрийгөө хамгаалсан мэдүүлгийг үндэслэн илт худал мэдээлэл тараасан гэж дүгнэсэн нь буруу байна.

Иргэн Б нь тодорхой болсон бодитой үйл баримт, фактад үндэслэн мэдээлэл түгээсэн байх бөгөөд эдгээр мэдээллийг илт худал мэдээлэл гэж үзэх боломжгүй юм. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг худал мэдээлэл тараах гэмт хэрэгт тооцсон нь өөрөө Үндсэн хуульд нийцэхгүй. Сэтгүүлч мэдээлэл хайх, олж авах, түгээх, хэвлэн нийтлэх нь түүний мэргэжлийн үйл ажиллагаа билээ. Мэргэжлийн үйл ажиллагаанаас үүдсэн худал мэдээлэлтэй холбоотой асуудлыг Эрүүгийн гэмт хэрэгт тооцож болохгүй юм.

Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т “Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2-т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ” гэж заасан. Уг асуудал нь Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн шинжтэй үйлдэл

биш бөгөөд Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан журмаар шийдвэрлэгдэх маргаан юм.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн тухай өргөдөл, гомдлыг шалгаж, шүүхээр шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан журмаар шийдвэрлэгдэх иргэний маргааны шинжтэй асуудлыг хамаатуулан шийдвэрлэж байгаа практик байна. Цаашид хууль хэрэглээний хувьд Эрүүгийн хуульд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан журмаар шийдвэрлэгдэх хэрэг маргааны эрх зүйн зөрчлийн ялгаатай байдлыг тодруулан зөв ялгаж зүйлчлэн хэрэглэх, хууль зүйн хувьд зөв тайлбарлах шаардлагатай. Мөн энэ талаар Улсын дээд шүүх хуулийн тайлбар гаргах шаардлагатай байна.

№11. ИРГЭН Т-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч мэдээлэл

Баянзүрх дүүргийн ЭХАШШ-ийн 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 427 тоот шийтгэх тогтоолоор Н.Т-г ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1000 нэгжээр торгох ялаар шийтгэжээ.

Шүүгдэгч нь өмнө үерхэж байсан О-гийн гэрэл зургийг ашиглан хуурамч фейсбүүк хаяг нээж садар самуун агуулга бүхий нийтлэл бичиж, түүний нэр төрд халдсан илт худал мэдээлэл олон нийтэд тараасан гэмт хэрэгт холбогджээ.

Дүн шинжилгээ

О-гийн нэр дээр нээсэн фейсбүүк хаягаасаа “Санхүү, тусламж” гэсэн бүлэгт нэгдэж улмаар биеэ үнэлж санхүү авна гэсэн утгатай зар байршуулсан ба уг зарын дагуу олон хүн холбогдсоны улмаас гар утасны дугаараа сольсон байна.

Өмнө нь мөн иймэрхүү үйлдэл гаргаж байсан ба цагдаагийн байгууллагаас сануулаад өнгөрсөн ч Н.Т сургамж авалгүйгээр дахин бусдын нэр төр гутаасан, илт худал мэдээлэл оруулж гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогджээ. Шүүхээс хэрэгт үндэслэл бүхий дүгнэлт хийж хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн байна.

Хохирогч О мэдүүлэгтээ “Одоо болтол над руу санхүү авах уу гэсэн чат ирж байгаа. Би үнэхээр гомдолтой байна. Энэнээс нь болж би маш хэцүү байдалд орсон. Ажлаа хийж чадаагүй. Өөрийнхөө дугаараар миний нэр дээр шинэ фейсбүүк хаяг нээгээд санхүү авна гэж бичсэн. Энэ хүнтэй би анх найзаараа дамжуулан танилцсан. Дархан руу хамт явж, ажил хийсэн. Тэгээд 12 сард буцаад Улаанбаатар хотод ирсэн. Би тэвчиж чадалгүй цагдаагийн байгууллагад өгсөн. Эхлээд манай ээж рүү залгаж уучлаарай гэсэн. Дараа нь миний үр хүүхэд болон ээжийн зургийг тавиад санхүү авна гээд ээжийн болон миний дугаарыг фейсбүүкт тавьсан байдаг. Ээж болон миний зүгээс маш их гомдолтой байна. Би дугааруудаа сольсон. Миний ээжийн дугаарыг манай төрсөн ах барьж байгаа. Тэр дугаар руу нь одоо болтол санхүү авах уу гэж залгадаг” гэжээ.

Яллагдагч Т нь мэдүүлэгтээ “Би 2019 оны 8 дугаар сарын үед О гэх хүүхэнтэй танилцсан. Надтай хамт амьдарч байх хугацаандаа фейсбүүк хаягаараа нэг залуугийн зурган дээр миний краш энэ тэр гээд, өөр залуу руу хандраад байсан. 2020 оны 3 дугаар сарын үед би согтуудаа дахин О-гийн цахим хуудсанд “Хүнтэй унтана, садар самуун зүйл хийнэ гэх утга бүхий мөн тэр хүний нэр төрийг гутаан доромжлох пост дахин оруулсан. Би хийсэн хэргээ хүлээн зөвшөөрч байна” гэсэн мэдүүлэг өгсөн байдаг.

Иргэн Т нь хохирогч О-гийн нэр төрийг гутаах, доромжлох зорилгоор илт худал мэдээлэл санаатай тараасан үйлдэл нь гэмт хэрэг мөн. Иргэний нэр төрийн халдашгүй байдлыг хуулиар хамгаалах ба хүний нэр төрийг гутаан доромжлох үйлдэл нь ёс суртахуунгүй үйлдэл бөгөөд нийгэмд харш үйлдэл юм. Уг асуудлыг иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ гэвэл ихээхэн хугацаа орох бөгөөд гэмт үйлдлийг таслан зогсоох, хохирогчийн эрх ашгийг хамгаалах шуурхай арга хэмжээ авах боломж ихээхэн хязгаарлагдмал юм.

№12. ИРГЭН С-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Товч мэдээлэл

Хан-Уул дүүргийн ЭХАШШ-ийн 2021 оны 4 дүгээр сарын 8-ны 229 тоот шийтгэх тогтоолоор өмнө нь хуурамч баримт бичиг үйлдэх, улсын хилээр хууль бусаар нэвтрэх гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан 30 настай эмэгтэй С нь иргэн О-гийн гар утасны дугаарыг “Халуухан дагина” гэх фейсбүүк бүлэгт “...санхүү авна, дуудлагаар үйлчилнэ, 35 настай царайлаг бүсгүй, утас 91...” гэх утгатай байршуулж хүний нэр төрд халдсан илт худал мэдээлэл олон нийтэд тараасан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхээс үйлдсэн хэрэг нь хангалттай нотлогдсон, шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрч хялбаршуулан шийдвэрлэж өгнө үү гэсэн хүсэлт гаргасан зэргийг харгалзан ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 500 нэгжээр торгох ялаар шийтгэжээ.

Дүн шинжилгээ

Шүүгдэгч С нь мэдүүлэгтээ “Би хохирогчийг манай нөхөртэй хамт байгаа гэж бодоод энэ хүнтэй таарамжгүй байдалд ороосой” гэж бодож пост тавьсан. Манай нөхөр гэр бүлээс гадуур харилцаа тогтоодог, хохирогчтой дотно харилцаатай гэдгийг манай аав хамт явж байгааг нь хараад надад хэлснээр би мэдсэн. Би гэм буруугаа ойлгож байгаа. Одоо нөхрөөсөө салсан, тусдаа амьдарч байгаа. Би “Х” гэх нэрээр фейсбүүк группт пост тавьсандаа харамсаж байна” гэжээ.

Хохирогч О мэдүүлэгтээ “2020 оны 9 дүгээр сарын эхээр “УУ” гэх нэртэй фейсбүүк хаягаас над руу “Чи манай нөхөртэй явалдаад байна, би гурван хүүхэдтэй, одоо нэг нь гэдсэнд байна. Чи муу янхан банзал” гэж чат бичиж доромжилсон. Би тухайн эмэгтэйн нөхөртэй фейсбүүкийн найзууд байсан. Гэхдээ уг залууг танихгүй, харж байгаагүй хүн байсан. Тэгээд “Чи намайг ямар хүнтэй хардаад байгаа юм бэ” гэхэд надад нөхрийнхөө нэрийг Т.Т гэж хэлсэн. Надад “Чи ямар ч холбоогүй юм бол блок хийгээч” гэхээр нь блоклосон. Би Т.Т гэх залууд “Танай эхнэр намайг чамтай хардаад элдэв янзаар доромжлоод байна, манай хүүхэд болон ах руу чат бичиж, намайг янхан банзал, хүүхэдтэй хүнтэй

явалдсан гэж чат бичсэн байна” гэхэд “Манай эхнэр байнга тэгээд байдаг юм аа, миний фейсбүүк хаяг дахь бүх эмэгтэй хүмүүс рүү чат бичээд байдаг юм” гэж хэлсэн. 2020 оны 12 дугаар сарын 27-ны өдөр над руу дахин чат бичиж “фейсбүүк од болгоно” гэж хэлээд 2021 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр “Нсадар групп” гэсэн нэртэй группт “Санхүү авна, мөн дуудлагаар үйлчилнэ, 35-тай царайлаг бүсгүй” гээд миний утасны 91XXXXXX гэсэн дугаарыг бичээд пост оруулсан байсан. Тэгээд миний гар утас руу маш их хүмүүс залгаж “Байр нь бэлэн юм уу, ямар үнэтэй юм бэ, дуудлагаар үйлчилдэг гэл үү” гээд залгасан. Шөнийн 2 цагаас үүрийн 5 цаг хүртэл хүмүүс залгасан. Өглөө 7 цагт мөн нэг хүн залгаж “постын дагуу залгаж байна” гэхээр нь миний утсыг фейсбүүкт тавьсан гэдгийг мэдсэн. Би хуулийн дагуу хэргийг шийдвэрлүүлмээр байна, ямар ч шалтгаангүйгээр намайг ингэж гүтгэж, нэр хүндэд минь халдаж, цахим орчинд худал мэдээлэл тараасанд гомдолтой байна” гэжээ.

Шүүх С-ийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон байна. Хувийн харилцааны маргаан, үл ойлголцол, хардалт, өс хонзон зэргийн улмаас бусдын нэр төрийг гутаан доромжлох явдал гардаг бөгөөд үүнийг иргэний хэргийн журмаар шийдвэрлэх асуудал нь хохирогчийн зүгээс эрх ашгаа хамгаалуулах, худал мэдээллийг нэн даруй таслан зогсооход хангалттай хууль зүйн хариу арга хэмжээ, хамгаалалт болж чаддаггүй. Нэгэнт нийгмийн ёс суртахууныг илтэд гажуудуулж, санаатайгаар бусдыг гүтгэж, доромжилж байгаа үйлдлийг гэмт хэрэгт тооцох нь тухайн улсын эрх зүйн бодлогын асуудал юм.

Хавсралт 2

*Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй
практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын
эрүүгийн эрх зүйн асуудал*

ЭКСПЕРТҮҮДИЙН УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ (2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр, 16.00-18.10 цагт)

Экспертүүдийн уулзалтад Глоб Интернэшнл төвийн Удирдах зөвлөлийн дарга Х.Наранжаргал, Хэвлэлийн Хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал М.Мөнхмандах, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, доктор О.Мөнхсайхан, УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Б.Энхбаяр, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Т.Золбоо, судлаач Д.Оросоо, Ц.Цэлмэг болон ННФ-ын менежер Б.Хишигсайхан нар оролцлоо. Хэлэлцүүлэгт оролцсон экспертүүдийн хэлсэн үгийг үг хэлсэн дарааллаар дор сийрүүлэн буулгалаа.

ННФ-ын менежер Б.Хишигсайхан

Нээлттэй Нийгэм Форум нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 30 орчим судалгаа хийгээд байна. Бид судалгааны чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх, эргэлтэд оруулах зорилгоор төрөл бүрийн хэлэлцүүлгийг хийдэг билээ. Энэ хүрээнд судлаач Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа нар хамтран хийсэн “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал” сэдэвт судалгааны хэлэлцүүлгийг энэ чиглэлээр ажилладаг экспертүүдийн түвшинд зохион байгуулсан болно. Энэ уулзалтын хамгийн гол зорилго нь судалгааны тайлангийн дүгнэлтэд мэргэжилтнүүдийн байр суурийг сонсох юм.

Глоб Интернэшнл төвийн Удирдах зөвлөлийн дарга Х.Наранжаргал

Өнөөдөр нийгэмд тодорхой хэмжээгээр айдас төрүүлж буй худал мэдээллийн тухай хуулийн асуудал бол чухал сэдэв. Худал мэдээл тараах

ба нэр төр гутаах гэмт хэргийн тухай ярьж байна. Үүнтэй холбогдуулан нэгдүгээрт, нэр томьёо; хоёрдугаарт, тодорхойлолтын тухай ярих ёстой. Тухайлбал, *honor*-ийг нэр төр, *reputation*-ийг алдар хүнд, мөн ажил хэрэгтэй холбогдуулан нэр хүнд гэдэг. Нэр төр бол хувь хүний мэдрэмж, энэ утгаар нэр төр бол хүний өөртөө өгч байгаа үнэлгээ юм.

Олон улсын эрх зүйд *Defamation* гэж эрхзүйн нэр томьёо ашигладаг. Олон улсын сэтгүүлчдийн холбоо (*IFJ*), 19-р зүйл (*Article 19*) байгууллагын өгсөн тодорхойлолт бий. Түүний дагуу алдар хүнд тодорхой баримтад үндэслэн хүнийг буруутган нэр хүндэд нь хор хохирол учруулах гэсэн тодорхойлолт бий. Оросууд *дефамаци* гэж хэрэглэдэг. Зориуд, санаатайгаар хүний нэр хүндэд хор хохирол учруулах гэдэгт л тулгуурладаг. *Defamation* нь *libel* ба *slander* гэсэн хоёр төрөлтэй гэж үздэг. *Libel* нь бичгээр илэрхийлсэн, нийтэлсэн үйлдлийг, *slander* нь биеийн хэлэмж, дохио зангаагаар гутаах гэсэн утгатай. Манайхан *slander*-ийг нь доромжлол, *libel*-ийг гүтгэлэг гэж орчуулж хэрэглэдэг. Олон улсад мөн *Insult law* гэсэн ойлголт байдаг нь манай доромжлол гэсэн үгтэй тохирдог. Англи хэлний тайлбар толь бичгээс харахад *insult* гэж үл хүндэтгэн эсвэл басамжлан тохуурхан ярих, харьцах гэж тайлбарладаг. Я.Цэвэл гуайн “Монгол хэлний тайлбар толь бичиг”-т “Гүтгэх гэж оргүй хэргийг зохиож муутган унагах, худал хэрэг тулгах” гэсэн байдаг.

Манайд хэрэг шийдвэрлэхдээ алдар хүнд гутаах, худал мэдээллийг хольж хутгасан нь ажиглагддаг. Жишээ нь, Зөрчлийн тухай хуулиар орон нутгийн иргэнийг 550 мянган төгрөгөөр торгосон тухай судалгаанд дурдагдсан байна. Иргэн КОВИД цар тахлын анхны хөл хорионы үеэр цагдаа хахууль авсан тухай бичсэн. Цагдаа хахууль авсан эсэхийг мөрдөн шалгаж байж л тухайн мэдээлэл үнэн эсвэл худал болохыг тогтооно. Үнэн л гол нотолгоо.

Хуучин Эрүүгийн хуульд гүтгэлэг, доромжлол хоёулаа гэмт хэрэг байлаа. Гүтгэлгийн гэмт хэргийг халсан байсныг буцааж орууллаа. Доромжлолыг бас эрүүжүүлэх вий гэсэн болгоомжлол байна. Хуучин хуулийн зүйл ангид санаатайгаар гүтгэсэн бол гэж байсан. Манай практикт сэтгүүлчийн материалд дурдагдсан гэмт хэргийн араас мөрдөн шалгасан тохиолдол бараг байхгүй. Хэл шинжээч эсвэл сэтгүүл зүйн багш нар материалыг уншаад “Энэ материал гүтгэлгийн шинжтэй,

доромжилсон өнгө аястай“ гэсэн дүгнэлт гаргана. Үүний дагуу шүүх хэргийг шийдвэрлэдэг байлаа. Доромжлолын утгатай байна уу, авлигатай холбоотой байна уу гэдгийг харахгүйгээр шийддэг байсан.

Худал мэдээллийн тухайд бол ЮНЕСКО-гийн сургагч багш нарт зориулан бэлтгэсэн гарын авлага бий. Дональд Трамп АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон сонгууль, Их Британийн Европын Холбооноос гарах асуудлаар явуулсан ард нийтийн санал асуулга *Brexit*-тэй холбоотой хүчээ аван өргөнөөр хэрэглэгдэх болсон “худал мэдээ”-тэй холбоотойгоор олон улсын шинжээч, мэргэжилтнүүдийн хийсэн судалгааны үр дүнд 2018 оноос энэ нэр томъёоноос татгалзаж, *disinformation, misinformation, malinformation* гэх үгийг ашиглаж байна. Сэтгүүл зүйн мэдээ бол олон нийтийн эрх ашигт нийцсэн, нотлогдсон мэдээлэл юм. Энэ хэм хэмжээнд нийцээгүй мэдээлэл нь мэдээний тэмдэг, тамга дарагдаагүй гэсэн үг. Энэ утгаар “худал мэдээ” гэдэг нь мэдээллийн найдвартай байдлыг бууруулж буй утга учиргүй тэс хөндлөн зүйл ба мэдээний төрөл зүйлүүдийн тухай ойлголтыг урвуулан ашигласан ажээ. Би *disinformation*-хуурамч мэдээлэл, *misinformation*-хуудуутай мэдээлэл, *malinformation*-дэгс мэдээлэл гэж орчуулсан.

- *Хуурамч мэдээлэл* бол хувь хүн, нийгмийн бүлгүүд, байгууллага, улс оронд хор хохирол учруулахын тулд урьдчилан төлөвлөж зохиосон худал мэдээлэл;
- *Хуудуутай мэдээлэл* бол худал мэдээлэл гэхдээ хувь хүн, нийгмийн бүлгүүд, байгууллага, улс оронд хор хохирол учруулах санаа зорилго агуулж, зохиогоогүй;
- *Дэгс мэдээлэл* бол жинхэнэ байдалд үндэслэсэн гэхдээ хувь хүн, нийгмийн бүлгүүд, байгууллага эсвэл улс оронд хор хохирол учруулахын тулд ашигладаг мэдээлэл.

Мэдээллийн эдгээр төрлийн уялдаа холбоог авч үзвэл хуурамч ба хуудуутай мэдээлэл хоёул худал, нэг нь санаатай, нөгөө нь санамсаргүй үйлдэл. Хуурамч мэдээлэл, дэгс мэдээлэл хоёр нь хор хохирол учруулах сэдэлтэй байна. Хүнээ дээдэлдэг ардчилсан улс оронд хүний эрхэм чанар, нэр төр, алдар хүнд, нэр хүндийг хамгаалдаг. Хэн ч хэнийг ч гүтгэж болохгүй. Харин олон улсын эрх зүйд алдар хүнд хүнд гутаахыг гэмт хэрэг гэж үзэх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд цагдан

хяналт болдог, эрүүгийн ийм хуулийг эрх баригч, эрх мэдэлтнүүд өөрсдийн зорилгод урвуулан ашиглах боломж олгодог гэж үздэг тул иргэн хоорондын маргаан гэж үзэн Иргэний хуулиар шийддэг.

Эцэст нь НҮБ, ЕХ-ны дүрмээр *public figure* буюу нийгмийн алдартнуудыг шүүмжлэлд өртөмтгий бүлэг учир хүлээцтэй хандах, төрийн байгууллагуудыг нэр хүндэд нь халдсан гэх үндэслэлээр иргэн, сэтгүүлчтэй заргалдахгүй байхыг зөвлөдөг ба ардчилсан улс орнууд үүнийг дотоодынхоо хуулиар зохицуулдаг. Нийгмийн алдартнуудыг хүсэл зоригоороо эсвэл хувь заяагаар алдартан бологсод гэж ангилдаг. Хүсэл зоригоороо алдартан бологсдыг сонгогдсон эрх мэдэлтэн, улс төрч, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчид, урлаг, спортын одод, мөн телевизийн хөтлөгчид, тохиолдлоор алдартан бологсод гэж ангилдаг бол хаан, хатан хааны гэр бүлийнхэн хувь заяагаар алдартан болдог. Эдгээр хүмүүс олон нийтийн анхаарлын төвд, тэдний хяналтад байдаг. Энэ бүлгийн шүүмжлэлд хүлээцтэй, тэвчээртэй хандах асуудлыг Эрүүгийн хуулийн тайлбарт тусгаснаас Төрийн албаны эсвэл ашиг сонирхлын хуулиар зохицуулах боломжтой санагддаг.

Судалгааны тухайд Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 19 дүгээр зүйл “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”, 20 дугаар зүйл “Дайныг сурталчлах, ялгаварлан гадуурхах, хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хуулиар хориглох” хоёрыг тодотговол зүгээр байна. Мөн Хүний эрхийн хорооны 34 тоот ерөнхий тайлбарыг ч дурдах хэрэгтэй.

Хэвлэлийн Хүрээлэнгийн гүйцэтгэх захирал М.Мөнхмандах

Судалгааны дүгнэлт мэдээлэл сайн, сонирхолтой байна. Хэвлэл мэдээллийн салбарт төдийлөн сайн ойлголтогүй байдаг нэр томьёо, эрх зүйн тайлбарыг тодорхой болгож өгсөн нь хэрэгтэй байлаа. Судалгаатай холбогдуулан хоёр асуулт байна.

Нэгдүгээрт, Эрүүгийн хуульд нэр төрд халдсан илт худал мэдээллийг “олон нийтэд тараасан бол” гэж орсон байгаа. “Олон нийтэд тараах” тухай ойлголтыг задалж харсан уу, судалсан тайлбарласан зүйл

судалгаандаа оруулсан уу? Миний санаж байгаагаар нэлээн дээр үед Улсын Дээд Шүүхийн тайлбараар “олон нийтэд тараах” гэдэг нь нэг ба түүнээс дээш хүнд мэдээлэл дамжуулахыг хэлнэ гэж тодорхойлсон байсан. Өөрөөр хэлбэл, хоёр хүн хоорондоо, дундуур нь заавал медиа орохгүйгээр харилцаж, мэдээлэл солилцсон нь олон нийтэд тараасан болох уу?

Хоёрдугаарт, зорилгогүйгээр, санамсаргүйгээр буюу субъектив шинжгүйгээр худал мэдээлэл тараасан тохиолдолд Эрүүгийн хууль биш Иргэний эсхүл Зөрчлийн хуулиар шийдвэрлэх нь зөв гэсэн зүйл сонссон. Энэ хэр оновчтой вэ? Орчин үеийн медиа онцлогийг харгалзах шаардлагатай. Ялангуяа фэйсбүк дээр *misinformation* дамжуулж байгаа хүмүүс нь өөрсдөө юмаа мэдэхгүйгээр дам дамжуулаад хэрэгт орох боломжтой болгоод байгаа юм биш үү. Үндсэн хуулиар олгосон үг хэлэх эрх чөлөөг дэмжинэ гэсэнтэй зөрчилдөх үү, үгүй юу?

Бас Цэлмэг хуульч Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэгт нэр хүндэд халдахтай холбоотой зохицуулалт байгаа, гэтэл худал мэдээлэл нь олон нийтэд аюул занал учруулахтай холбоотой асуудал учир 2-р бүлэг руу оруулах нь зүйтэй гэж тайлбарлалаа. Энэ эргээд та нарын дүгнэлттэй зөрчилдөөд байгаа юм биш үү. Өөрөөр хэлбэл, “худал мэдээлэл тараах” тухай заалтыг 13-р бүлэгт байх эсвэл 2-р бүлэгт байх, нааш цааш хөдөлгөх тухай яриад байна уу. *Misinfomation*-ий хувьд хор хохирол учруулах санаа агуулаагүй, мэдэхгүйгээр мэдээлэл дамжуулсан байхад Эрүүгийн хуулиар авч үзэх нь Д.Оросоо хуульчийн ярьсантай зөрчилдөж байгаа санагдаж байна.

Гол ээдрээтэй юм бол хэн нэгэн эхлээд ямар нэгэн худал мэдээллийг тараалаа гэж бодоход дараагийн хоёр дахь, гурав дахь, зуу дахь иргэн худал гэдгийг мэдэхгүйгээр шэйрлэчихсэн байна. Тэгээд түгээчихсэн бол бусдад дамжуулчихсан болно. Гэтэл тэр хүн өөрөө ямар нэг сэдэл байхгүй буюу зориудаар, ямар нэгэн байдлаар гутаах, нэр хүндэд халдах зорилго агуулаагүй. Гэхдээ дамжуулчихсан уу гэвэл дамжуулчихсан. Тэгэхээр одоо нөгөө асуудлыг шийдэхийн тулд жишээлбэл, тэр анхлан тараасан хүнээс гадна нөгөө дамжуулсан баахан хүмүүс хэрэгт орох уу, үгүй юу гэдэг асуудалд хариулт хэрэгтэй байна.

Судлаач Д.Оросоо

Ер нь худал мэдээлэл бол олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой гэж Цэлмэг доктор хэлсэн. Эрүүгийн хуульд ч байгаа. Өөрөөр хэлбэл, террор хийх, зэвсэгт ажиллагаа, хорлон сүйтгэх зэрэг төрлийн худал мэдээлэлтэй холбоотой олон нийтийн аюулгүй байдлын асуудлыг Эрүүгийн хуулийн тусдаа заалтаар зохицуулж байгаа. Дайн, гэмт хэргийн шинжтэй худал мэдээллийн асуудал манай эрүүгийн хуулиар хамгаалагдаад, террор хорлон сүйтгэх гэсэн худал мэдээлэл нь эрүүгийн хуулийнхаа тэр заалтад л байж байх ёстой. Гэтэл худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэрэг “нэр төр” гэдэг асуудал дээрээ төвлөрөхгүй, үндсэндээ олон нийтийн аюулгүй байдал гэдэг шинж чанарыг бас давхар оруулж ирээд, өргөн хүрээтэй болгоод байна гэж хардаад байгаа хэрэг юм. Хууль санаачлагч худал мэдээлэл тараах нь нийгэмд аюултай байна гэж үзэж байгаа бол олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт тэр асуудал нь байгаа гэдгийг анхаарах шаардлагатай. Тусдаа заалт нь байж байхад заавал энэ гэмт хэрэг рүү оруулж ирэх шаардлагагүй гэж харж байна. Ер нь бол энэ гэмт хэрэгт түрүүн ярьсан нэр төрийг гүтгэх, худал мэдээлэл тараах, доромжлох бүгдийг базаад хийчихсэн. Тэгээд энэ нь маш том “сав” болчихсон учраас өргөн хүрээтэй болчихсон.

Зөрчлийн тухай хууль, Иргэний хуулиар зохицуулах ёстой гэдэг дээр бид юу гэж харж байна гэхээр аливаа эрх зүйн асуудал ямар нэг хуулиар зохицуулагдах шаардлагатай. Хүний нэр төр, алдар хүндэд халдчихлаа, миний нэр төрийг гутаачихлаа, худал мэдээлэл тараачихлаа гээд иргэн хүн гомдол гаргаад явахад ямар нэг хуулиар хамгаалагдсан байх ёстой л доо. Иргэний хуульд бол хуулийн заалт нь байж байгаа. Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээсээ болоод хүний нэр хүндийг гутаах юм бол Иргэний хуулиар нөгөө гэм хорын хохирол, хариуцлагаа хүлээх л асуудал болж байгаа юм.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, доктор О.Мөнхсайхан

Чухал сэдвээр судалгаа хийж, энэ асуудалд анхаарч байгаа явдалд талархаж байна. Шинэ хуулийн орчин бүрдчихсэн байгаа үед хэрэгжилтийг судалж, ярьж хэлэлцэж байгаа нь тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх олон хувилбарыг сонгох буюу хууль

өөрчлөхгүйгээр шүүхийн практикаар эсхүл тайлбарлах замаар засах уу, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай юу гэдгийг харахад чухал гэж бодож байна. Хувь судлаачийн байр суурь бол гүтгэлгийг Эрүүгийн хуулиар зохицуулаад дэмий гэж үздэг. Сая зарим судлаач хэлж байна. Жишээлбэл, 2020 онд 258 хүнийг энэ зүйлээр шалгаж байгаа, 24 нь шүүх рүү шилжсэн. Эндээс арав хүрэхгүй хувь нь л шүүхээр шийдэгдэж байна, өмнө нь ч бас л тийм байсан. 2002 оны хууль үйлчилж байхад дандаа эрх мэдэлтнүүд л өөрийгөө хамгаалахын тулд ашигладаг, сэтгүүлчдэд эрүү үүсгэдэг, улмаар айдас үүсгэдэг байсан. Гэтэл Эрүүгийн хуулиас хасаад Зөрчлийн тухай хууль руу оруултал байдлыг улам дордуулсан. Хууль сахиулагч цагдаа нь хоёр сая төгрөгөөр торгоод байдаг болсон.

Манайд гурван янзын эрх зүйн орчин үйлчилсэн байгаа байхгүй юу. 2002 оны хууль нэг хэсэг үйлчилсэн, тэгээд Зөрчлийн тухай хууль, одоогийн хууль байна. Энэ гурван эрх зүйн орчноос миний хувьд одоогийнх нь маш олон талаар өмнөхөөсөө дээр. Нэгдүгээрт, хорих, баривчлах ялыг байхгүй болгосон. 2002 оны хууль тийм ялтай байсан. Тэгэхээр энэ нь НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбарт туссан “Гүтгэлгийг гэмт хэрэгт тооцох, эрүүгийн хуулиар зохицуулахаас аль болох татгалз, гэмт хэрэгт тооцсон ч хорих, баривчлах ялаар ерөөсөө шийтгэж болохгүй, шийтгэх нь Пактын 19 дүгээр зүйлийг зөрчсөн гэж үзнэ” гэсэнд нийцэж байна. Тэгэхээр энэ бол дэвшил юм. Хоёрдугаарт, ял нь бас харьцангуй хөнгөн байгаа. Яагаад гэхээр өмнө нь 2002 оны хууль үйлчилж байхад 5,5-14 сая төгрөгөөр торгодог байсан. Тэр үед би шүүхийн шийдвэрүүдийг бүгдийг нь авч судалж, харьцуулж байсан. Зөрчлийн тухай хуулиар бол хоёр саяар автоматаар торгодог байсан. Үүнтэй харьцуулахад 450-1300 нэгж гэдэг бол харьцангуй бага дүн юм, энэ нь бол дэвшил гэж бодож байгаа. Гуравдугаарт, хүндрүүлэх бүрэлдэхүүнгүй байгаа, өмнө нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараавал бүр хүндрүүлдэг байсан. Дөрөвдүгээрт, цагдаа биш, шүүх шийдэж байгаа нь чухал дэвшил болсон.

Дээрээс нь доромжлохыг гэмт хэргээс хассан нь сайн зүйл юм. Бид үүнийг буцааж Эрүүгийн хуульд оруулах шаардлагагүй гэдэг дээр Х.Наранжаргалтай санал нэг байна. Тэгэхээр одоогийн Эрүүгийн хуулийн энэ заалтын гарчиг агуулгаасаа зөрсөн. 13.14 дүгээр зүйлийн

агуулга, гэмт хэргийн шинжийг харах юм бол ерөнхийдөө гүтгэлгийн асуудал байгаа, гэхдээ гарчгийг судлаачдын хэлснээр хэт өргөн хүрээнд өгчихсөн. Б.Энхбаяр гишүүний санаачилж байгаа төсөл дээр ч гарчгийг зөв болгож, агуулгатай нь нийцүүлэх асуудал байсан.

Эрүүгийн хуулийн 13.14-т субъектив талыг орхигдуулсан, тиймээс зорилготойгоор хүний нэр төр, алдар хүндийг гутаах илт худал мэдээлэл тараасан гэж оруулъя гэж судлаачид үзжээ. Тийм томъёолол өмнө байсан ч одоогийнхоос нэг их ялгаагүй байсан. Яг үнэхээр тийм зорилготой юу, үгүй юу гэдгийг намайг 2011-2017 оны шүүхийн шийдвэрийг шүүж үзэж байхад бол нотолдоггүй, яг одоогийнхтой адил байсан. Тэгэхээр түрүүн судалгаанд дурдагдаад байгаа Нью Йорк Таймс, Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүд байна. Санаатай гэдэг нь зорилготой гэдгээс илүү тодорхой ойлголт юм. Тэр *actual malice* гэдэг чинь өөрөө юу вэ гэхээр тэр мэдээллийг худал гэдгийг мэдсээр байж тараасныг хэлээд байгаа байхгүй юу. Тиймээс “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан, илт худал мэдээллийг мэдсээр байж олон нийтэд тараасан” гээд томъёолол оруулах саналтай байгаа юм. Тэгэхээр прокурор зөвхөн худал гэдгийг нотлоод зогсохгүй, нэр төр, алдар хүндэд халдсан гэдгийг нотлох, цаашлаад худал гэж мэдэж байсан гэдгийг нотлох шаардлагатай болно. Үүнийг Архангай аймгийн Засаг даргын кэйс дээр тайлбарлая. Архангайн Засаг дарга 15 удаа гадаад явсан гээд бичтэл бодит байдалд 12 явсан гээд сэтгүүлчийг торгочихсон. Тэгэхээр яг хэдэн удаа явсныг мэдээгүй байсан тул мэдсээр байж тараасан гэдэг томъёолол орвол сэтгүүлчид хариуцлага хүлээлгэхгүй байж болохоор байгаа юм.

УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Б.Энхбаяр

Яг цаг үеэ олсон сэдвээр ярилцаж байгаад баярлалаа. Үүнийг зохион байгуулсан Нээлттэй Нийгэм Форумыг судалгааны санаачлагч гэж ойлгож байгаа. Судалгаа хийсэн Д.Оросоо, Ц.Цэлмэг болон бусад хуульчдадаа баярлалаа. Би сайн судалгаа болсон байна гэж дүгнэж байгаа. Энэ нь Б.Жаргалмаа, М.Оюунчимэг гишүүдтэй хамтраад өргөн барьчихсан, 9 сарын сүүлээр буюу яг хуулийн төслийг хэлэлцэхийн өмнө нь болж байгаа гэдгээрээ чухал ач холбогдолтой байна. Энэ

судалгааны дүнг УИХ-ын нийт гишүүн ялангуяа УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны гишүүдэд дэлгэрэнгүй хүргүүлж болох болов уу? Тэгвэл их чухал байна. Энэ хуулийн төслийг гурван сарын сүүлээр УИХ-д албан ёсоор өргөн барьсан. Хаврын чуулганы хэлэлцүүлгээс хойш нь тавьсан. Учир нь миний хувьд цаг нь болоогүй, бэлтгэлгүй байна гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, хэлэлцвэл уначих өндөр эрсдэлтэй байсан. Сонгууль болж байсан, улс төрийн бусад зүйлийн халууралтай үеэр улс төрийн албан тушаалтнууд, төрийн байгууллагууд эрүүгийн журмаар гомдол гаргахгүй гэдэг ийм хууль УИХ-аар хэлэлцэгдэх нь нэлээн өндөр эрсдэлтэй байсан юм. Тэгэхээр одоо нэлээн тохиромжтой цаг нь болж байгаа юм болов уу. Энэ судалгааны үр дүн өргөн хүрээг хамарсан, тэр дотроо хуулийн хэрэгжилт, хаана асуудал үүсэж байна гэдгийг нэлээн цогцоор харахыг хүссэн, зорьсон судалгааны дүн гарч ирсэн байна. Миний харж байгаагаар УИХ-ын чуулган 10 дугаар сарын 1-нд эхлээд энэ хуулийг хэлэлцэх эсэх асуудал чуулганаар нэг хоёр долоо хоногийн дотор орох болов уу. Өөрөөр хэлбэл, хөтөлбөр, дараалал харахаар 10 сарын хоёр дахь долоо хоногт орох юм болов уу гэж хараад байгаа. Тэгэхээр тэр үед шийдвэр гаргагчдын түвшинд анзаарагдаж байгаа гол хүчин зүйл нь “Энэ улс төрч хүмүүс яахаараа гомдол гаргахгүй байдаг юм бэ”, бидний гомдох эрхийг хязгаарлаад байна, биднийг гүтгэж болно гэсэн хуулийн төсөл өргөн барьчихлаа гэж ойлгоод байгаа юм. Ер нь бол шуудхан хэлэхэд биднийг гүтгэж болно гэдэг ийм хуулийг ер нь дэмжих ёстой юм уу, үгүй юм уу гэдэг нэг ийм ойлголт байгаад байна. Тэгэхээр энэ ойлголтыг зөвшүүлж, ойлголт өгөхөд энэ судалгааны дүн чухал нөлөөтэй.

Хоёрдугаарт, хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ хуулийн нарийн заалтуудын талаар хангалттай сайн ойлголттой байдаггүй. Тэгэхээр иргэдийн мэдэх эрхийг хангадаг чухал заалтууд нэг үгнээс хамаарсан байдаг гэдгийг наана нь 9 сарын сүүлээр өгвөл, энэ хуулийн асуудал УИХ-ын түвшинд хэлэлцэх эсэх шийдэгдэх үед хэвлэл мэдээллийн байгууллагынхан тодорхой хэмжээний ойлголттой болчихсон байвал их зүгээр байна. Энд хууль санаачлагчдын хувьд хамтарч ажиллахад бэлэн байна гэдгийг илэрхийлж байна. Хэвлэл мэдээллийнхэн, сэтгүүлчид, түүнчлэн шийдвэр гаргагчдад магадгүй УИХ-ын Хууль зүйн байнгын хороо ийм хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулаад, энэ хийгдсэн судалгааны дүнгүүдийг танилцуулбал ойлголт өгөхөд

нэлээн их үр дүнтэй байх юм байна гэж харлаа. Тэгээд хэлэлцэх эсэх нь шийдэгдсэний дараа мэдээж нэг их удаан уягдаад байхгүй байх. Ганц зүйл анги хөндөж байгаа учраас ер нь шуурхай ойлголт авсан дээр нь шуурхай явчих боломж үүсэх болов уу.

Улс төрийн хувьд бас их чухал нэг зүйл байна. Энэ долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд энэ мэдэгдлүүдийг анзаарсан байх. Тэр нь авлигатай тэмцэх. Одоо ийм комисс байгуулж байгаа. Энэ хүрээнд их анхаарч байгаа чиглэл нь шүтэл үлээгчийн эрх зүйн байдлыг сайжруулах асуудал. Энэ асуудлыг Ерөнхий сайд өөрөө ярьж байгаа. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайд, Хууль зүйн сайд мөн энэ чиглэлээр улс төрийн манлайлал үзүүлээд, тодорхой ойлголт авчихсан байгаа үе нь өөрөө их тохиромжтой байна. Засгийн газрын, тэр дотроо Ерөнхий сайдын бодлого, үйл ажиллагаатай, бидний оруулсан хуулийн төслүүд уялдаж явах юм байна гэж би хараад байгаа юм. Тийм учраас яг одоо тохиромжтой юм болов уу гээд 10 сарын эхээр оруулахаар явж байгаа. Энэ цаг үетэй судалгааны дүн уялдаж байгаад их баяртай байна.

Энэ хуулийг санаачлах явцад Улсын Дээд Шүүх “Төрийн байгууллага болон улс төрд нөлөө бүхий этгээд албаны бүрэн эрхтэй нь холбогдуулж хардаж сэрдсэн үйлдэл дээр гомдол гаргахгүй” гэдэг тайлбарт “Энэ бол Үндсэн хууль зөрчиж байна” гэсэн санал өгсөн. Тэгэхээр жирийн алба, төрийн нэг байгууллага биш Улсын Дээд Шүүх ийм санал өгчхөөд байгаа учраас энэ дээр судалгаа хийсэн Д.Оросоо хуульч, Ц.Цэлмэг хуульч нар анхаарал хандуулж өгөөрэй. Би бол хууль санаачлагчийн хувьд энэ нь Үндсэн хууль зөрчөөгүй ээ. Эрүүгийн хуулиар албан тушаалтнуудад ялгавар, ялгамжтай ял шийтгэл ногдуулдаг зөндөө тохиолдол байдаг. Улс төрд нөлөө бүхий этгээд ялангуяа албан тушаалын гэмт хэрэг дээр бусад иргэнээс илүү хүнд шийтгэл авч байгаа. Энэ болгонд Үндсэн хууль зөрчиж байна гэж үздэггүй. Тэгэхээр Дээд шүүх, дараа нь энэ хуулийг хэрэглэх учир ялангуяа Улсын Дээд Шүүх албан ёсны тайлбаруудаа гаргадаг эрх нь нээгдчихсэн тул энэ асуудлаар нэлээн идэвхтэй ажиллах байх. Хуулийн хэлэлцүүлгийн шатанд ч гэсэн хууль тогтоогчдын нэг анхаардаг асуудал бол дээд шүүхийн санал байдаг. Дээд шүүх “Үндсэн хууль зөрчиж байна, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна гэдэг заалтыг зөрчиж байна, улс төрд

нөлөө бүхий этгээд хүн учраас гомдол гаргадаг байх ёстой, энэ эрхийг хааж болохгүй” гэдэг санал өгсөн байгаа нь цаашдаа энэ зүйлийг хэлэлцэх, батлах бүх шатанд нэлээн чухал санал юм. Тийм учраас яагаад Америкийн Дээд шүүх эдгээр албан тушаалтныг илүү хүлээцтэй байх тухай шийдсэнийг анхаарах шаардлагатай. Нөгөө талаас янз бүрийн ялгамжтай зохицуулалт, эрхийн хязгаарлалт угаасаа байдаг. Наад зах нь зарим төрийн албан хаагчийг ажил хаяж болохгүй гэж хязгаарладаг, энэ тохиолдолд улс төрийн эрхийг нь хааж байна гэж Цэц үздэггүй шүү дээ. Энэ мэт албан үүргийн онцлогтой нь холбогдуулаад хязгаарлалт байдаг гэж би үзээд байгаа юм. Судалгааны хүрээнд үүнийг анхаарч үзээсэй гэсэн саналтай байна.

Би хууль санаачлахдаа хоёр санааг энэ заалтын дагуу хөгжих байх гэж бодсон юм. Нэгдүгээрт, нэр төр, албаны нэр хүнд гэж ялгаатай ойлголт байна. Энэ хоёр хэллэгт цаашдаа тайлбар орчихвол улс төрчийн хувийн нэр хүндэд халдсан бол гомдол гаргах боломжтой. Харин албаны бүрэн эрхээ хэрэгжүүлсэнтэй холбоотой хардлага үүссэн бол гомдол гаргахгүй гэж үзсэн. Хувь хүнийхээ хувьд нийгмийн ёс суртахуун зөрчсөн асуудал бол гомдол гаргах эрхтэй. Энэ нь хууль шүүхийн өмнө эрх тэгш байх асуудлыг бүхэлд нь хөндсөн гэж би ойлгохгүй байгаа. Зөвхөн албаны бүрэн эрхийнхээ хугацаанд албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлсэнтэй холбогдуулж үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үү, авлига хахууль авсан уу, албан тушаалын байдлаа урвуулсан уу, эрх мэдлээ хэтрүүлсэн үү, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан уу гэдэг асуудал дээр гомдол гаргахгүй шүү гэж яриад байгаа хэрэг. Нөгөө талаас энэ нотлоход хүнд асуудал, эрэн сурвалжлах сэтгүүлзүйгээр хайж олж авдаг мэдээлэл. Гэтэл эх сурвалжаа нууцлах эрхийг бас хөндөөд байгаа. Тийм учраас энэ асуудал дээр гомдол гаргахгүй гээд заачихвал цаашдаа шүүхийн тайлбар, практикаар хувь хүний нэр төр, албаны нэр хүнд гэдэг ялгаатай ойлголт нь хууль зүйн хувьд зөв, ялгамжтай байдлаар тайлбарлагдаж хэрэглэгдэх боломж гарах юм болов уу гэж бодоод байна.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Т.Золбоо

Нэлээн цаг хөдөлмөр шаардсан, чухал судалгаа болжээ гэж дүгнэж болохоор байна. Судалгааны ажлын сэдвийг худал мэдээлэл тараах гэмт хэргийн практик, шүүхээс шийдвэрлэж байгаа байдал, илт худал мэдээлэл гэх эрүүгийн хуульд заасан тодорхой хэм хэмжээг ярьж байна гэж харж байна. Тэгэхээр энэ нь иргэн ч бай, эрүү ч бай, захиргаа ч бай, ер нь бол бүгдээрээ хэм хэмжээний онолын бүтцүүдийн дагуу явж байгаа. Тэр дундаа эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ, ялангуяа энэ тусгай ангийн хэм хэмжээ буюу бидний бүрэлдэхүүн гэж яриад байдаг шинжлэх ухааны нэр томъёогоороо бол тусгай ангийн хэм хэмжээ, нөгөө ерөнхий ангийнхаа хэм хэмжээнд зангидагдаж явж байдаг. Д.Оросоо өмгөөлөгч, Ц.Цэлмэг доктор хоёр объектив тал дээр ер нь нэлээн чухал санаа өгсөн байна, субъектив тал жоохон тэнцвэртэй байдлаа алдчихжээ гэж санагдлаа. За дээр нь доктор Мөнхсайхан багш, мэдсээр байж худал мэдээлэл тараасан гээд томъёолчихвол яасан юм бэ гэсэн санаа хэлж байна.

Тэгэхээр бид Эрүүгийн хуулийн хэм хэмжээг судлах, үүнийг өөрчлөх санал гаргавал дээрх бүтцийн дагуу явах ёстой. Яагаад гэвэл эрүүгийн хууль ерөнхий болон тусгай хоёр хэсгээс бүрдэж байна шүү дээ. Тэгэхээр тусгай анги ерөнхий ангийнхаа хүрээн дотор явна гэсэн үг. Ерөнхий анги дотор бас судлаачид харвал гэмт хэргийн тодорхойлолт дээр байгаа “Болгоомжгүй үйлдэл эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэгт тооцно” гэсэн нэг зүйл 2.2.2 дээр байгаа шүү. Эрх зүйн техник буюу стандарт нь нэг ижил болохоор эш татахад Германы хууль болох байх гэж бодож байна. Гэхдээ ерөнхий ангид ийм хэм хэмжээ хийчихсэн учраас. Хэрвээ бид болгоомжгүй гэмт хэрэг гэж үзэх юм бол түүнийг заавал Эрүүгийн хуулийн тусгай ангид онцгойлон заана гэж байгаа юм. Эрүүгийн хуулийн концепц нь ч гэсэн анх угаасаа ингэж явж байсан. Тэгэхээр энийг юу гэж ойлгох, задлах ёстой юм гэхээр хэрвээ болгоомжгүй хэрэг байх юм бол хууль дүрэм, журам, захиргааны актаар оногдуулсан үүргээ болгоомжгүйгээр зөрчөөд гэдэг диспозицийн буюу шинжүүдийг нэмнэ. Хэрвээ тийм шинж байхгүй бол энийг шууд санаатай гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл, энэ 10.1 хэм хэмжээний шинжтэй ижил зарчим юм. 10.1 бол хүнийг албал 8-15 жил л гэж байгаа шүү дээ. Бас санаатай гэж бичээгүй байхгүй

юу, хүнийг алах юм бол гэж байгаа юм. Гэтэл 16 дээр болгоомжгүй гээд биччихсэн байгаа. Тэгэхээр бас эргээд энд эрүүгийн хуулийн тусгай анги чинь өөрөө нэг үйлдлийн объектив болон субъектив шинжүүдийг хууль зүйн шинжийн дагуу хэлбэржүүлээд хуульчилчихсан хэм хэмжээ л байгаа шүү дээ.

Энд бас “тараасан” гэдэг үйлдлийг хэлж байна. Тэгэхлээр нөгөө тараасан гэдэг маань ардаа санаатай үйлдлийг илэрхийлэх нэр томьёо байж болно. Эрүүгийн эрх зүйд болгоомжгүй үйлдлийг ялангуяа мэдээлэл тараах, эд баримт алдах дээр жишээ нь гээгдүүлэх, үрэгдүүлэх гэж томьёолдог. Субъектив талыг хуульд арай бага оруулчихжээ гэж дүгнэлт хийх нь зөв үү эсвэл хууль хэрэглээгээ өөрөө практик түвшиндээ ингэж ойлгож задалж чадахгүй байна аа гэж хэлэх нь бас зөв юм болов уу. Энэ хоёр дээр анхаарлаа хувааж хандуулах нь зөв байх гэж бодож байна.

Нэр томьёоны, хууль хэрэглээний, практик хэрэглээний гээд гурван асуудал байна. Нэр томьёоны асуудал эрүүгийн эрх зүйд бол нөхцөлдсөн шинжтэй. Тэгэхлээр энэ дээр бид бас үгийн шууд утгыг авч үзээд байж арай болохгүй байх. Жишээлбэл, би өнөөдөр ээждээ алуулна аа гэдгийг, одоо эрүүгийн эрх зүйн дагуу бол “Манай ээж өнөөдөр орой намайг алах юм байна” гэж бид шууд ойлгохгүй шүү дээ. Яг тэрэнтэй ижилхэн энэ мэдэх, мэдсэн гэдэг бол ялангуяа болгоомжгүй хэрэг, болгоомжлолгүй ангилал руугаа уначих вий дээ. Хэрвээ мэдэх гэдэг үг нэмчихвэл. Санаатай гэвэл хүсэж байж үйлдэх тухай ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр нөгөө илүү хэм хэмжээгээ задлах арга зүйн тал дээрээ бид анхаарах юм уу эсвэл. Ер нь эрүүгийн хуульд тодорхой тусгах, ялангуяа энэ эрүүгийн хуулийн тусгай ангийг судалж байгаад, дээр нь диспозиц шинж нэмэх тухай юм ярьж байгаа шүү дээ. Объектив шинж үү, эсвэл субъектив шинж нэмэх үү? Тараасан үйлдлээ тойрсон шинжүүдийн алийг нь нэмэх юм гэдэг асуудал. Хэрвээ энэ хэм хэмжээг оролдох бол объектив шинж нэмэх үү, субъектив шинж нэмэх үү? Тэгээд энэ нь эргээд эрх зүйн онолын хэм хэмжээний онолтойгоо уялдана. Тэгэхээр бас ингээд шууд үгийн утгаар хараад энэ нь байхгүй болчихжээ, тэр нь байхгүй болчихож гэж дүгнэхээсээ илүүтэйгээр хэм хэмжээний бүтэцтэйгээ уялдуулах ёстой. Тэгээд дараа нь эрүүгийн эрх зүй рүүгээ холбовол ямар юм бэ гэсэн санал байна. Хэрвээ тэгвэл энэ судалгаа илүү

практиктай бөгөөд дээр нь шинжлэх ухааны, ялангуяа энэ эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг задлах, ойлголттой уялдах байх гэж бодож байна.

Дээр нь бас Б.Энхбаяр гишүүн тодорхой санал хэлбэрээр явуулбал хууль тогтоох байгууллага ажиллахад бэлэн байна гэдгээ илэрхийлж байна. Эрүүгийн хуульд бас мэр сэр алдаанууд байдаг. Хууль энэ чигээрээ батлагдчих юм бол процесс дээр очоод хэрэглэхэд маш төвөгтэй болдог. Тайлбар дээр бичих, тайлбарлаж бичих, түүнийг практик ажилтнууд яаж задалж хэрэглэх үү, процессын хуультайгаа яаж уялдуулах юм, нотлох баримтаа яаж цуглуулах юм гээд. Дараа нь иргэн, эрүү, захиргааны зөрчлөөсөө яаж ялгагдах юм гээд явчихдаг. Тэгэхээр энэ судалгаан дээр хэрвээ нэмэх шаардлагатай гэж үзвэл ойролцоо төрлийн үйлдлээс яаж ялгах уу, эрүүгийн эрх зүйн аспект буюу эрүүгийн эрх зүйн ухагдахуун болохынхоо хувьд объектив, субъектив талаараа яаж ялгагдах уу гэдэг байна. Хэрвээ бид энэ шинжийг нэмбэл яг энэ шинжтэй нь хамааруулж байгаа юм аа, энэ нь практикт ингэж одоо нотлогдон гарч процессынхоо хуультайгаа уялдах ёстой юм аа гээд нэгд, эрүүгийн эрх зүйн аспект талаас нь цогц байдлаар авч үзэх; хоёрт нь нэр томьёо талаасаа хэрэг хэр оновчтой вэ гээд явах нь зөв байх. Гэхдээ эрүүгийн нэр томьёо нь нөхцөлдсөн учир ухагдахуунаар явдаг шүү гэдгээ байнга санах хэрэгтэй.

Судалгаа үр нөлөөтэй болжээ. Практикт худал мэдээлэл тараах асуудал, ялангуяа социал орчин хөгжсөн өнөө үед эрх зүйн зохицуулалт, эрүүгийн эрх зүйн хамгаалалтыг бүрдүүлэх нь мэдээж хэрэг шаардлагатай байгаа. Өөрөөр хэлбэл, нийгэмд үнэхээр хэрэгцээ шаардлагатай судалгаа гэж харж байна. Тиймээс цогц байдлаар хараад шинжлэх ухааны арга зүйтэй жоохон уялдуулбал зүгээр юм болов уу гэсэн санал хэлье.

ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ГЭХ ОЙЛГОЛТЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

ISBN 978-9919-9812-0-4



9 789919 981204